

**“ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2023 оны 01 сарын 31

Сайншанд

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн
<b>НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
1	1.1.1. Коронавирус “Ковид-19” халдварт цар тахал, шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэд, олон нийт болон аж ахуйн нэгж, байгууллагуудад зохион байгуулж, халдвараас сэргийлэх мэдлэг, дадлыг дээшлүүлэх	2022	ААНБ-ын тоо  хамраг-дах иргэдийн тоо	200  16000	ОНТ	<p>Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгөх “24 цагийн утас”, “Call center” төвийг байгуулж, нийт 3019 дуудлага хүлээн авснаас 30.4% нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл, 65.9% нь гэрийн тусгаарлалт, эмчилгээнд байгаа иргэдийн биеийн байдлын тандалт, дархлаажуулалтын зөвлөгөө, 3% нь эмнэлгийн тусламж шаардлагатай иргэнийг өрхийн Эрүүл мэндийн төвтэй холбох, 0.7% нь талархал байсан.</p> <p>Ковид-19 халдварын эсрэг “Комирнэти” вакцины 5-11 настай хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэх зорилгоор 5 удаагийн сургалтад 35 байгууллагын 108 ажилчид, эцэг эхийн төлөөллийг хамруулан, 9 төрлийн 455 зөвлөмжийг түгээж, “Хүүхдийн дархлаажуулалт–Бяцхан үрсээ халдварт өвчнөөс сэргийлье” өдөрлөгийг зохион байгуулж 400 гаруй хүүхэд, эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэсэн.</p> <p>Орон нутгийн телевизүүд, “Өнөөгийн Дорноговь”, “Ялалт” сонинтой гэрээ байгуулж</p>

						<p>нийт 529 төрлийн мэдээ мэдээлэл /цаг үеийн үйл явдлын мэдээ мэдээлэл–202, “Эмч зөвлөж байна”, “Охид хөвгүүдийн цаг” буланд–44, хэвлэлийн бага хурал - 6, шторк-277/ нэвтрүүлж, иргэдийг цаг үеийн мэдээ мэдээлэл, зөвлөмжөөр шуурхай хангасан.</p> <p>Ковид-19 халдвар, түүний хувилбаруудаас сэргийлэх мэдээлэл сурталчилгааг иргэдэд тасралтгүй хийж, 1492 удаагийн сургалт, сурталчилгаанд давхардсан тоогоор 204 байгууллага, аж ахуйн нэгжийн 20134 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 91 удаагийн сургалт, 4421 хүнээр, цахим хуудсуудаар 11008 төрлийн мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг, видео зөвлөмж байршуулж, 327 951 хандалт авсан нь өмнөх оны мөн үеэс 697 мэдээлэл, 8197 хандалтаар тус тус нэмэгдсэн. Дээрх арга хэмжээний үр дүнд иргэдийн халдвараас сэргийлэх тухай ойлголт, мэдлэг, хандлага нэмэгдэж, халдварын тохиолдлын тоо урьд оноос 8859-өөр буурсан.</p>	
2		<p>2. Коронавирус “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, сэргээх тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах</p>	2022	Сэргээх тунд хамраг-далтын хувь	Сэргээх тунд хамраг-далтын хувийг нэмэгдүүлсэн байх.	ОНТ	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/01 тушаалын дагуу коронавируст халдварын эсрэг нэмэлт тунгийн дархлаажуулалтыг эрчимжүүлэх 1 сарын аяныг зохион байгуулж, НҮБ-ын Хүүхдийн сангаас 10,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, сумдын дархлаажуулалтын ажлын хэсэгт цахимаар 2 удаа арга зүйн зөвлөгөө өгч, 40 удаагийн сургалтаар 1759 хүнд дархлаажуулалтын талаарх мэдээлэл өгсөн. Дархлаажуулалтын байнгын, түр, явуулын 34 цэгт 39 эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж, 830 хүнийг коронавирусын эсрэг</p>

						<p>вакцинд шинээр хамруулсан. НҮБ, НЭМҮТ-ийн 1.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэх” аяныг өрнүүлэн вакцинаар дархлаажуулахын ач холбогдлын талаар мэдлэг олгох 5 удаагийн сургалтад 35 байгууллагын 108 ажилтан, эцэг эхийн төлөөлөл, олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулж, 2 төрлийн 255 ширхэг гарын авлага тараасан.</p> <p>“Хүүхдийн дархлаажуулалт–Бяцхан үрсээ халдварт өвчнөөс сэргийлье” өдөрлөг зохион байгуулж, 24 байгууллагын 400 гаруй хүүхэд, эцэг эхчүүдэд Ковид-19 халдвараас сэргийлэх 5-11 насны хүүхдийн вакцины ач холбогдлын талаар мэдээлэл түгээсэн. Төр хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжлийн эмч нар үзлэг хийж, зөвлөгөө өгч, 9 төрлийн 300 гарын авлага тарааж, эмийн сангууд 400 хүүхдийг амин дэмээр хангаж, 200 хүүхдэд хүчилтөрөгчийн коктейлиор үнэгүй үйлчилсэн.</p> <p>Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнууд 7 төрлийн 230 гарын авлагыг олон нийтийн газарт байршуулан, айл өрхөөр тарааж, орон нутгийн 12000 хэрэглэгчдэд "Масс" мессежээр дархлаажуулалтын талаар мэдээлэл, зөвлөмжийг илгээж, телевизээр хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө-8, шторк-9-ийг нэвтрүүлсэн. Дархлаажуулалтыг эрчимжүүлснээр 12-оос дээш насны зорилтот бүлгийн хүн амын 1-р тунгийн хамралт 96,4%, 2-р тун 92,9%, 3-р тун</p>
--	--	--	--	--	--	---

							55.9%-д хүрч халдварын тархалт, хүндрэл, эмнэлэгт хэвтэлт буурсан.
3		3. Зорилтот бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулах	2022	Вакцинд хамраг-дах хүүхдийн тоо	1000	ОНТ	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/609, 629 дүгээр захирамжаар орон нутгийн төсвийн 29,2 сая төгрөгийн санхүүжилтээр 06 сартайгаас 5 хүртэлх насны эмзэг бүлгийн, өвчлөмтгий 700 хүүхдийг сонгон томуугийн эсрэг Солонгос улсын “Грийн кросс” үйлдвэрийн 4 цэнт вакцинаар дархлаажуулсан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/512 дугаар тушаалаар 11060 хүн тун Солонгос улсын “Грийн кросс” үйлдвэрийн томуугийн эсрэг 4 цент вакциныг татан авч, 9038 хүн хамруулснаас 4390 буюу 48.6%-ийг 01-12 хүүхэд эзэлж, зорилтот бүлгийн хүн амын 81,7%-ийг дархлаажуулалтад хамруулсан.</p>
4	1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	4. Халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангаж, хүний нөөцийг чадавхжуулах, хамгаалах хувцас хэрэглэл, эм барааны нөөцийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлэх	2022	Сургалтын тоо  хүний тоо  Зарцуулах төсөв	15,  400  500.0	ОНТ	<p>Шинэ хувилбарын дэгдэлт, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, нөөц бүрдүүлэх, хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг ханган, 16 удаагийн танхимын болон цахим сургалт зохион байгуулж, 198 эмнэлгийн мэргэжилтэн, дархлаажуулалтын сургалтад 19 эрүүл мэндийн байгууллагын давхардсан тоогоор 235 эмч мэргэжилтнийг тус тус хамруулж, эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтад 100% хамруулсан. “Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх” нь бүсийн зөвлөлдөх уулзалт, “Халдварын сэргийлэлт хяналтын алба, багуудын үйл ажиллагааг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулж, бүсийн 8 аймгийн 40 мэргэжилтэн, орон</p>

						<p>нутгийн төрийн өмчит 20 эрүүл мэндийн байгууллагын 50 хүнийг хамруулан коронавируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ, эмнэлгийн халдвар хамгааллын талаарх мэдлэгийг дээшлүүлж, нийт 17,8 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Эрүүл мэндийн яамны 3 удаагийн ханган нийлүүлэлтээр 5 нэр төрлийн 37000 ширхэг 439,5 сая төгрөгийн эм, 11 нэр төрлийн 313000 ширхэг 439,5 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгслийг татан авч, 20 эрүүл мэндийн байгууллагад хуваарилж, нөөцийг нэмэгдүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагууд Коронавируст халдвар, томуу, томуу төст өвчний үед эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал, хомсдолгүй ажиллаж, эмийн 2 сарын нөөц, хамгаалах хувцас хэрэгслийн 3-5 сарын нөөцийг бүрдүүлж, нөөцийн burtgel.mohs.mn программд оруулж, хяналтыг тогтмол хийсэн. Эрүүл мэндийн газрыг 165.2 мян ширхэг хамгаалах хувцас хэрэгсэл, 9.4 мян ширхэг ариутгал, халдваргүйжилтын бодис, 19.2 мян ширхэг эмээр ханган, 2-3 сарын нөөцийг бүрдүүлсэн.</p>
5		5. Замын-Үүд хилийн боомтод зоонозын өвчин судлалын тандалтын нэгж байгуулах бэлтгэл хангах	2022	Зохион байгуулах ажлын тоо	1	<p>УТ</p> <p>ОНТ</p> <p>Замын-Үүд сумын хилийн боомтод Зоонозын өвчин судлалын тандалтын нэгж байгуулах чиглэлээр Зооноз өвчин судлалын үндэсний төвд 2, Эрүүл мэндийн яаманд 1 албан бичгийг тус тус хүргүүлж, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторийг түшиглэн тандалтын нэгж байгуулах, хүний нөөцийг бэлтгэж, зоонозын чиглэлээр мэргэшүүлэх чиглэл, зөвлөмж авч,</p>

						эмч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, хүний нөөцийг бэлтгэх зорилгоор ерөнхий мэргэжлийн 5 эмчийг 6 сарын сургалтад /3 сар-танхим, 3-сар цахим/ хамруулж, талбарын тархвар судлаачаар бэлтгэхээр шийдвэрлэн, хүний нөөцийн мэдээлэл, нэрсийг хүргүүлсэн. Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн молекулбиологийн лабораторийн үйл ажиллагааг тогтворжуулах, хүний нөөцийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн молекулбиологийн лабораторийн эмч 1, лаборант 1 туршлага солилцохоор 2022 оны 8 дугаар сард тус суманд ажиллаж, мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн.
6	6. Сайншанд, Замын-Үүд сумын молекулбиологийн лабораторийн үйл ажиллагааг тогтворжуулах, хүний нөөцийн мэдлэг чадварыг дээшлүүлэх	2022	Сургах хүний нөөцийн тоо  байнгын үйл ажил-лагааны хувь	12  100	ОНТ	<p>Аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгүүдийн "Молекул биологийн лаборатори"-ийн хүний нөөцийн тогтвортой байдлыг ханган, танхимын болон цахим сургалтад 9 эмч мэргэжилтэн, ажлын байрны дадлагажих сургалтад 2 лаборантыг тус тус хамруулан чадавхжуулсан.</p> <p>Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нэгдсэн лабораторийн баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, 12 эмч мэргэжилтнүүдийг ажлын байрны сургалтад хамруулж, арга зүйгээр хангаснаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн молекулбиологийн лаборатори нь бүсийн лавлагаа лаборатори болох боломжтой болсон.</p> <p>Энэ онд 2 Нэгдсэн эмнэлэг нийт 107,8 сая төгрөгийн лабораторийн оношлуурыг</p>

						худалдан авч, нөөцийг тасралтгүй бүрдүүлж, 10111 ширхэг оношлуурын нөөцтэй, нийт 13725 PCR шинжилгээ хийж, 7650 халдварыг эрт илрүүлэн, халдварын голомтыг тухай бүрд нь цомхотгон ажилласан.
Хоёр. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
7	2.1.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрт илрүүлгийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	7. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлж, эрүүл мэндийн зөв мэдлэг дадлыг төлөвшүүлэн халдварт бус өвчнийг эрт илрүүлэг цогц үзлэгийг сумдад зохион байгуулах	2022	ЭМСС-д хамрагдах хүний тоо  Үзлэгт хамрагдах хүний тоо	39300  74000	ОНТ  “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 6105 удаагийн аян, өдөрлөг, уралдаан тэмцээн, сургалт, сурталчилгааг зохион байгуулж давхардсан тоогоор 179 байгууллагын 94895 албан хаагчид, иргэд хамрагдаж, 1567 төрлийн 88696 зөвлөмж тараан, цахимд 10164 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулж, 124683 хандалт авсан. Арга хэмжээний хүрээнд аймгийн аварга шалгаруулах “Ажлын байр–Эрүүл мэндийн дасгал”, “Хийн дасгал”, “Эмч спорт”, “Флаш моб”, “Цахим алхалт” зэрэг тэмцээн уралдаан, аян, зохион байгуулж, дасгал хөдөлгөөнийг сурталчилснаар хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг хүний тоо 13295 болж өмнөх оны мөн үеэс 4279-р өсч, биеийн жингээ бууруулах зэрэг хандлага нэмэгдсэн. 10.8 сая төгрөгийг шийдвэрлэж "Шүдний эмчийн явуулын үзлэг"-ийг хойд бүсийн 5 суманд зохион байгуулж, 908 хүн хамрагдсаны 73.7% нь 0-18 насны хүүхэд, 26.2% нь 19-аас дээш насныхан байсан. Үзлэгээр 836 шүдний эмгэг илрүүлэн, 1369 шүдэнд эмчилгээ хийж, 706 хүнийг /84.4%/ эрүүлжүүлсэн нь 2020 оны явуулын үзлэгтэй харьцуулахад эрүүлжүүлэлт 0.9%-иар нэмэгдсэн. “Эрүүл мэнд-Эрхэм баялаг” уриан

						<p>дор “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ”-г 5 сарын 1-нээс эхлүүлж, Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэгт “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулж, 1,8 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хийсэн.</p> <p>Эрт илрүүлэг үзлэгээр 2681 удаагийн сургалт сурталчилгаанд 77021 хүнийг хамруулж, 34 төрлийн 47956 ширхэг зөвлөмж мэдээллийг түгээсэн. Үзлэгт хамрагдвал зохих хүн амын 26.3% хамрагдаж, эмгэг өөрчлөлттэй 5269 хүнийг илрүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд нийт 94254 хүнийг хамруулсан нь зорилтот түвшнээс 2,3 дахин их, үзлэгт хамрагдсан иргэдийн тоо 73134 байгаа нь зорилтот түвшний 98,8 % байна. Хүүхдийн өвчлөлийн 89.1%-ийг амны хөндийн өвчлөл эзэлж, насанд хүрэгчдээс 62 хавдрын урьтал өвчин, 16 хавдрын сэжигтэй тохиолдол илэрч 15 нь эрт үедээ эмчлэгдсэн. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 93.4% байна.</p>
8	8. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, сүрьеэ, БЗДХ-ын идэвхтэй тандалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	2022	Төлөвлө-гөөний хэрэгжилтийн хувь  Тандал-тад хамрагдах хүний тоо	95  7000	ОН	<p>“Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалтын тогтогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт бүсийн зөвлөлдөх уулзалтыг ДЭМБ-ын 16,9 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 8 аймгийн 32 эмч, тархвар судлаач нар хамрагдаж, халдварын сэргийлэлт, тандалтын мэдлэгээ дээшлүүлж харилцан туршлага солилцсон. Эрүүл мэндийн салбарт 17.0 сая төгрөгийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, хангалтыг 100% -д хүрсэн. НҮБ-ын 9,0 сая төгрөгөөр вакцины</p>



						<p>агуулахыг засварлаж, 48,1 сая төгрөгийн 18 компьютер олгон, дархлаажуулалтын цахим программын ашиглалтыг сайжруулсан. Дээрх ажлын үр дүнд товллын дархлаажуулалтын хамралт 89,1% хүрсэн. В вирус тээгч эхээс төрсөн 34 нярайд В гепатитийн эсрэг иммуноглобулин эмчилгээг хийж, эхээс урагт халдвар дамжихаас сэргийлсэн.</p> <p>Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлж 12-аас дээш насны хүн амын хамралт 1-р тунд 96,4%, 2-р тунд 92,9%, 3-р тунд 55.9%-д хүрч халдварын тархалт, хүндрэл, эмнэлэгт хэвтэлт буурсан.</p> <p>Сүрьеэгийн идэвхтэй тандалтыг эрчимжүүлж эрт илрүүлэг үзлэгт 3497 хүнийг, Глобаль сангийн 7,2 сая төгрөгийн санхүүжилтээр 7 суманд зохион байгуулсан эрт илрүүлэг үзлэгт 1360 хүн хамруулж, 13 сумын 184 хүний 213 цэрийг тээвэрлэж нийт 6 шинэ сүрьеэг, 6647 хүнийг БЗДХ-ын идэвхтэй тандалтанд хамруулж, 339 шинэ өвчлөл илрүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд нийт халдварт өвчний 93,7%-ийг эзлэх “Ковид19”-ын халдвар өмнөх оны мөн үеэс 11674-р буурч, нийт 9232 халдварт өвчин бүртгэгдсэн 10000 хүн амд 1288.1 болж өмнөх оноос 1641,7-оор буурсан.</p>
9	9. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, зайн оношилгоо, зөвлөгөөг өргөжүүлж, эх нярайн нэн	2022	Төлөв-лөгөөний хэрэг-жилтийн хувь  Эх нярайн нэн	98	ОНТ	<p>Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд 540 сургалтад 14860 жирэмсэн эхчүүд, гэр бүлийн гишүүдийг хамруулж, 529 төрлийн 16328 сурталчилгааны материал тарааж, эх барих эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө, мэдээллийг пэйж хуудсууд ашиглан 729</p>

		шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх		шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь	75	<p>эрүүл мэндийн зөвлөгөөг өгч, давхардсан тоогоор 31719 хүн хандалт авсан.</p> <p>Эх, нярайн зайн оношилгооны хуваарийг гаргаж, нэгдсэн эмнэлгүүд Realtime-аар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй холбогдон, маш хүнд, онош тодруулах шаардлагатай 4 эмэгтэй, 16 нярайд зөвлөгөө авч, нөхөн үржихүйн насны 163 эмэгтэйг багажийн шинжилгээнд хамруулж, эмгэг өөрчлөлттэй 24 тохиолдлын оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Нийт 129 жирэмсэн эхэд зөвлөгөө өгсний 16 нь эрсдэлтэй, 27 нь хөгжлийн бэрхшээлтэй эхчүүд байсан. “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулснаар эх нярай, хүүхдийн эндэгдлийг бууруулах” төслийг Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг дээр хэрэгжүүлж, 46,0 сая төгрөгийн нэн шаардлагатай 12 төрлийн 26 ширхэг, улсын төсвийн 53,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 4 төрлийн 5 тоног төхөөрөмж, сумын Эрүүл мэндийн төвүүдэд 4,4 сая төгрөгийн ургийн доплер тус тус нийлүүлсэн.</p> <p>Дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд 2 нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эх нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 90%-д хүрсэн. Шинээр 2 эх барих эмэгтэйчүүдийн эмчийг бэлтгэн ажиллуулж, мэргэжил дээшлүүлэх, олгох сургалтад 3 эх барихын эмчийг, 5 удаагийн богино хугацааны сургалтад 69 эмч мэргэжилтнийг хамруулан, мэдлэг чадварыг дээшлүүлж, “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга</p>
--	--	---	--	--	----	---

						хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 98,3% хангаснаар 1000 амьд төрөлтөд ногдох перинаталь эндэгдэл 4.8 промилльд хүрч урьд оны мөн үеэс 0.7-оор буурсан.
10	10. “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж хими эмчилгээ, хавдрын эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	2022	Төлөвлө-гөөний биелэл-тийн хувь  , Хими эмчил-гээнд хамрагдах хүний тоо  Хавдрын эрт илрүү-гийн хувь	92  75  60	ОНТ	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хавдрын тасгийг 2 их эмчтэй, 10 ортой болгон өргөжүүлж, полихими эмчилгээг нэвтрүүлж, хавдрын эмч сувилагчийг ХСҮТ дээр туршлага судлуулж, хөнгөвчлөх эмчилгээнд 235, хими эмчилгээнд 123 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс хөнгөвчлөх эмчилгээ 50 хүнээр, хими эмчилгээ 137 хүнээр тус тус өсч, тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. Хавдрын 3 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 28263 хүнийг хамруулж, дундаж хамралт 67.4% байгаа нь өмнөх оны мөн үеэс 4,3%-аар өсч, шинээр умайн хүзүүний хорт хавдар 1-ийг эрт үед нь илрүүлсэн. “Хүүхдийн хавдрын өвчлөл, хяналт” сэдвээр хавдрын эмчийн арга зүйн зөвлөгөө, сургалт, орон нутгийн телевизээр “Хавдрын өвчлөлийн эрт илрүүлэг, хими туяа эмчилгээ” нэвтрүүлэг хийж, эмнэлгийн байгууллагууд 152 удаагийн сургалт сурталчилгаанд 3895 хүнийг хамруулан, 38 төрлийн 2857 зөвлөмж сэрэмжлүүлэг, цахимаар 56 төрлийн мэдээлэл түгээж, 11654 хандалт авсан нь өмнөх оноос 295 хандалтаар өсч иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 10.5 сая төгрөгийн санхүүжилтээр Хавдар судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг урьж, хавдрын эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулан, 1045 хүнийг</p>

						<p>хамруулан, шинээр 9 хавдар илрүүлсний 5 нь эрт үедээ оношлогдож, сэжигтэй 70 өвчлөл, биопси 9, цитологи шинжилгээ 97 хийж, дээд шатлалд 18 хүнийг илгээн, эмэгтэйчүүдийн 1 мэс засал хийж, 150 эмч нарт сургалт зохион байгуулж мэдлэгийг нэмэгдүүлсэн.</p> <p>Үзлэгийн явцад нийт 603 хүнээс авсан хавдрын эрсдэлийн асуумж судалгаагаар хавдрын анхдагч эрсдэлттэй хүн 40.1%, хавдрын эрсдэлтэй хүн 45.4% байсан. "Хавдрын эсрэг" арга хэмжээний хүрээнд шинээр 112 хавдар бүртгэгдэж, үүнээс 34.0% нь эрт үедээ оношлогдож, хавдрын эмчийн хяналтад 467 хүн байгаагийн 42% нь 5-аас дээш жил амьдарч байгаа нь хавдар эрт шатандаа оношлогдсоноор амьдрах чадвар тодорхой хэмжээгээр уртасч байгаа илтгэж байна.</p>	
11	11. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, оношилгоо, эмчилгээний хамралтыг сайжруулах, элэгний В вирустэй эхээс төрсөн нярайн эмчилгээнд В гепатитын иммуноглобулиныг нэвтрүүлэх	2022	<p>Төлөвлө-гөөний хэрэг-жилтийн хувь</p> <p>Оношил-гооны хамраг-далтын хувь</p> <p>гепатитын иммуноглобулин хийлгэх нярайн тоо</p>	80	40	ОНТ	<p>"Элэг бүтэн Монгол" арга хэмжээг 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн, 202 удаагийн сургалт сурталчилгаанд 4152 хүн хамруулж, 199 төрлийн мэдээллийг цахимд байршуулан 4876 хандалт авч, 125 төрлийн 2993 ширхэг гарын авлага тараасан.</p> <p>Гепатитын В, С вирусын халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд зорилтот бүлгийн 16684 хүнийг хамруулж, архаг В вирусын халдвартай 163 хүн, архаг С вирусийн халдвартай 197 хүнийг тус тус илрүүлсэн.</p> <p>Вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээг 141 хүнд хийлгэж, вирусийн эсрэг эмийг 46 эмийн сангаар худалдаалан 508 хүн үнийн хөнгөлөлтөөр 21.2 сая төгрөгийн В, С вирусийн эсрэг эмийг авсан. Энэ онд</p>

					25		элэгний цочмог гепатитын 6 тохиолдол бүртгэгдэн, 10 000 хүн амд 0.8 ногдож, өмнөх оны мөн үеэс 0.2 тохиолдлоор өссөн ба элэгний В вирустэй эхээс төрсөн 34 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, хяналтад авснаар хүүхдүүдэд халдвар илрээгүй.
12		12. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	2022	Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувь  УС үзлэгт хамрагдах эрэгтэйчүү-дийн тоо, байгууллагын тоо  Эрүүлжих залуучуудын тоо, хувь	75  700/20  183/90	ОНТ	<p>“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжье”, “Малчдын эрүүл мэндийг дэмжье”, “Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлье” аянуудыг зохион байгуулсан. Эрэгтэйчүүд олноор ажилладаг албан байгууллагуудад 155 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж, 4447 эрэгтэйг хамруулан, 70 төрлийн 2507 ширхэг зөвлөмж мэдээллийг цаасан хэлбэрээр тарааж, эрт илрүүлэг үзлэгт 6015 эрчүүдийг хамруулсан.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлэг улсын төсвийн 151,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бөөр, шээс дамжуулах доод замын дурангийн мэс заслын 9 нэр төрлийн 10ш төхөөрөмж авч, Урологийн 1 эмчийг шинээр бэлтгэн, дурангийн мэс заслаар мэргэшүүлэн, нэгдүгээр эмнэлгийн эмч мэргэжилтнүүдтэй ажлын байранд хамтарсан мэс заслыг хийж, мэс заслын эмчилгээнд 21 хүнийг хамруулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/203, А/222 дугаар захирамжаар 1-р ээлжийн цэрэг татлагын үзлэгт нийт 6 сумын 380 залуу хамрагдсанаас эрүүл мэндээр тэнцээгүй 76 хүнийг эмчлэн эрүүлжүүлсэн. Цэргийн төв</p>

						<p>эмнэлгийн Эрүүл мэндийн магадлан нягтлах үзлэгийн баг орон нутагт ажиллаж, эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанд тэнцэхгүй 111 хүний асуудлыг шийдвэрлэсэн. 2-р ээлжинд нийт 9 сумын 1027 эрэгтэй үзлэгт орсноос 316 нь дотор, мэс засал, гэмтэл, чих хамар хоолой, нүд, сэтгэц, мэдрэл, арьс харшил, сүрьеэ, шүдний эмгэг, жин өндрийн үзүүлэлтээр тэнцээгүй байсан.</p> <p>Цэргийн албанд тэнцээгүй залуучуудыг харьяа эмнэлгийн хяналтад авч, 42 залууг эрүүлжүүлсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал хандлага өөрчлөгдөн, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 28579 эрэгтэйг хамруулж, эрчүүдийн дундах элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 10 000 хүн амд 0,8 болж урьд оны мөн үеэс 0,8%-аар буурсан.</p>
13	<p>13. “Эрүүл шүд” хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дадлыг олгох сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэлтийг нэмэгдүүлэх</p>	2022	<p>Төлөвлө-гөөний хэрэгжил-тийн хувь</p> <p>Үзлэгт хам-рагдах хүний тоо</p> <p>эрүүлжүү-лэлтийн хувь</p>	<p>95</p> <p>6700</p>	ОНТ	<p>“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн, “Би эрүүл шүдтэй” дэвжээ тэмцээнийг 10 суманд, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” нээлттэй хаалганы өдөрлөгийг 9 суманд зохион байгуулж, 3750 хүүхэд, эцэг эхчүүдийн мэдлэгийг нэмэгдүүлсэн.</p> <p>Амны хөндийн эрүүл ахуйн зөв мэдлэг дадал төлөвшүүлэх 434 сургалт, сурталчилгаанд 18376 хүүхэд, эцэг эхчүүдийг хамруулж, цахим орчинд 299 төрлийн мэдээлэл байршуулан 12715 хүний хандалт авч, 272 төрлийн 10255 ширхэг зөвлөмж, санамж, гарын авлага тараасан. Нэгдсэн</p>

					70	<p>эмнэлгүүдийн шүдний эмчийн орон тоог нэмэгдүүлэн нийт 7 эмчтэй болсноор тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, хүлээгдэл чирэгдэл буурсан.</p> <p>Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн 10 шүдний эмнэлэг, кабинетаар 0-18 насны нийт 8813 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, шүдний өвчтэй 7851 хүүхдийг илрүүлэн, 4445 хүүхэд буюу 56.6%-ийг эрүүлжүүлсэн. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 10.8 сая төгрөгийн санхүүжилтээр шүдний эмчийн явуулын үзлэгийг хойд бүсийн 5 суманд зохион байгуулан, 908 хүн хамруулснаас 670 /73.7%/нь 0-18 насны хүүхэд, 238 /26.2%/нь 19-аас дээш насныхан байсан. Шүдний өвчтэй 836 хүнийг илрүүлэн 1369 шүдэнд эмчилгээ хийж, 706 хүнийг /84.4%/ эрүүлжүүлсэн нь өмнөх үзлэгтэй харьцуулахад эрүүлжүүлэлтийг 0.9%-аар нэмэгдүүлсэн.</p> <p>“Театрт тавтай морил-2” аяны хүрээнд Хүүхэлдэйн театрын албан ёсны эрхтэйгээр “Миний хөөрхөн шүдний аялал” хүүхэлдэйн жүжгийг цэцэрлэгийн ахлах болон бэлтгэл ангийн 430 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн 250 хүүхэд, нийт 680 гаруй хүүхдэд үзүүлсэн.</p> <p>“Эрүүл шүдтэй хүүхдийн байгууллага, хамт олон” шалгаруулах болзолт уралдааны удирдамжийг хүүхдийн байгууллагуудад хүргүүлж, 6 хүүхдийн байгууллага, 40 анги хамт олонтой хамтран ажиллаж, 20 байгууллагын 35 албан хаагч, 8 байгууллагын</p>
--	--	--	--	--	----	---

							19 бүлэгт явцын дэмжлэгт хяналт хийж арга зүйн зөвлөгөөг өгсөн. "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 95,6%-д хүрч, зорилтот түвшинд хүрсэн.
14		14. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн эмч мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлж, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, хүчилтөрөгчийн үйлдвэртэй болох	2022	ЯТТТ-ийн хангал-тын хувь  Сурах хүний тоо	95  20	ОНТ	<p>Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад 210,8 сая төгрөгийн өртөг бүхий яаралтай тусламжийн 181 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлж, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт анхан шатанд 90%, лавлагаа шатлалд 97%-д хүрч, өмнөх оноос 2.5%-аар нэмэгдсэн.</p> <p>Улсын төсвийн 561,7 сая төгрөгийн өртөг бүхий хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр суурилагдаж, орон нутгийн төсвийн 116,4 сая төгрөгийн санхүүжилтээр хүчилтөрөгчийн дотор шугамыг бүх тасагт оруулан угсарч, эмчилгээ үйлчилгээнд ашиглаж эхэлсэн. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/814 тушаалаар шинэчлэгдсэн "Яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалтыг үзүүлэх журам"-ыг ЭМБ-уудад хүргүүлэн, самбар, гарын авлагыг шинэчлүүлэн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасагтай хамтран 2 сумын эрүүл мэндийн төвд "Мэс засал, гэмтлийн үеийн яаралтай тусламжийн бэлэн байдал, анхны тусламж үзүүлэх нь" ажлын байрны сургалтыг зохион байгуулж, 20 эмч мэргэжилтэн хамрагдан, гардан үйлдэл, дадлага хийснээр анхан шатны эмч нарын ур чадвар нэмэгдэж, яаралтай тусламжийн чанарт ахиц гарсан. "Ковид-19" халдварын эмнэлзүй, яаралтай тусламжийн эрэмбэлэн</p>



						ангилалт, хүчилтөрөгч эмчилгээ” сургалтын орон нутгийн 2 сургагч багшийг бэлтгэж, Японы Хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр сум, өрхийн 34 эмч, "Осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц сургалт"-ыг зохион байгуулж, эрүүл мэнд, онцгой, цагдаа зэрэг чиг үүргийн 6 байгууллагын 130 хүнийг хамруулж, мэдлэг чадвар олгосон.
15	2.1.2. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бий болгоно.	15. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах санамжийг байгуулж, мэргэжлийн арга зүйгээр хангах, коронавируст халдвар болон эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр дэмжих	2022	ЭМД-ын санхүүжилттэй эмнэлэг/-орны тоо-  Үйлчлүү-лэх хүний тоо	3/70  37731	ОНТ  Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах, чадавхжуулах уулзалт зөвлөгөөнийг 1 дүгээр улиралд зохион байгуулж, хувийн хэвшлийн 27 эмнэлэг, мэргэжлийн салбар холбоодтой хамтран ажиллах гэрээг байгуулан, тусгай зөвшөөрөл авсан чиглэлийн дагуу үйл ажиллагааг явуулах, орчин үеийн шинэ техник, технологийг нэвтрүүлэх, халдвар хамгааллын дэглэм чанд мөрдөх, тусгай хог хаягдал, ариутгал халдваргүйтгэлийн нэгдсэн менежментийг нэвтрүүлэх, "Covid-19" халдварын үед хамтран ажиллах, дайчлагдах, мэдээ тайланг цаг хугацаанд нь өгч хэвшүүлэх чиглэлүүдийг нэг бүрчлэн тусган, хэрэгжилтэд хяналт тавин, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага 107 ажиллаж байгаагаас ортой хувийн эмнэлэг 3, 46 эмийн сан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан, нийт 957.6 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан. Хувийн хэвшлийн ЭМБ-ууд амбулаторийн

						<p>үзлэгт 23994 лабораторийн оношилгоог 16463, эмнэлэгт ковидын дараах хам шинжтэй болон бусад оношоор 2574 хүнийг хэвтүүлж, 20511 ор хоног ашигласан нь өмнөх оны мөн үеэс амбулаторийн үзлэг 5893 хүнээр, хэвтүүлэн эмчлүүлэх хүний тоо 346 хүнээр тус тус нэмэгдсэн.</p> <p>Төрийн өмчийн эмнэлгүүдэд хийгдэхгүй байгаа тархины судасны доплер, 4D ЭХО, шүдний гажиг засал, бамбайн дааврын шинжилгээ, өтгөнд хеликобактер илрүүлэх шинжилгээ зэрэг олон лаборатори дүрс оношилгоо, эмчилгээ үйлчилгээг үзүүлж, өндөр хөгжилтэй орны эмчилгээний бүтээгдэхүүнийг тусламж үйлчилгээндээ шинээр нэвтрүүлж, иргэдийн Улаанбаатар хотруу дээд шатлалын эмнэлэгт явах чирэгдлийг багасгаж, төрийн эмнэлгийн ачааллыг бууруулсан.</p>	
16		16. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх	2022	Лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	60	ОНТ	<p>Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр 17 сумын лаборантуудыг дадлагад суурилсан орон нутгийн сургалтад хамруулсан. Сайншанд сумын Зүүнбаян багийн Эрүүл мэндийн төв, Хатанбулаг, Өргөн сумын эрүүл мэндийн төв, Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төвүүд Мобайл технологийн төхөөрөмжтэй, Өргөн сумын эрүүл мэндийн төв, Зүүнбаян багийн эрүүл мэндийн төв шээс, биохимийн хагас автомат анализатортай тус тус болон, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар 5 нэр төрлийн 6 ширхэг 39.3 сая төгрөгийн</p>

							лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, анхан шатанд лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт 62 %-д хүрсэн нь урьд оноос 2,1%-аар нэмэгдсэн.
17		17. Иргэдийг орон нутагтаа эмчлүүлэх эдийн засгийн хүндрэлээс сэргийлэх зорилгоор лавлагаа шатлалд гуравдах шатлалд хийгддэг болон өндөр өртөгтэй эмчилгээ үйлчилгээг нэвтрүүлэх, ажлын байрны дадлага сургалтыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн төвүүдтэй хамтран ажиллах	2022	Орон нутагт хийгдэх эмчилгээ-ний төрөл, хүний тоо-	3/40	ОНТ	<p>Эрүүл мэндийн газар, аймгийн болон Замын Үүдийн Нэгдсэн эмнэлгээс холбогдох мэргэжлийн 18 хүний бүрэлдэхүүнтэй баг Хавдар судлалын үндэсний төвд очиж чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрхэн нэвтрүүлсэн талаар туршлага судалж, орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан.</p> <p>Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн асуумж судалгааг 887 хүнд хийж, “Цусны даралт ихсэлт, түүний эрсдэлт хүчин зүйл, хүндрэлээс сэргийлэх нь” сургалтыг 24 байгууллагын 60 эмч, мэргэжилтэнд зохион байгуулав. “Зүрх мартахгүй” төслийн баг Айраг, Иххэт сумдын 36 хүнд үзлэг хийж, 1 том хүн, 4 хүүхдийн мэс засал эмчилгээний асуудлыг шуурхай шийдвэрлэсэн.</p> <p>Хавдар судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн 8 эмчийн бүрэлдэхүүнтэй баг 3 хоногийн хугацаанд 1045 хүнд үзлэг оношилгоо хийж, шинэ хавдар 9, хавдрын сэжигтэй тохиодол 70, биопсийн шинжилгээ-9, хэвлийн тодосгогчтой КТГ 10, цитологи 97 авч, дээд шатлалд 18 хүнийг илгээсэн. Цэргийн төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдтэй хамтран, орон нутагт нийт 500 гаруй хүнд үзлэг шинжилгээ хийн, өвчний учир цэрэгт явах боломжгүй 111 залуусыг магадлан нягтлах үзлэг хийж, асуудлыг</p>

							шийдвэрлэсэн. Улсын нэг, хоёрдугаар төв эмнэлгүүдтэй хамтран 12 мэс засал хийж, орон нутагт хийгддэггүй 3 мэс заслыг зааж сурган, тухайн мэс заслыг шинээр нэвтрүүлэх боломжтой болсон.
18	2.1.3. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	18. Аймгийн нэгдсэн эмнэлгийн сүлжээний серверийг өргөтгөж цахимжуулалтыг эрчимжүүлэх	2022	Нэмэг-дүүлэх тоног төхөөрөмжийн тоо	2	ОНТ	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төв серверийн компьютерийн Hard, Ram, Pac серверийг шинэчилж, хурд хүчин чадлыг нэмэгдүүлэн, интернет, серверийн өргөтгөл хийхээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулан ажилласан. Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг нь 20,0 сая төгрөгөөр серверийн өргөтгөлийг хийж, Эрүүл мэндийг дэмжих төвийн шинэ тоног төхөөрөмж болон бусад төхөөрөмжүүдийг холбож үйл ажиллагааг тогтмолжуулсан. Эрүүл мэндийн байгууллагууд E-Health программыг хөгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн санг баяжуулан 511764 хүний мэдээллийг оруулсан.
19	эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	19. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлж иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, иргэд, байгууллагад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулах	2022	Цахим үйлчилгээний тоо сангийн мэдээллийн тоо	12 275000	ОНТ	Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн "Health.acc.hdc.gov.mn" цахим программыг шинээр нэвтрүүлж, магадлан итгэмжлэгдсэн 26 байгууллагын мэдээлэл, хугацаа сунгах хүсэлт, магадлан итгэмжлэлийн материалыг цахимаар илгээх, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулан ажилласнаар 12 байгууллага цахимаар хүсэлт, материалаа илгээж, магадлан итгэмжлэл амжилттай явагдсан. Нэгдсэн эмнэлгүүд E-health программын хөгжүүлэлтийг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллээс гадна шинээр урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн

						мэдээллийг бүртгэж, цахим мэдээллийн санд нийт 511764 хүний мэдээллийн сан үүсгэсэн. E-Mongolia цахим системд Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, сунгах 2 үйл ажиллагаа болон 2 нэгдсэн эмнэлэгт цаг авах болон цаг цуцлах зэрэг нийт 13 үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж, анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагуудад e-hospital программыг нэвтрүүлэн ашиглаж, 30362 иргэний эрүүл мэндийн мэдээллийг бүртгэн, сан бүрдүүлж ажилласан.
20	20. Анхан болон лавлагаа шатлалд явуулын болон алсын зайн тусламж үйлчилгээний цахим технологийг нэвтрүүлж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх	2022	Мобайл технологи нэвтрүүлэх АШЭМБ-ын тоо  Телемедицинээр зөвлөгөө авах хүний тоо -	10  180	ОНТ	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын алсын зайн оношилгооны чадавхийг нэмэгдүүлж, хөдөөгийн малчид иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр нийт 10 сум, 1 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологийг нэвтрүүлэн, оношилгоо хийх 49 эмч мэргэжилтнийг орон нутгийн сургалтад хамруулан чадавхжуулсан. Сумын эрүүл мэндийн төвүүдийн 76,9% нь мобайл технологитой болж, үлдсэн 3 сумдад ДЭМБ, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 2023 онд нэвтрүүлэхээр төлөвлөгдсөн.</p> <p>Мобайл үзлэгт хүн амын 36,1% буюу 5293 хүнийг хамруулан, 2318 шинжилгээ хийж, 319 өвчлөл шинээр илрүүлж, дээд шатлалд 192 хүн илгээн, 115 хүний эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Эрт үедээ байгаа хорт хавдар 8-ыг илрүүлж, зүрх судасны эмгэгтэй 38 хүнийг зайн оношилгооны дамжуулалтаар оношилж, 16 хүнийг арьсны төвтэй</p>

							холбогдож, эмчилгээг заалгаснаар хөдөөгийн малчид жилдээ нэг удаа оношилгоо шинжилгээг орон нутагтаа хийлгэх боломж бүрдсэн.
21	2.1.4. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ.	21. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлэх чиглэлээр шат дараалсан сургалтуудыг зохион байгуулах, санхүүжилтийн орлогын гүйцэтгэлд хяналт тавьж, нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2022	Гүйцэтгэлийн санхүүжилт авах ЭМБ-ын тоо  Орлогын гүйцэтгэлийн хувь	16  90	УТ ОНТ	<p>Эрүүл мэндийн байгууллагууд 2022 оноос эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах улсын төсвийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих санхүүжилтийн шинэчлэл хийгдэж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банкны төслийн шугамаар орон нутагт сургагч багш нар 2 дахь удаагаа ирж, лавлагаа шатлалын 2 эмнэлэг дээр 4 хоног ажлын байрны сургалтуудыг зохион байгуулж, орон нутгаас 8 хүн хамрагдсан. Орон нутагт 7 удаагийн арга зүйн сургалт хийж, анхан шатны 17 байгууллага, лавлагаа шатлалын 3 байгууллагын нийт 204 хүнийг хамруулан ЭМД-ын үндэсний зөвлөлийн 01, 02, 05, 12 дугаар тогтоолууд, дагалдах тушаал зааврууд, гүйцэтгэлийн санхүүжилт, эдийн засгийн тооцоолол, албан хаагчдын оролцооны чиглэлээр мэдээлэл өгч, чадавхжуулав.</p> <p>Эрүүл мэндийн салбарын 2022 онд 35,5 тэр бум төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, ЭМДҮЗ-ийн 1,2,4 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэн, жилийн эцэст санхүүжилтийн гүйцэтгэл 90,0%, анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүд нийт 32,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт авсан нь 2021 онтой харьцуулахад 4,2</p>

							тэрбум төгрөгөөр өссөн.
22		22. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын Эрүүл мэндийн даатгалын санхүүжилттэй тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2022	ЭМД-аар санхүүжих тусламж үйлчилгээ-ний нэр төрлийн тоо	25	УТ ОНТ	<p>Магадлан итгэмжлэгдсэн төрийн 20, хувийн хэвшлийн 3 эмнэлэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулж, 73316 хүнд эрүүл мэндийн 27 нэр төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэн, 18,8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оны мөн үеэс 1,3 тэрбумаар нэмэгдсэн.</p> <p>Хувийн хэвшлийн 42 эмийн сан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 11 дүгээр тогтоолын дагуу хөнгөлөлттэй эм олгож, 37438 хүнд эм зүйн тусламж үйлчилгээг хүргэсэн.</p>
23	2.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	23. Эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээ болон худалдан авах ажиллагааны хууль журмын хүрээнд зохион байгуулж, чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангуулан хяналт тавих	2022	Стандартын хэрэгжилтийн хувь	95	УТ ОНТ	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргын А/635 дугаар захирамжаар шилжүүлэн, Эрүүл мэндийн газрын даргын А/191, А/202 дугаар тушаалуудаар үнэлгээний хороог байгуулж, аймгийн болон Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2,9 тэрбум төгрөгийн 44 багц, сумын Эрүүл мэндийн төвүүдийн 279,0 сая төгрөгийн 29 багц бүхий нээлттэй тендерүүдийг цахимаар зарласан. Захиалагчийн шаардлагад нийцэж хамгийн сайн үнэлэгдсэн 29 байгууллагатай гэрээ байгуулан, хуваарийн дагуу татан авалтуудыг тогтмол хийж, тендерийн гүйцэтгэл Нэгдсэн эмнэлгүүдэд 88,2%, Сумын эрүүл мэндийн төвүүдэд 91,8%-тай байна. 15 эрүүл мэндийн байгууллага 1,5 тэрбум төгрөгийн худалдан авалт хийснээр, чанар стандартад нийцсэн</p>

							эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангагдаж эмийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилт 100% болсон.
24		24. Шинэчлэгдсэн цахим жорын программыг өргөжүүлж, хөнгөлөлттэй эмийн жор бичих эмчийн тоог нэмэгдүүлж эрүүл мэндийн даатгалын сангийн үнийн хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх	2022	Хөнгөлөлт-тэй эмээр үйлчлүүлэх хүний тоо  Жор бичих эмчийн тоо-	38000  85	УТ ОНТ	<p>Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 159 ерөнхий нэршлийн, 590 эм хөнгөлөлттэй олгогдохоор батлагдаж, иргэд хурууны хээгээ уншуулан харьяалал харгалзахгүйгээр бүх шатлалын эмнэлгүүдээр хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжтой болсон.</p> <p>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 71-ээс дээш насны иргэд, бусдын асаргаанд байдаг, уналт таталт, саажилттай иргэд хурууны хээ уншуулахгүй хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжийг бүрдүүлснээр эмийн хүртээмж нэмэгдсэн. Эрүүл мэндийн байгууллагууд ZK9500 загварын, иргэдийн хувийн мэдээлэл хадгалагддаггүй 186 ширхэг хурууны хээ уншигч төхөөрөмжтэй болж, төрийн өмчийн 19 эрүүл мэндийн байгууллагын 81 эмч хөнгөлөлттэй эм бичиж, 42 эмийн сан 45798 хүнд, 1,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилж, гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс 7.8%-аар өссөн.</p>
25	2.1.6. Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, хүний нөөцийн хангалтыг	25. Эмч, мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах гадаад, дотоодын албан болон албан бус сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх	2022	Сургал-тад хамрагдах хүний тоо	3550	УТ ОНТ	Сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 12 эмч эмнэлгийн мэргэжилтэнд 10,6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг тухайн байгууллагаас нь, мэргэшүүлэх сургалтад суралцаж ирсэн 8, суралцаж буй 5 эмчийн суралцах хугацаанд нь албан тушаалын үндсэн цалинг олгох зэргээр дэмжлэг үзүүлэн ажилласан. Төрийн албаны мэргэшүүлэх богино хугацааны



	нэмэгдүүлж, нөхцөл боломжоор хангана.					сургалтад 2, Лондонгийн CIPD их сургуульд 1 албан хаагч, магистрт 3 мэргэжилтэн суралцаж, клиникийн профессор 4, АШУҮИС-ийн АУ-ны магистр 2, Глобаль удирдагч дээд сургуулийн магистр зэргийг 14 мэргэжилтэн хамгаалж, 15 эмч мэргэжилтэн мэргэшлийн зэргээ ахиулсан. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 21, танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 3329, дотоодын сургалтад давхардсан тоогоор 804 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, нийт 4154 хүний мэдлэг чадварыг дээшлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 734 хүнээр нэмэгдсэн.
26	26. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, сум орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгох	2022	Хүний нөөцийн хангалтын хувь  Дэмжлэг үзүүлэх сумын тоо	94,  10	УТ ОНТ	Сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа 34 эмч мэргэжилтнийг төрийн албан хаагчийн орон сууцанд 100% үнэ төлбөргүйгээр амьдрах, 4 хүнд өвлийн идэшний 1.5 сая төгрөг, 17 хүнд мах хүнсний 1.8 сая төгрөг, 1 хүнд эзэмшлийн газар, 1 хүнд гэр авах 1,5 сая төгрөг, 23 өрхөд түлээ нүүрсний дэмжлэгийн 16,1 сая төгрөг, 12 эмч мэргэжилтний сургалтын төлбөрт 10,6 сая, төгрөг, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хөнгөлөлттэй болон бусад хэлбэрээр хамруулж 1,3 сая төгрөг, нийт 31,5 сая төгрөгийн дэмжлэг, 4 эмчийг малжуулах төсөлд хамруулсан нь өнгөрсөн онтой харьцуулахад төрийн орон сууцанд амьдарч буй эмчийн тоо 3 дахин, дэмжлэг үзүүлсэн сум 6-аар, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 9.2 дахин буюу 28,4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2-д

							зааснаар тэтгэврийн тэтгэмжийг 4 хүнд 85,4 сая төг, тогтвор суурьшилтай ажиллаж буй 139 хүнд 646.6 сая төгрөгийн тэтгэмж, илүү цагийн хөлс, урамшууллыг давхардсан тоогоор 6257 хүнд 2,4 тэрбум төгрөг, үр дүнгийн урамшуулал 1609 хүнд 596,4 сая төгрөг, 212 ажилтанд 9,6 сая төгрөгийн витаминжуулалт, эмчилгээнд хамруулсан 151 ажилтан, 219 ажилтны ар гэрийнхнийг хамруулах зэргээр нийгмийн хамгааллын дэмжлэг үзүүлсэн. Эрүүл мэндийн салбарт шинээр 90 эмч мэргэжилтнийг ажилд авч, эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт анхан шатанд 86,1%, лавлагаа шатлалд 76.8%, салбарын хэмжээнд дунджаар 82,6% болсон.
27	2.1.7. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	27. Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 522,4 сая төгрөгийн төсөвт өртгөөр Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг "БЭМЭС" ХХК гүйцэтгэж 8 дугаар сард байнгын ашиглалтад оруулсан.
28		28. Замын-Үүд суманд өрхийн Эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 950,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих ажлыг "Төгс өнөд" ХХК гүйцэтгэхээр шалгарч, барилгын угсралтын ажил хийгдэж, 90%-тай гүйцэтгэсэн.
29		29. Даланжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Улсын төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн 2262.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даланжаргалан суманд 15 ортой эмнэлгийн шинэ барилга барих ажлын гүйцэтгэгчээр "Элит конкрет" ХХК шалгарч

						ажлаа эхлүүлсэн. Барилгын каркасан хийц угсрах ажил нь бүрэн дуусч, 1 дүгээр давхрын гадна, дотор ханын өрлөг, дээвэр, дотор магистраль шугам угсрах ажлууд хийгдэн, 70%-тай гүйцэтгэсэн.	
30		30. Ханги хилийн боомтод эмнэлгийн барилга барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Ханги хилийн боомтод баригдах эмнэлгийн барилгын зураг төслийн ажлыг "Сант номун" ХХК боловсруулж дууссан. Барилгын зохион байгуулалт, халдвар хамгааллын урсгал, ПГУ лабораторийн байршлын талаар зураг төслийн ажилд санал тусгасан. Орон нутгийн төсвийн 1990,2 сая төгрөгийн төсөвт өртөгөөр баригдах Ханги хилийн боомтын Эрүүл мэндийн төвийн барила угсралтын ажлын сонгон шалгаруулалтыг <a href="https://www.tender.gov.mn/">https://www.tender.gov.mn/</a> цахим сайтад байршуулан нийтэд зарласан ба 12 дугаар сарын 19-ний өдөр тендер нээгдэнэ.
31		31. Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн барилгын дээвэр, гадна фасад засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Орон нутгийн төсвийн 163.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн барилгын дээвэр, гадна фасадны засварын ажлыг "Төгс өнөд" ХХК гүйцэтгэж 10 дугаар сард ашиглалтад оруулсан.
32		32. Хөвсгөл сумын эрүүл мэндийн байгууллагыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлэх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Хөвсгөл сумын орон нутгийн хөгжлийн санийн 585.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Төсөвт байгууллагуудыг дулаан, цэвэр ус, бохирын сүлжээнд холбох ажил"-ыг "Энержи парагон" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.
33		33. Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын төв, Халзан-Уул	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын төв, Халзан-Уул сувиллыг нэгтгэх аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

		сувиллыг нэгтгэн үйл ажиллагааг өргөжүүлж, сувиллын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх					Тэргүүлэгчдийн 2021 оны 55 дугаар тогтоолоор шийдвэр гарсаны дагуу Халзан-Уул рашаан сувиллын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийн, Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төвд 92,7 сая төгрөгийн эргэлтийн, 346,1 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг шилжүүлэн хаалтын баланс гаргаж, төрийн болон төрийн бус харилцагч байгууллагуудтай тооцоог бүрэн нийлүүлж, Улсын бүртгэлд хасалт хийлгэн, нэгтгэсэн. “Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв”-ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Сувиллын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажлын зураг төсвийг хийлгэн аймгийн 2023 оны төсөв, жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 138,0 сая төгрөгөөр тусгасан.
34	2.1.8. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулж, төгсөгчдийг орон нутагт мэргэжлээрээ ажиллах хөшүүргийг оновчтой хэрэгжүүлнэ.	34. Бэлтгэж буй мэргэжлийн тоог нэмэгдүүлэн, орон нутгийн оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэн, тогтвор суурьшилтай ажиллах үр дүнтэй хөшүүргийг бий болгох	2022	Бэлтгэж буй мэргэж-лийн тоо  Дэмжлэг үзүүлэх оюутны тоо	6  20	ОНТ Хандив тусламж	Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургууль их эмчийн 6 жил, сувилагчийн 3 жил, дипломын 4 жил, эм найруулагчийн 3 жил, лабораторийн техникчийн 3 жилээр нийтдээ 4 мэргэжлийн 5 чиглэлээр оюутан сургасан. Эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж байгаа 16 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулан сургалтын төлбөрийн 100% -ийн тэтгэлэг болох 67.9 сая төгрөгийг аймгийн Засаг дарга, орон нутгийн хөгжлийн сангаас олгож, орон нутгийн хүний нөөц бэлтгэх ажлыг бодлогоор дэмжсэн. Орон нутгийн их, дээд сургуульд элсэн суралцах оюутнуудын төлбөрийг хөнгөлөх талаар 2022 онд гарсан Засгийн газрын шийдвэрийг 14 сумдын ЗДТГ-т хүргүүлж,

						сумдад дутагдалтай байгаа сувилагч, эм найруулагч зэрэг мэргэжлээр суралцах орон нутгийн оюутнуудыг дэмжих чиглэл өгч, албан бичгээр үүрэг өгсөн. Тухайн онд сувилахуйн чиглэлээр Дорноговь аймгийн 15 оюутан төгссөн ба үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт 2 сувилагч, сумын эрүүл мэндийн төвүүдэд шинэ төгссөн 3 мэргэжилтнийг ажлын байраар хангасан.
35	2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлнэ.	35. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн”, хүүхдийн парк байгуулах	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ Улсын төсвийн 5,5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн” хүүхдийн парк байгуулах ажлыг “Дэлгэр баясах зам” ХХК, “Энержи парагон” ХХК, “Уртын-Уул” ХХК-ууд гүйцэтгэсэн. Тус хүүхдийн паркад үйлчилгээний барилга, нийтийн бие засах газар, тасалбар худалдах цэгийн барилга, тоглоом /алсын харагч, далайн дээрэмчний завь, агаарын гинж, морин тойруулга, эргэдэг аяга, мөргөлддөг машин/, гадна зам, талбайн гэрэлтүүлэг, хиймэл нуур, тохижилт, ногоон байгууламжийн ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөнөөс үйлчилгээний барилга, нийтийн бие засах газар, тасалбар худалдах цэгийн барилгууд болон гадна цахилгаан хангамж, гадна хашаа, гадна бохир усны цооног, бохир усны шугам, гүний худаг гаргах мөн хиймэл нуурын төмөр бетон хийцийн ажлууд бүрэн хийгдэж дууссан. Гадна зам, талбайн явган замын хавтан-3000м2, автозамын хашлага, автозогсоолын хашлагыг бэлтгэсэн. Гантиг чулуун хавтан,

							гантиг хашлага, тоглоомуудыг БНХАУ-аас захиалсан. Мөн 5 ширхэг тоглоомын суурийн хийцлэл буюу арматурчлалын ажлууд хийгдсэн. Улсын болон орон нутгийн төсөвт 2021-2022 онд 3,08 тэрбум төгрөг батлагдаж, батлагдсан санхүүжилтийн хүрээнд төлөвлөгдсөн ажил 100% хийгдсэн.
36		36. Спортын төрлүүдийг хөгжүүлэхэд спортын холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах	2022	Хамтран ажиллагч байгууллагын тоо  Спортын-төрөл-	42  15	ОНТ	Монголын бүх ард түмний спортын 15-р наадмын анхан шатны тэмцээнийг 22, Үндэсний спортын 7-р наадмын анхан шатны тэмцээнийг 14 төрлөө рспортын 20 холбоо, клубтэй хамтран 738 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Аймагтаа спортын төрлүүдийг жигд хөгжүүлэхэд анхаарч спортын бүх төрлийг дэмжин шинээр Жюүжицү, Грандгольф, Софт волейбол зэрэг спортын холбоодтой гэрээ байгуулан, 22 спортын холбоо, клуб, 25 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран нийт 95,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
37		37. Биеийн тамир спортоор хичээллэх нөлөөллийн ажлыг сайжруулан үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох	2022	Хичээллэгсдийн тоо	10000	ОНТ	Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороо “Монголын Гимнастикийн холбоо”, “Үнэгүй Фитнес” төрийн бус байгууллага хамтран орон даяар шууд дамжуулсан өглөөний дасгалд 14 сумын 80 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор 13730 иргэнийг хамруулсан ба идэвх санаачилгатай оролцсон 5 сум, 5 аж ахуйн нэгж, байгууллага, 5 иргэнийг шалгаруулж, урамшуулсан. Энэ арга хэмжээ нь иргэдийг нийтийн

							биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхжүүлэх нөлөөллийн ажил болон, 8 сумын 20 аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч, иргэд нийт 600 гаруй хүн тогтмол дасгал, хөдөлгөөн хийж хэвшсэн. Нийтийн биеийн тамир, спортоор давхардсан тоогоор 15000 гаруй хүн хичээллэж байгаа нь өмнөх оноос 10000 хүнээр өссөн.
38	2.2.2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор хичээллэх орчныг сайжруулна.	38. “Шанд ресорт” мөсөн гулгуурын талбайг хувийн хэвшлийн оролцоог дэмжих	2022	Дэмж-лэгийн тоо	1	ОНТ	Улсын төсвийн 5,5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн” хүүхдийн парк байгуулах ажлыг “Дэлгэр баясах зам” ХХК, “Энержи парагон” ХХК, “Уртын-Уул” ХХК-ууд гүйцэтгэж байгаа бөгөөд “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн”-г түшиглэн мөсөн гулгуурын талбай байгуулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн.
39	үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор хичээллэх орчныг сайжруулна.	39. Үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулах	2022	Төвийн тоо	1	ОНТ	“Соёмбо” цогцолборын хүндэтгэлийн өргөө, “Жаргалан” хүүхдийн зуслан, “Спорт цогцолбор”-ын үндэсний спортын танхимыг түшиглэн үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулах зургийн ажил хийгдсэн. Төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгт Монгол ёс заншил, бахархлын өргөө, танхимыг тохижуулан, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3000 гаруй хүүхэд, багачуудад үндэсний өв соёлоо сурталчлан таниулсан.
40	2.2.3. “Өсвөрийн шигшээ баг”-ийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2021-	40. Тив, дэлхий, олимп, улс бүсийн чанартай тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчдад	2022	Урамшуу-лах тамирчдын тоо	50	ОНТ	“Өсвөр үе, залуучуудын шигшээ багийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжих журам”-ыг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн 28 тамирчин, 4

	2024)-ний хүрээнд их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын тэмцээн уралдаанд оролцох тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.	дэмжлэг урамшуулал олгох				дасгалжуулагчийг 3,0 сая төгрөг, тив, дэлхий, улс, бүсийн тэмцээнд оролцсон 40 тамирчин, нийт 68 тамирчид, дасгалжуулагчдад нийт 42,0 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олгосон. “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жилийн хүрээнд өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн, Монголын бүх ард түмний спортын 15-р наадмын зүүн бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн, “DORNOGOBI OPEN-2022” жюу жицүгийн нээлттэй тэмцээн, холимог насны боксчдын аварга шалгаруулах олон хотын нээлттэй тэмцээн, залуучуудын улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн, волейболын “Үндэсний дээд лиг”-ийн аварга шалгаруулах тэмцээний тойргийн тоглолтыг орон нутагт анх удаа зохион байгуулсан. Спортын арга хэмжээ болон тамирчдын амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлж, орон нутгийн төсвөөс 165,0 сая төгрөгийг зарцуулсан.
41		41. Өсвөрийн шигшээ багийн төрлийн тоо, медалийн чанарыг нэмэгдүүлж, багш дасгалжуулагчдыг урьж хамтран ажиллах	2022	Шигшээ багийн төрлийн тоо  Хичээллэгсдийн тоо	10  400	ОНТ  “Хүүхэд хөгжил-2022” зорилтот жил болгон зарласны дагуу Биеийн тамир, спортын газраас “Өсвөрийн шигшээ багийг дэмжих жил” болгон, төлөвлөгөө гарган, шинээр Ширээний теннис, Хөл бөмбөг, Гандболын спортын холбоо, клубтэй хамтран ажиллаж, Сагсан бөмбөг, Жүдо бөх, Гандбол, Чөлөөт бөх, Хөл бөмбөг, Бокс, Хөнгөн атлетик, Волейбол, Ширээний теннис гэсэн спортын 9 төрлөөр үнэ төлбөргүй секц, сургалтад 810 хүүхдийг хамруулсан. Боксын спортын мастер, дасгалжуулагч Баасанг 3 дахь жилдээ урьж ажиллуулснаар



						Боксын холбоо Улсын тэргүүний холбоо болсон амжилт үзүүлсэн. Аймгийн өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр хичээллүүлж, мэргэжлийн багш, дасгалжуулагч нартай хамтран 400 гаруй хүүхдэд сургалт, бэлтгэл хийж байгаа нь өмнөх оноос 25%-аар өссөн.
42	2.3.1. Сургуулийн өмнөх боловсролд 3-5 настай хүүхдийг хамруулж, 5 настай хүүхэд бүрийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	42. 3-5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах	2022	СӨБ-ийн хамран сургалтын цэвэр жин Үүнээс 5 настай сурагч-дын хувь	92  98	ОНТ  Хүн амын статистик тоогоор цэцэрлэгийн 3-5 насны 4664 хүүхэд байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгт 3767, төрийн бус өмчийн цэцэрлэгт 57, төмөр замын цэцэрлэгт 542, нийт 4366 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, сургалтын бохир жин 93.6 хувьтай гарсан. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 87,6%, хүн амын статистик тоогоор 5 настай 1520 хүүхдээс 1432 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, хамран сургалт 94,2%-тай байна.
43	2.3.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарын үндэсний үнэлгээний чанарыг ахиулна.	43. Элсэлтийн ерөнхий шалгалт болон сурлагын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах	2022	ЭЕШ-ын оноо  Чанарын үнэлгээний шалгалтын гүйцэтгэ-лийн хувь	538,5,  36.1	ОНТ  Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, сурагчдыг идэвхжүүлэх, сурлагын хоцрогдлыг бууруулах зорилгоор “Зорилгын-хүч-3” арга хэмжээг зохион байгуулан, 10 сургуулийн 12 дугаар ангийн нийт 2473 сурагчдаас 10 хичээлээр 2 удаа элсэлтийн ерөнхий шалгалтын сорил авч нэгдсэн дүнгээр 64,8%-тай шалгагдлаа. Монгол хэл, бичгийн ерөнхий шалгалтад бэлтгэн "Ямар мэргэжилтэй больё доо?" эсээ бичлэгийн уралдаан зарлаж 551 сурагчийг хамруулсан. Мөн “Зөвлөх багш зөвлөж байна” ажлын хүрээнд 1 Ардын багш, 5 Зөвлөх багшаар 12 дугаар ангийн сурагчдад сургалт зохион байгуулж, зөвлөмж өглөө. Математикийн

						<p>“Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулж, 10 сургуулийн 18 бүлгийн 180 сурагч, 30 гаруй багшийг хамруулсан. “Шинэ Монгол” сургуультай хамтран 12-р ангийн сурагчид болон математик, физик, англи хэлний багш нарт 2-3 өдрийн сургалт зохион байгуулж, 84 багш, 360 гаруй сурагчийг хамруулсан. “Санаачилгатай эртэч хүүхэд” аянд 91%-ийн ирцтэй оролцсон.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 ангийн анги хамт олны “Үндэсний бичгийн олимпиад”-д 20 сургуулийн 36 бүлгийн 5171 сурагч оролцуулснаас Сайншанд, Замын-Үүд, Дэлгэрэх, Өргөн сумдын сургуулийн анги, хамт олон тэргүүн байруудыг эзэлж, мөнгөн шагналаар шагнагдсан. Элсэлтийн ерөнхий шалгалтын ерөнхий дүнгээр 520,8 дундаж оноогоор улсад 5 дугаар байр эзэлж, Монгол хэл, Түүх, Газар зүйн хичээлээр улсын хэмжээнд тус тус тэргүүн байр эзэлсэн.</p>	
44	2.3.3. Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэх арга хэмжээг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.	44. "Хутагтын нутгаар", "Торгон хил" сэдэвт болон бусад нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх	2022	Хамраг-дах сурагч-дын тоо	30	ОНТ	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/656 дугаар захирамжаар 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр говь нутгийн ахуй амьдрал, өөрийн аймгийн түүхэн дурсгалт газрууд, хилийн цэргийн амьдралтай танилцуулан, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх “Торгон хил” сургалт, аяллын арга хэмжээг 20 сургуулийн 9-р ангийн 40 сурагч, 8 багшийг хамруулан, Сайншанд-Зүүнбаян-Хөвсгөл-Хатанбулаг-Сулинхээр 5-р застав-Хөвсгөл-Зүүнбаян-Сайншанд гэсэн маршрутаар зохион байгуулсан. Сурагчид “Торгон хил” сургалт, аяллын сэтгэгдлээ гар зургаар илэрхийлэн, сургуулийнхаа нийт сурагчдад үзэсгэлэн</p>

							гаргаж, түгээн дэлгэрүүлсэн.
45		45. Байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн олон талт арга хэмжээнд хүүхдүүдийг өргөнөөр хамруулан, орон нутгийн түүх, соёлыг таниулах	2022	Хамрагдах сурагчдын тоо	6000	ОНТ	<p>Төрийн өмчийн ерөнхий боловсролын 21 сургуульд “Орон нутгийн онцлогтой хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн, Иххэт сумын сургууль “Байгалиа шинжихүй” сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагчид хичээлийн бус цагаар мэлхий хад, сэнжит хад, заан хад, бүсийн чулуу, даяанчийн хад зэрэг газруудыг үзэж, өөрийн амьдардаг орон нутгийн түүхэн дурсгалт газрыг танин мэдэж, нэрлэж, сумынхаа түүхэн газруудыг дүрслэн зурж сурсан.</p> <p>Эрдэнэ сумын сургуулийн сурагчид орон нутгийн түүх соёлыг таниулах ажлын хүрээнд сургуулийн нийт 163 хүүхдийг “Бүрдэнэ элс” байгалийн үзэсгэлэнт, түүх дурсгалыг таниулж сургалт, аялал зохион байгуулсан. Даланжаргалан сумын сургууль “Их нартын байгалийн нөөц газар” үзэсгэлэнтэй байгалийн тогтоц, ховор ан амьтан, түүх соёлын баялаг өвийн өлгий болсон нутагтай танилцах аяллыг зохион байгуулсан. Орон нутгийн түүх, соёлыг таниулах ажлын хүрээнд орон нутгийн онцлогтой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээс гадна аймаг, сумын Музей сургалт судалгааны төвд түүхийн хичээлүүдийг заах, “Ёс заншлын өргөө”-гөөр зочлуулан монгол ахуй соёлыг танилцуулах, аялал, уулзалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд 6031 сурагч хамрагдаж, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн.</p>
46	2.3.4. “Чадварлаг багш” арга хэмжээг	46. Багш нарын ур чадвар, сурган хүмүүжүүлэх илтгэлийн	2022	Зохион байгуулах арга хэмжээ-ний тоо	5	ОНТ	“Хөгжлийн төлөө хамтдаа-2” /2020-2024/ үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Чадварлаг багш” арга хэмжээг нийт багш

	<p>хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.</p>	<p>уралдаан, хичээл төрлийн олимпиад зохион байгуулах</p>				<p>нарын дунд зохион байгуулан, “Сайн хичээл-2022” ур чадварын уралдааны 1-р шатанд 51 багш, 2-р шатанд 12 багш оролцсоноос Замын-Үүд сумын сургууль, цэцэрлэгийн багш нар тэргүүлсэн. “Сурлагын хоцрогдлыг бууруулж буй тэргүүн туршлага” уралдааны 1-р шатанд бүх цэцэрлэгийн багш нар, 2-р шатанд 30 багш, 3-р шатанд 6 багш оролцсон. "Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь" сэдэвт оны шилдэг илтгэл шалгаруулах уралдааны 1-р шатанд 25 илтгэл ирснээс Сайншанд сумын 1-р сургуулийн бага ангийн багшийн илтгэл шалгарч, онлайнаар улсын хэмжээнд илтгэлээ танилцуулсан. Хичээл төрлийн олимпиадыг 10 төрлийн судлагдахуунаар зохион байгуулсан. "Миний Монгол бичиг-2022" олимпиадыг СӨБ-ын 272 багш, ЕБС-ийн 275 багш, 6-9 дүгээр ангийн 1723 сурагчдын дунд 3 үе шаттай зохион байгуулсан.</p>
47		<p>47. “Алтанзул” арга хэмжээ зохион байгуулах</p>	2022	<p>Зохион байгуулах арга хэмжээний тоо</p>	1	<p>ОНТ</p> <p>"Алтанзул" арга хэмжээ, багш нарын өдрийг хамтатган боловсролын салбарын өнгөрсөн жилийн ололт амжилт, алдаа оноогоо нэгтгэн дүгнэх, ахмад багш нар болон амжилттай ажилласан хамт олон, багш нарыг алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх “Багш бадрахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд багш нар харилцан суралцаж, багш мэргэжлээрээ бахархан, орон нутгийн онцлог давуу талыг мэдэрч, цаацдаа сургалтандаа хэрэгжүүлэх</p>

						<p>ямар нөөц боломж байгааг судлан хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон.</p> <p>Мөн "Алтанзул" шагналт багш С.Батхишиг, Р.Алтанцэцэг нарын туршлагыг орон нутгийн телевизээр олон нийтэд түгээсэн. "Зөвлөх багш зөвлөж байна" арга хэмжээг зохион байгуулж, МУ-ын Ардын багш Ч.Отгонбаяр, Зөвлөх багш О.Дуламсүрэн, Г.Батхишиг, Ч.Амаржаргал нар бага ангийн багш нар болон 12 дугаар ангийн сурагчдад сургалт хийж, зөвлөмж зөвлөгөө өгсөн. Мөн "Багш дор мөргөмүй" багшийн багшийн багшийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулж, боловсролын байгууллагад гэр бүлээрээ хамтран зүтгэсэн 8 ахмад багшид хүндэтгэл үзүүлж, багшийн багшийн шавь 14 багшийг алдаршуулсан.</p>
48	48. "Багш спорт" арга хэмжээ зохион байгуулах	2022	Зохион байгуулах арга хэмжээ-ний тоо	1	ОНТ	<p>"Багш спорт-2022" спортын наадамд 59 байгууллагын 25 багийн 470 гаруй тамирчдыг хамруулан спортын 5 төрлөөр зохион байгуулсан. Тус спортын арга хэмжээнд багийн нийлбэр дүнгээр Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн хамт олон 1-р байр, ЕБ-ын 3 дугаар сургуулийн хамт олон 2-р байр, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийн хамт олон 3-р байр, 9 жилийн сургууль, цэцэрлэгээс Дэлгэрэх сумын ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн хамт олон тэргүүн байр, Мандах сумын ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн хамт олон 2-р байр, Эрдэнэ сумын ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн хамт олон 3-р байрыг тус тус эзэлсэн.</p>
49	49. Орон нутагт нэн шаардлагатай багш	2022	Дэмжлэг үзүүлэх оюутны	30	ОНТ Хандив	Багш мэргэжлээр суралцаж байгаа 1-4 дүгээр курсийн оюутнуудын судалгааг

		нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх		тоо-			гаргахад 1-р курст 46, 2-р курст 32, 3-р курст 39, 4-р курст 20 оюутан суралцаж байна. "Саран хөхөө" театрын хөгжимчин, бүжигчин 3 уран бүтээлчийн сургалтын хөтөлбөрийн төлбөрт нийт 5,0 сая, СУИС-д Дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 5 оюутны сургалтын төлбөрт орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээний дагуу нийт 20,0 сая, Даланжаргалан сумаас хөгжмийн багш мэргэжлээр сурч буй 1 оюутны сургалтын төлбөрт 4,0 сая, бусад мэргэжлээр суралцаж буй 6 оюутанд 16,0 сая, орон нутагт нэн шаардлагатай багшийг бэлтгэхэд нийт 15 оюутанд 45,0 сая төгрөг, эмч бэлтгэхэд 16 оюутанд 67,9 сая төгрөг, нийт 31 оюутанд 112,9 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.
50	2.3.5. Боловсролын байгууллагын бүтээн байгуулалт	50. Сайншанд сумын 640 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, гадна хашаа барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Сайншанд сумын 6 дугаар багт "640 хүүхдийн сургууль барих" төсөл арга хэмжээг төлөвлөн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгөөр барилга угсралтын ажлыг "Болор-Аграмба" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын үндсэн хийц бүтээц, дотор цахилгаан, сантехник, холбоо, дохиолол, хаалга, цонх суулгах, шалны ажлууд хийгдсэн. Гадна фасадны металл өнгөлгөө, дотор заслын ажлуудын 90 хувь хийгдсэн.
51		51. Сайншанд сумын 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Улсын төсвийн 3,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1 дүгээр багт 2 дугаар сургуулийн /өргөтгөл/ 320 хүүхдийн сургууль барилгын ажлын гүйцэтгэгчээр "Жинсийн орой" ХХК шалгарч барилгын бүтээцийн ажил болон дүүргэлт,

						заслын ажлыг гүйцэтгэж дууссан. Ажлын гүйцэтгэл 90%-тай байна.
52	52. Замын-Үүд суманд 640 хүүхдийн сургуулийн барилга барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ ОНТ	Улсын төсвийн 9,3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Замын-Үүд сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 640 хүүхдийн сургуулийн барилга барих ажлыг "Билгүүн монгол констракшн" ХХК шалгарч, барилгын талбайд газар шорооны ажил 100%, суурийн ажил 100%, хийгдэж 1 дүгээр давхрын А, В, С, D, E блокийн төмөр бетон каркас болон 2 дугаар давхрын С, E блокийн багана дам нурууны бетон хучилт, А, В блокийн дам нуруу болон хучилтын арматурын ажлыг гүйцэтгэсэн. Тухайн онд хийгдэх үе шатны төлөвлөгөөт ажил бүрэн хийгдсэн. Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан барилын ажил түр зогссон.
53	53. Хатанбулаг суманд 320 хүүхдийн сургуулийн барилга барих	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	УТ	Улсын төсвийн 7,7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Хатанбулаг суманд 320 суудалтай сургуулийн барилга барих ажлыг "Ньюконстракшн" ХХК шалгарч, барилгын газар шороо, суурь, 1,2-р давхрын каркасан хийцийн угсралтын ажил, 3-р давхрын багана, дам нуруу, хучилт цутгах ажил зэрэг ажлууд хийгдэн 40%-тай гүйцэтгэлтэй байна. 2022 онд батлагдсан санхүүжилтийн хүрээнд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 100 хувьтай болсон.
54	54. Сайншанд сумын 4-р цэцэрлэгийн засварын ажил хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 295.7 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд сумын 4 дүгээр цэцэрлэгийн гадна фасад, хаалга, шал, гэрэлтүүлгийн засварыг "Аббадон констракшин" ХХК 100 хувь гүйцэтгэж

						ашиглалтад хүлээлгэн өгсөн.
55	55. Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн гадна фасад засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 52.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр Замын-Үүд сумын 1 дүгээр цэцэрлэгийн гадна фасадны засварын ажлыг "Дэнжийн хүү" ХХК 100 хувь гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.
56	56. Замын-Үүд сумын 4-р цэцэрлэгийн дээврийн засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 94.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр Замын-Үүд сумын 4 дүгээр цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг "Дэнжийн хүү" ХХК 100 хувь гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.
57	57. Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн сантехникийн засвар хийх, 9-р цэцэрлэг, Замын-Үүд сумын 5-р цэцэрлэгийг жишиг гадна тоглоомын талбайтай болгох	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 163.2 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн дулаан болон цахилгааны засварын ажлыг "Мандах наран сүлжээ" ХХК гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн. Сайншанд сумын 9-р цэцэрлэг, Замын-Үүд сумын 5-р цэцэрлэгийг жишиг гадна тоглоомын талбайтай болгох санхүүгийн эх үүсвэр тус онд шийдэгдээгүй бөгөөд 2023 оны төсөвт Замын-Үүд сумын 5-р цэцэрлэгийн өргөтгөлийн гадна тохижилт, эртний түүх дурсгалтай холбоотой тоглоомын талбай байгуулах ажлыг гүйцэтгэхээр 39,2 сая төгрөгийг тусгасан.
58	58. Сайншанд сумын 1-р сургуулийн дээврийн засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 485.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн дээврийн засварын ажлыг "Танан цамхаг констракшин" ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн.
59	59. Сайншанд сумын 3-р сургуулийн спорт заалны гадна фасад засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Сайншанд сумын 3 дугаар сургуулийн гадна фасадны зураг төслийг "Сант номун" ХХК боловсруулсан. 2022 онд санхүүгийн эх



							үүсвэр шийдэгдээгүй, 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгасан.
60		60. Хөвсгөл сумын сургуулийн барилгын дээврийн засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 51.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр Хөвсгөл сумын сургуулийн барилгын дээврийн засварын ажлыг "Дэнжийн цамхаг" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.
61		61. Иххэт сумын сургуулийн дотоод засвар хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	Орон нутгийн төсвийн 117.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотор Мэдээлэл зүй, хими, англи хэлний болон технологийн кабинет, бага анги 1, спорт зал болон 1, 2-р давхрын бүх ариун цэврийн өрөө, цайны газрын бэлтгэлийн өрөөний засварын ажлыг "Эргэл хийц" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.
62		62. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2022	Тоног төхөөрөмжөөр хангагдах сургуулийн тоо	3	ОНТ	Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн урлагийн танхимд 10,0 сая төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, 2-р сургуульд 8,7 сая төгрөгийн 30 морин хуур, 5-р сургуульд 4,8 сая төгрөгийн 15 морин хуур хөгжмийг тус тус нийлүүлсэн. Сайншанд сумын 3-р сургуульд 3,0 сая төгрөгийн, Хатанбулаг сумын ЕБ-ын сургуульд 8,2 сая төгрөгийн, Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн урлагийн танхимд 7,2 сая төгрөгийн хөгжим, техник хэрэгслийг тус тус худалдан авч сургалтын орчныг сайжруулсан. Тайлант онд 5 сургууль, цэцэрлэгийн биеийн тамирын залны тохижилт, хэрэгсэл болон урлагийн

							танхимын хөгжим, техник хэрэгслийг үе шаттайгаар нэмэгдүүлж, нийт 43,6 сая төгрөгийг зарцуулан, хүүхдийн хөгжлийг дэмжин ажилласан.
63	2.3.6. Ерөнхий боловсролын сургуульд “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” үйлчилгээнд шилжүүлэн, шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.	63. “Үдийн хоол” арга хэмжээг чанар, хүртээмжтэй хэрэгжүүлэх	2022	Үдийн хоол хөтөлбөрт хамраг-дах сургуу-лийн тоо	22	ОНТ	<p>Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн үдийн хоол хөтөлбөрт хамрагдвал зохих 21 сургуулийн 7937 хүүхэд бүрэн хамрагдсан. “Хоол үйлдвэрлэлийн шинэ системийн танилцуулга” сургалтыг сургууль, цэцэрлэгийн тогооч, нярвуудад цахимаар зохион байгуулж, 21 сургууль, 36 хүүхдийн цэцэрлэг цахим системд хоолны мэдээллээ бүрэн оруулж хэвшсэн. Сургууль, цэцэрлэгийн 46 тогоочийг хамруулан хоолны технологийн картын бичилт, бодолт хийх арга зүйн сургалтыг зохион байгуулсан. “Зохистой хооллолт ба эрүүл мэнд” нөлөөллийн сарын аяныг зохион байгуулж, 22 сургуулийн 15321 сурагчийг хамруулсан.</p> <p>Нөлөөллийн сарын аяны хүрээнд эрүүл мэндийн хичээлээр дамжуулан хүнсний шим тэжээлийн бодисыг нэмэгдүүлэх зорилгоор бага ангийн сурагчдад “Өглөөний цайны ач холбогдол”, дунд ангийн сурагчдад “Зохистой хооллолт ба дасгал хөдөлгөөн”, ахлах ангийн сурагчдад “Зохистой хооллолт ба эрүүл мэнд” сэдвээр хичээл, сургалтыг зохион байгуулсан. Хоолны чанар, нэр төрлийг сайжруулах талаар тухай бүр зөвлөгөө өгч, сумдын сургууль, цэцэрлэгийн хоолны чанарт тогтмол хяналт тавьснаар үдийн хоолоо түрээслэн ажиллуулдаг 11 сургууль байснаас Мандах сумын сургууль энэ оноос өөрсдөө үйлдвэрлэдэг болсон.</p>

64		64. Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах	2022	Гал тогооны тоног төхөөрөмж сайжруулах сургуулийн тоо	3	ОНТ	Хатанбулаг сумын сургуулийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 25,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Чиглэл" ХХК гүйцэтгэж, гэрээний дагуу 19 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Замын-Үүд сумын сургуулиудын дотуур байрыг нийт 42,3 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан.
65		65. Ерөнхий боловсролын сургуулиудыг ундны усны шүүлтүүрээр хангах	2022	Ундны усны шүүлтүүр сайжруулах сургуулийн тоо	10	ОНТ	"НИК" ХХК-ийн харьяа Дорноговь нефть хангамжийн салбараас нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн төвийн 2 цэцэрлэг, 1 сургуульд 4 ширхэг ус цэвэршүүлэгч, "Мобиком" ХХК-ийн Замын-Үүд дахь салбар нийгмийн хариуцлагын хүрээнд тус сумын ЕБ-ын 3-р сургуульд 2 ширхэг ундны усны шүүлтүүрийг тус тус хандивласан. Мөн Алтанширээ, Даланжаргалан, Хөвсгөл, Өргөн, Эрдэнэ сумдыг нийт 6 ширхэг 3,0 сая төгрөгийн ус цэвэршүүлэгчээр хангаснаар сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд анги танхимдаа цэвэр ус уух нөхцөлийг бүрдүүлсэн. Ерөнхий боловсролын болон цэцэрлэгийн 12 ангийг ус цэвэршүүлэгчээр хангасан.
66	2.3.7. Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан бүх	66. Цахим сургалтыг хөгжүүлэх бүх талын арга хэмжээг авч багш, суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх	2022	Нийлүү-лэх компюте-рийн тоо  Хүүхдүүдийн	20	УТ ОНТ	ЕБ-ын 12 сургууль, 2 цэцэрлэгийн цахим сургалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, нийт 96,9 сая төгрөгийн 34 зөөврийн компьютероор хангасан. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан "Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй, аргачлалыг таниулах"

	<p>насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.</p>			<p>цахим сургалтад хамрагдах хувь</p>	<p>75</p>	<p>цахим сургалтад 14 судлагдахуунаар 471 багшийг хамруулж, шууд дамжуулсан сургалтад 246 багшийг хамруулан мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Мөн Боловсрол мэдээллийн технологийн төвөөс зохион байгуулсан "Microsoft Office 365" админ хэрэглэгчийн 2 удаагийн сургалтад 36 цэцэрлэг, 21 сургуулийн захирал, эрхлэгч, сүлжээ хариуцсан багш нийт 80 хүнийг хамруулсан.</p> <p>Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургууль "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн хүрээнд "Аргыг нь олж амжилтаар жигүүрлэе" хөтөлбөрийг хэрэгжүүлж, бага ангийн сургалтын чанарыг сайжруулах, сурагчдын бие даан суралцах боломжийг бүрдүүлэх, эцэг эхчүүдэд хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийхэд тулгардаг бэрхшээлийг арилгахад туслах "TINK" аппликейшныг шинээр бүтээсэн. Боловсрол шинжлэх ухааны яамнаас байгуулсан "Medle.mn" цахим сургуульд улсын хэмжээнд төрийн өмчийн 499 сургуулийн 10-р ангийн 10409 суралцагч цахимаар 16 хичээл судалж байгаагаас аймгийн хэмжээнд 177 хүүхэд цахимаар суралцсан.</p> <p>Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Ган-Эрдэнэ 3,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, "ЕСМ" ХХК-ийн "Их нүүдэл" цахим сургалтын удирдлагын системийг Сайншанд сумын ЕБ-ын 2-р сургуульд хэрэгжүүлсэн.</p>
<p>67</p>		<p>67. "Англи хэлтэй Дорноговь" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>2022</p>	<p>Төлөвлө-гөөний хэрэгжил-тийн хувь</p>	<p>100</p>	<p>ОНТ</p> <p>"Англи хэлтэй Дорноговь" зорилтот хөтөлбөрийн хүрээнд Сайншанд сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд</p>

						<p>“Бадрах энерги” ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд 24,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Англи хэлний кабинет, Лингафоны танхимыг иж бүрэн тохижуулсан. Америкийн Элчин сайдын яамнаас зохион байгуулсан 3 сарын цахим сургалтад 37 багш, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн “Англи хэлний зуны эрчимжүүлсэн сургалт”-д 7 багш, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 1, 5, 10 жилийн үндсэн сургалтуудад 14 багш, үндсэн болон төрөлжсөн сургалтуудад давхардсан тоогоор нийт 116 багшийг хамруулсан. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан модуль сургалтад 73 багш 219 модуль эзэмшсэн.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Англи хэлний олимпиад”-ыг 5 ангиллаар зохион байгуулж, 503 сурагчийг хамруулсан. Говийн бүсийн аймгуудын ЕБ-ын сургуулийн “Англи хэлний олимпиад”-д оролцох багш, сурагчдыг шалгаруулах сорилыг 7 ангиллаар 150 сурагчийг хамруулан зохион байгуулж, шалгарсан 16 сурагчийг бүсийн олимпиадад оролцуулж, багш, сурагчид 5 алт, 2 мөнгө, 3 хүрэл, 1 тусгай байр эзэлсэн амжилт үзүүллээ. Англи хэлний элсэлтийн ерөнхий шалгалтад зориулсан 3 удаагийн сургалтад 360 сурагч хамруулж, “МУ-ын Ерөнхийлөгчийн илгээлт-2100” тэтгэлэгт хөтөлбөрт 9 сурагч тэнцсэн.</p> <p>Орон нутгийн төсвийн 12,0 сая, АНУ-ын Элчин сайдын яамны 63,0 сая төгрөгийн</p>
--	--	--	--	--	--	--

							санхүүжилтээр “Соёмбо” цогцолборын Америкийн соёл мэдээллийн төвийн барилгын дотор засвар, тус яамны 10,000 долларын санхүүжилтээр техникийн шинэчлэлийг хийж, 300 орчим англи ном, DVD кино, уншигч үйлчлүүлэгчдэд зориулсан өндөр хурдны интернэт, иж бүрэн компьютер ашиглан, байгууллага, иргэд, хүүхэд, залуучуудын насны онцлог, түвшинд зориулсан англи хэлний анхан, дунд, ахисан шатны сургалт, IELTS-н шалгалтад бэлдэх сургалт, кино, үлгэрийн цаг, ярианы болон бичгийн клуб, үг, үсэглэлийн тэмцээн сургалтын хөтөлбөрт 3346 иргэнийг хамруулсан. Зорилтот хөтөлбөрийг 89%-тай хэрэгжүүлэн ажилласан.
68	2.3.8. Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	68. “Миний монгол хэл, бичиг-2025” арга хэмжээг хэрэгжүүлэх	2022	Зохион байгуулах арга хэмжээний тоо	3	ОНТ	“Миний монгол хэл, бичиг-2025” арга хэмжээний хүрээнд “Үндэсний бичиг үсэг-2022” 3 сарын аяныг зохион байгуулан, СӨБ-ын багш, ажилтнуудын дунд “Миний монгол хэл, бичиг-2022” уралдааныг 3 үе шаттай зохион байгуулж, 824 багшийг хамруулсан. Мөн нийт багш нарын дунд “Миний монгол хэл бичиг-2022” олимпиад, монгол бичгийн багш нарын сургалт, 6-9 ангийн сурагчдын дунд анги хамт олны олимпиадыг 3 үе шаттай зохион байгуулж, 600 багш, 5171 сурагчийг оролцуулсан. Насан туршийн боловсролын төвөөс "Алтан нутгийн бүтээлийг ахмад настнууд бичиж байна" таталган бичлэгийн уралдаан, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар 127 ажилтныг 80 цагийн үндэсний бичгийн сургалтад, 118 иргэнийг 4 удаа 68 цагийн үндэсний бичгийн сургалтад тус тус

						хамруулсан. “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийн 2 удаагийн арга хэмжээнд 791 иргэнийг хамруулсан. Миний монгол хэл, бичгийн хөтөлбөр, сургалт, уралдаан, тэмцээн, үзэсгэлэн зэрэг 32 арга хэмжээнд давхардсан тоогоор 7800 гаруй хүнийг хамруулсан нь өмнөх оноос 29 арга хэмжээгээр өссөн.
69		69. Иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимыг сургуульд түшиглэн байгуулах	2022	Шинээр байгуулах танхи-мын тоо	2	ОНТ Хатанбулаг, Мандах сумдын насан туршийн боловсролын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, үндэсний бичгийн танхимыг шинээр байгуулан нийт 30,0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн. Насан туршийн боловсролын төв, сумдын насан туршийн боловсролын нэгжийн сургалтын танхимд үндэсний бичиг, үсгийн чиглэлээр иргэд болон төрийн албан хаагчдын дунд түргэн уншлага, хүмүүн бичиг сонины захиалга, уншлага, сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, 32 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 7800 гаруй хүнийг хамруулсан. Алтанширээ сумын төрийн албан хаагчдаас монгол бичгийн сорилын шалгалт авч, 57 төрийн албан хаагчийг хамруулан, сургалт зохион байгуулсан.
70	2.3.9. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, суралцах орчин бүрдүүлнэ.	70. Бүх насны иргэдэд насан турцдаа суралцахуйг дэмжих тэгш, хүртээмжтэй хүргэх цахим болон танхимын сургалт, сурталчилгааны ажлыг хийх	2022	Сургал-тын төрөл тоо,  хамрагдах хүний тоо	10/230/  15500	ОНТ Насан туршийн боловсролын төв, сумдын насан туршийн боловсролын нэгжийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, дарах” сургалтад 105 иргэн, дээл эсгэх арга, эмжих технологи, даалин урлалын сургалтад малчин өрхийн 21 иргэн, малчдын амьдрах ухаанаас суралцах

						<p>экскурс сургалтад 80 гаруй сурагч, нийт 8 төрлийн амьдрах ухааны танхимын сургалтад 225 иргэнийг, "Гэр бүлийн боловсрол", "Гэр бүлийн харилцаа", "Гэр бүл төлөвлөлт" сэдвээр 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 220 иргэнийг хамруулж, "Гэр бүлийн хүчирхийлэлд үр хүүхэд хохирдог" сэдвээр цахим хичээл бэлтгэж 2000 гаруй иргэнд түгээсэн. Гэр бүл, жөндөр судлаач Н.Золзаяагийн "Айл бүхэн аз жаргалтай байг" сургалтад 45 гэр бүлийг тус тус хамруулсан. Мөн "Ёс зүйн төлөвшил", "Авлигын эсрэг хууль", "Зүрх сэтгэл ба зөв харилцаа хандлага", "Харилцаа хандлага", "Стрессийг даван туулах арга", "Хайр ба уучлал", "Өөрийгөө таньж мэдэх", "Бусдыг ойлгох, хайрлах", "Үгэн бус харилцаа" зэрэг цахим сургалт, хичээлийг бэлтгэн 9800 гаруй иргэдэд түгээсэн. Ял эдэлж буй 11 иргэнд иргэний боловсрол, ёс зүйн боловсрол, санхүүгийн боловсрол олгох сургалтыг сард 2 удаа тогтмол зохион байгуулсан.</p> <p>Үндэсний бичгийн анхан болон ахисан түвшний сургалт, "Монгол өв соёл" нөлөөллийн арга хэмжээ, гоо зүйн сургалт зэрэг цахим болон танхимын сургалт, нөлөөллийн 17 үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 15800 гаруй иргэнд хүрч үйлчилсэн нь өмнөх оноос үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хамрагдсан иргэдийн тоо 5,3%-аар өссөн.</p>
71	71. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт	2022	Тохижил-тын ажлын тоо-	2	ОНТ	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуульд нийт 30,4 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд



		<p>боловсрол олгох орчин нөхцөлийг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх</p>		<p>Хамраг-дах тоо</p>	<p>20</p>	<p>зориулсан тусгай хэрэгцээт хөтөлбөрийн хичээлийн танхимыг шинээр байгуулан, танхимаар 13, гэрээр 14, нийт 27 хүүхдийг тусгай боловсролын үйлчилгээнд хамрууллаа.</p> <p>Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах ээлтэй орчин нөхцөл, хүртээмжийг нэмэгдүүлж, 640 хүүхдийн хүчин чадалтай шинэ сургуулийн давхар бүрд тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан бие засах суултуур, орох хаалга бүрд стандартын 3 налуу шатыг шийдэв. Аймгийн хэмжээнд 255 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас боловсролын үйлчилгээнд 157 хүүхдийг хамруулсан ба бусад 98 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насанд хүрээгүй болон суралцахад хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байсан.</p> <p>Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх сэргээн засах, өдөр өнжүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-д 66,9 сая төгрөгийн санхүүжилт олгон, 9 хүүхдийг хамруулсан. Боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй болон дутуу хамрагдсан 0-24 насны бүлгийн хүүхэд, залуучуудыг илрүүлэх “Монголын боловсрол-өнөөдөр” үндэсний суурь судалгааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2022 оны А/677 дугаар захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Мөн сум бүр ажлын хэсэг байгуулан ажиллаж, нийт 21115</p>
--	--	--	--	-----------------------	-----------	---

						<p>өрхийг уг судалгаанд хамруулах ба нэгж хариуцсан 106 судлаачийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Судалгааны ажлыг 2021 оны 11-р сарын 28-ны өдрөөс эхэлж 2023 оны 01-р сарын 13 нд дуусгахаар төлөвлөсөн. Сайншанд сумын түр хамгаалах байранд 19,0 сая төгрөгийн санхүүжилтээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх өрөөний засварыг хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авч үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p>	
72	<p>2.4.1. Шинжлэх ухаан технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг орон нутгийн нийгэм, эдийн засагт өгч байгаа үр өгөөжийг шалгуур болгон дэмжинэ.</p>	<p>72. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих</p>	2022	Дэмжлэгийн тоо-	2	ОНТ	<p>Орон нутгийн захиалгат төслийг дэвшүүлэх, хяналт тавих, үр дүнг хүлээн авах, үнэлэх, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх чиг үүрэг бүхий “Шинжлэх, ухаан технологийн салбар зөвлөл”-ийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагын 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.</p> <p>“Дорноговийн хонины мах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 27.6 сая төгрөгийн санхүүжилтээр эрдэм шинжилгээний судалгаа хийж 2022 онд говийн хонины махны гарц амт чанарыг хангайн хонины махтай харьцуулахад говийн хонины мах 2 дахин их антиоксидант идэвхтэй, амт, үнэр бүрдүүлэгч аминхүчил нь хамгийн өндөр буюу хурганы маханд 49.94%, төлөгний маханд 49.68%, гулуузны жингээр 5.5 кг буюу 30%, нядлахын жингээр 5.7 кг буюу 30.4%-н үзүүлэлтээр хангайн хонины махнаас илүү нь эрдэм шинжилгээний</p>

						<p>тайлангаар батлагдаж, Оюуны өмчийн газраар баталгаажуулсан “Зохиогчийн эрхийн гэрчилгээ” авсан.</p> <p>Орон нутгийн эрдэмтэн багш, зураач, докторуудтай хамтран зохиолч Л.Түдэвийн “Хорвоотой танилцсан түүх” бүтээлийг албан ёсны зөвшөөрөлтэйгөөр үндэсний бичгээр бичүүлэн, нутгийнхаа хүүхэд, багачуудын оюуныг тэлэх, хөгжүүлэх ажлыг шинээр санаачлан 600 ширхэгийг 11,4 сая төгрөгийн санхүүжилтээр хэвлүүлэн, 20 сургуульд түгээж, хичээл сургалтын үйл ажиллагаанд ашигласан.</p> <p>"Nextgen" төслийн уралдаанд хог хаягдлыг бууруулах, ангилах чиглэлээр 2, мод тарих, сэргээн засах төв байгуулах, "Ардьоно робот" зэрэг 5 төслийг илгээснээс "Ардьоно робот" төсөл шалгарч 20,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургууль “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд “Аргыг нь олж амжилтаар жигүүрлэе” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Andriod8 ISO ухаалаг үйлдлийн системтэй ямар ч гар утас, таблетад суулган ашиглах боломжтой TINK аппликейшн бүтээж тус аппликейшнд Монгол хэл, Математик зэрэг нийт 50 цахим хичээл, 70 гаруй сорилын санг байршуулан, сургуулийн хүрээнд 1281 сурагч, 2100 эцэг эх, 65 багш ашигладаг болсноор сурагчид чөлөөт цагаараа бие даан суралцах боломж бүрдсэн.</p>	
73	2.5.1. Нийгмийн даатгалын	73. Нийгмийн даатгалын шинэчлэлийг	2022	Сургалт, сурталчил-	100	ОНТ	“Сайн дурын даатгуулагчдын анхдугаар зөвлөгөөн”-ийг улсын хэмжээнд анх удаа

	шинэчлэл ийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөтгөж, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ.	эрчимжүүлж, холбогдох хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааг зохион байгуулан хэрэгжилтийг хангах		гааны ажлын тоо-			<p>зохион байгуулж, тус аймгийн 14 сумын 100 иргэнийг хамруулан, аймгийн Засаг даргаас 5,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэсэн. Нийгмийн даатгалын хэлтсээс явуулын үйлчилгээг 14 суманд зохион байгуулж, 456 иргэнд үйлчилгээг үзүүлэн, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс Замын-Үүд суманд нүүдлийн хурлыг зохион байгуулж, 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунган, 25 иргэний хугацаагүй сунгалтад шалгалт хийж зөвлөн тусалж ажилласан.</p> <p>Цахим хуудсаар 81, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудаснаас 71, орон нутгийн ТВ, сонин сэтгүүлд 8, байгууллагын цахим пэйж хуудсаар 206, коммент мессежээр 112, цахим сургалт /live, zoom/ 10, гар утсаар 383 удаа үйлчилгээг хүргэж ажилласан. Фейсбүүк хуудсаар 170, веб сайтаар /www.ndaatgal.do.gov.mn/ 81 удаагийн нийтлэлээр 36839 даатгуулагчдад мэдээллийг хүргэж, шинээр 197 даатгуулагч хуудсыг дагаж, нийт дагагчийн тоо 3249 буюу өмнөх оноос 20,1%-аар өссөн.</p>
74		74. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч болон даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх	2022	Ажил олгогч Даатгуулагчийн тоо --	715 23666	ОНТ	<p>Тэтгэврийн даатгалын сан 31,3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөө 98,4%, тэтгэмжийн даатгалын сан 3,2 тэрбум төгрөг төвлөрч 103%, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 3,2 тэрбум 100%, ажилгүйдлийн даатгалын санд 649,6 сая төгрөг төвлөрч 95,8%-тай биелүүлсэн.</p> <p>Нийт 17932 иргэнд 58,4 тэрбум төгрөгийн</p>

							тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгосон. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо 740, даатгуулагч иргэний тоо 22403 байгаа нь зорилтот түвшнээс ажил олгогч 25-аар нэмэгдсэн.
75	2.5.2. “Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулж иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно.	75. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгох	2022	Төлөвлө-гөөний биелэлт Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо Хугацаанд нь олгосон байх	100%	ОНТ	Тэтгэврийн даатгалын сан 31,3 тэрбум төгрөг орлого төвлөрч төлөвлөгөө 98,4%, Тэтгэмжийн даатгалын сан 3,2 тэрбум төгрөг төвлөрч 103%, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 3,2 тэрбум 100%, ажилгүйдлийн даатгалын санд 649,6 сая төгрөг 95,8%-тай биелүүлсэн. Нийт нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 100% биелсэн. Нийт 17932 иргэнд 58,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгож ажиллав.
76	2.5.2. “Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулж иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно.	76. Нийгмийн даатгалын үйл ажиллагааг цахимжуулан, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод шуурхай хүртээмжтэй болгох	2022	Цахим-жуулах үйлчил-гээний тоо-	3	ОНТ	“Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд 12 нэр төрлийн үйлчилгээг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системээр дамжуулж, нийгмийн даатгалын цахим дэвтрийг 456 иргэнд, тэтгэврийн цахим дэвтрийг 321 тэтгэвэр авагч, ажилгүйдлийн тэтгэмж 36 хүсэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хуудас, жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудас нийт 1321, ажил олгогчийн тодорхойлолт 744 зэрэг үйлчилгээг цахимаар хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Нийт 34 үйлчилгээнээс 24 үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.
77	2.5.3. Нийгмийн халамжийн	77. Нийгмийн халамжийн цахим системд	2022	Цахимд шилжих үйлчил-гээний	36	ОНТ	Нийгмийн халамжийн 72 нэр төрлийн үйлчилгээний 64 нэр төрлийг цахимд

	үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан, цахим системд үе шаттай шилжүүлнэ.	шилжүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх		тоо-			шилжүүлж, цахимаар үйлчилгээ авах хүсэлт ирүүлсэн 13447 иргэний хүсэлтийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн Үүнээс гадна “E-Mongolia” системд 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг оруулсан ба нийт үйлчилгээний 88,8 хувийг цахимжуулсан.
78		78. Хөдөлмөр эрхлэгчдийн орон нутгийн цахим бүртгэлийн мэдээллийн сан байгуулах бэлтгэл ажлыг хангах, судалгаа хийх	2022	Гүйцэтгэл	100%	ОНТ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан EJOB платформыг хөгжүүлэлтийн сургалтад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлагууд болон хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүд, сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний төлөөлөл нийт 23 албан хаагчийг хамруулсан. Бүгд найрамдах Солонгос улсын Хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн системд бүрэн шинэчлэл, сайжруулалт хийж, хөдөлмөрийн нэгдсэн систем EJOB платформыг хөгжүүлэн 2022 оны 12 дугаар сараас үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн.
79		79. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны чанарыг сайжруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот эзэнд нь хүргэх	2022	Нийг-мийн халам-жийн үйлчил-гээ зорилтот иргэнд хүрсэн байна	100%	ОНТ	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны маягт аргачлал шинэчлэгдсэн бөгөөд туршилтын журмаар зарим аймаг дүүрэгт судалгаа хийгдсэн. Тус аймгийн хувьд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдах өргөдөл өгсөн өрх иргэдээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/64, ҮСХ-ны даргын А/460 тоот хамтарсан тушаалаар батлагдсан аргачлалын дагуу судалгаа авах ажил хийгдэн, бүртгэлтэй 15343 өрх байгаа бөгөөд

						<p>доод түвшний 1428, харьцангуй бага хэрэглээтэй 3231, дундаж түвшний 7356, дунджаас дээгүүр 2724, илүү өндөр хэрэглээтэй 604 өрх байна. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд бүртгэлтэй доод түвшний 1428 өрхөөс нөхцөл байдлын үнэлгээ хийж амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн 157 өрхийн 296 том хүн, 406 хүүхдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийгмийн халамжийн сангаас өссөн дүнгээр 148,8 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээг 25470 иргэнд үзүүлж халамжийн 11,0 тэрбум төгрөгийг олгосон. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн тоо 147 өрхөөр буурч, халамжийн бусад үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 4261 иргэнээр өссөн.</p>	
80		80. Орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн гишүүдийг чадавхжуулах замаар ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2022	Зуучлаг-дах ажлын байрны тоо Чадавхжуулах зорилтот бүлгийн иргэдийн тоо	1300  120,	ОНТ	<p>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээ, мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх "Оролцоо" төслийн сургалтад өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-өөс доош оноотой нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн 433 иргэнийг хамруулж чадавхжуулсан. Үүнээс 294 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан.</p>
81	2.5.4. Орон нутгийн бүтээн	81. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд	2022	МСҮТ төгсөх сурагч-дын тоо	300 (гүйцэтгэ-	ОНТ	Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон зорилтот бүлгийн иргэдийн эрэлт хэрэгцээнд

	байгуулалтын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ.	үндэслэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх			лээр)		үндэслэн богино хугацаанд мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг үсчин, тогооч, оёдолчин, гагнуурчин мэргэжлээр зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан 61 иргэнд чадамжийн гэрчилгээг олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 11,9 сая төгрөгийг зарцуулсан. Мөн аймгийн Политехник коллежийн 2,5 жилийн ангид 7 мэргэжлээр 8 бүлэг, 1 жилийн ангийн 5 бүлэгт 337 элсэгчийг шинээр элсүүлж нийт 652 суралцагчид суралцаж байна. Энэ онд 363 суралцагч төгсөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 102 хүнээр өссөн.
82		82. Цагийн болон өдрөөр ажиллах хөдөлмөрийн уян хатан тогтолцоо, нөхцөлийг бүрдүүлэх	2022	Зохион байгуулах арга хэмжээний тоо Түр шинэ ажлын байранд орох иргэдийн тоо	2  320	ОНТ	Ажил ологч байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийн цагийн болон өдрийн ажлын байрны захиалгыг тухай бүрд авч Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн программд нэгтгэн орон нутгийн DTV телевиз болон зарын цахим сайт, цахим хуудсаар долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар ажлын байрны 61 захиалгыг 23 аж ахуй, нэгж байгууллага, 10 иргэнээс авч, шинэчлэн зар мэдээг хүргэж 46 иргэнийг ажлын байранд зуучилсан. Түр ажлын байранд 126 иргэнийг зуучилж, төсөл хөтөлбөрийн хүрээнд 596 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан. Нийт 722 иргэнийг түр ажлын байраар хангасан. Өмнөх оны мөн үеэс цагийн болон өдрийн ажлын байрны зуучлал, түр ажлын байрны зуучлал 90%-аар өссөн.
83		83. Орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний	2022	Шинэ ажлын байрны тоо Ажлын байранд	130	ОНТ	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд 1057 иргэн ажилд зуучлагдсанаас орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарт



		салбарын шинэ ажлын байранд ажиллагсдыг зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх		зуучлагдах ажлын байрны тоо	140		байнгын ажлын байранд 130 иргэн, түр болон улирлын ажлын байранд 283 иргэн нийт 413 иргэнийг зуучилсан. Мөн шинээр бий болсон 1013 ажлын байрыг бүртгэснээс орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарт 360 шинэ ажлын байр бий болсон. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал зуучлагдсан иргэдийн тоо 295 иргэнээр өссөн.
84		84. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сумдын ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	2022	Төлөвлөгөө-ний хэрэгжилт	100%	ОНТ	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөг 5 зорилт 14 арга хэмжээ, сарын аяны төлөвлөгөөг 4 зорилт 10 арга хэмжээг тусган баталж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: 1. ХАБЭА-н сарын аяныг “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан дор тэмдэглэн нээлтийг 04 сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нээлтэд 14 сумын ХАБЭА-н зөвлөлийн дарга, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарын 12, барилгын салбарын 13, худалдаа үйлчилгээний салбарын 5, төрийн 14 байгууллага оролцож, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын хэлтсээс мэдээлэл хийж, мэдээллийг 600 гаруй иргэнд хүргэсэн. Мөн Улаан загалмайн хороо, Онцгой байдлын газраас үзүүлэх сургалтыг зохион байгуулан 14 сумын ХАБЭА-н зөвлөлийн дарга нарт хууль тогтоомж дүрэм, журам бүхий хавтас, дарцгийг гардуулан өгсөн.</p> <p>2.Сургалтын хүрээнд: 14 сумын ХАБЭА-н</p>

125		125. Үнэт цаас, хувьцааны талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх	2022	Сургал-тад хамрагдах хүний тоо	500	ОНТ	Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, үнэт цаас, хувьцааны талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол банк, "Гүүдсек" үнэт цаасны компани, "Санхүүгийн хүртээмж хөгжил санаачилга" ТББ-тай хамтран санхүүгийн залилан түүнээс сэргийлэх, банкны IPO, үнэт цаас хувьцаа, амьдралын санхүүгээ сайжруулах сэдэвт сургалт, өдөрлөгийг давхардсан тоогоор 713 бизнес эрхлэгч, иргэдийг хамруулан зохион байгуулсан.
126	3.1.6. Нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн эх	126. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг төрийн бусад мэдээллийн сантай уялдуулан сайжруулж, хүн ам зүйн нарийвчилсан	2022	Мэдээлэл ашиглах хувь	100%	ОНТ	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн үзүүлэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний мэдээллийн сан, Боловсролын байгууллага, Нийгмийн даатгалын хэлтэс болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллийн сангуудтай холбон тогтмол шинэчилсэн. Хүн ам, өрхийн

	үүсвэртэй болно.	мэдээллийг гаргахад ашиглах					мэдээллийн сангаас хүн амын жилийн эцсийн тоо, төрөлт, нас баралт зэрэг хүн амын салбарын зарим дүн мэдээг гаргаж, “Хүн амын үндсэн үзүүлэлт-2021” танилцуулга, “Хүүхэд хөгжил-2022” судалгааг тус тус нэгтгэн боловсруулж цахимаар болон хэвлэмэл хэлбэрээр хэрэглэгчдэд тарааж, төрийн байгууллага, олон нийтийг мэдээллээр хангасан.
127		127. Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарын түүвэр судалгаанд хамрагдах өрхийн жагсаалт болон сэдэвчилсэн судалгааг гаргахад ашиглах	2022	Мэдээлэл ашиглах хувь	100%	ОНТ	Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж малчин, малтай өрхийн мэдээллийн санг шинэчилж хөдөө аж ахуйн 2022 оны тооллого болон хагас жилийн малын түүвэр судалгааны үр дүнг боловсруулан мэдээлэл бэлтгэсэн. Мал тооллогын үр дүнд үндэслэн 17 зураг, 31 хүснэгт, 6 бүлэгтэй “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга-2021” судалгааг боловсруулж ажилласан. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, малын тоо, насаар, төллөх малын тооны өөрчлөлт, төлийн тооны өөрчлөлт, худаг ус, хашаа, малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцөлийн талаарх мэдээллийг 2017-2021 оноор харьцуулсан дүгнэлт гаргаж 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар болон цаасан хэлбэрээр тараасан.
128		128. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайланг боловсруулах, тархаах, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах, тооллого судалгааны мэдээллийн үр өгөөжийг	2022	Мэдээ-лэл ашиглах хувь	100%	ОНТ	Албан ёсны статистикийн 52 нэр төрлийн мэдээ, тайлан, 5 төрлийн түүвэр судалгаа, 1 төрлийн нэлэнхүй судалгаанд сум, аж ахуйн нэгж, байгууллагын иргэдийг бүрэн хамруулж долоо хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар мэдээллийг авч 6749 нэгж мэдээг графикт хугацаанд нь гаргасан. Цахим хуудасны мэдээллийн санд үнийн



		нэмэгдүүлэх					мэдээг 43 удаа, жилийн эцсийн танилцуулгыг 1 удаа, сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг 10 удаа, улирлын болон салбарын инфографикийг 6 удаа, тэмдэглэлт баярын өдрүүдтэй холбоотой инфографикийг 3 удаа, сар бүрийн нийгэм эдийн засгийн байдлын тухай танилцуулгыг 10 удаа, статистик динамикийг 23 удаа цахим хуудсанд байрлуулж ажилласан. Мөн хөдөө аж ахуйн салбарын судалгаа-2021, Хүн ам өрхийн үндсэн үзүүлэлт-2021, Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлтийн судалгаа-2021, Худалдаа үйлчилгээний салбарын танилцуулга-2021, Хүүхэд хөгжил-2022 танилцуулгыг төрийн болон олон нийтийн байгууллага, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан.
129	3.2.1. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	129. Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	2022	Дэмжлэгийн тоо	1	ОНТ	“Цагаан суваргын зэс молибдений үйлдвэр”-ийн исэлдсэн хүдрийг боловсруулах катодын зэсийн үйлдвэрийг "МАК Аранжин зэс" ХХК барьж байгуулахаар төлөвлөж, овоолон уусгах байгууламжийн зураг төслийг "Усны эрчим" ХХК, барилгын ажлыг "Түмэн харш" ХХК гүйцэтгэхээр бэлтгэл ажлуудыг ханган барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан үзэж байна. Мандах сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс цагаан суварга” ХХК орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж 1,8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
130		130. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн дэд бүтцийн ажлыг	2022	Дэмжлэгийн тоо	1	ОНТ	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн дэд бүтэц байгуулах ажлын хүрээнд Иххэт сумын 2022 оны А/13 тоот захирамжаар 5

		гүйцэтгэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, газар ашиглах эрх олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах					кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын доорх 16.27 га газрыг "Монголросцветмет" ТӨХК-д эзэмшүүлж дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн Говьсүмбэр аймгийн Усны сав газартай ус ашиглах гэрээ байгуулж, тус аймаг болон Хэнтий аймгийн Засаг дарга нартай замын трассыг батлуулж хамтран ажилласан.
131		131. Алтанширээ суманд хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах, Иххэт суманд жонш баяжуулах зэрэг үйлдвэрүүдийг байгуулахад орон нутгийн зүгээс зохих дэмжлэг үзүүлэх	2022	Дэмж-лэгийн тоо	2	ОНТ	<p>“Алтанширээт үйлдвэрлэл технологийн парк”-ийн төслийн хүрээнд “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн 420,0 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар Алтанширээ сумын нутаг дэвсгэрт 140га талбайд төмрийн хүдрийн баяжмал, баяжуулсан нүүрс, кокс, төмрийн хүдрийн хорголж үйлдвэрлэх дагалдах 4 үйлдвэр бүхий жилдээ 500 мян.тн ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барихаар төлөвлөснөөс үйлдвэрийн 6.3 мВт-ын дэд станц, цахилгаан станц, 12 км төмөр зам, авто зам, төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр болон нүүрс угаах үйлдвэр тус тус ашиглалтад оруулсан.</p> <p>1000 ажилчид амьдрах орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Иххэт суманд “Төвшин” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажил дууссан. Орон нутгаас барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрлийг тухай бүр шуурхай олгон дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.</p>
132	3.2.2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах	132. Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад	2022	Дэмж-лэгийн тоо	3	ОНТ	Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилга болох иргэний 9 барилга, байгууламж, 44 км ус дамжуулах хоолой, 30 мянган м.куб багтаамжтай усны нөөцийн резерваур, үйлдвэрийн дэд бүтцийн

<p>үйлдвэрийг барьж байгуулна.</p>	<p>орон нутгаас дэмжлэг үзүүлэх</p>				<p>байгууламжийн бүтээн байгуулалтын ажлын явц 70 гаруй хувьтай хэрэгжсэн. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн Технологийн бус байгууламжийн Инженерчлэл-худалдан авалт-барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Жэй Эм Си Прожектс Индиа” компани шалгарсан. Үйлдвэрийн иргэний барилга байгууламж (Захиргааны байр, агуулах, засварын цех, гал командын байр, анхны тусламжийн төв, лаборатори, угтах байр), Ус хангамжийн систем, талбайн дэд бүтэц зэрэг барилга байгууламжуудыг барих ажлыг гүйцэтгэх ажилд туслан гүйцэтгэгч 8 компани ажиллаж, үйлдвэрийн гадна хашаажуулалт 100%-тай, усны нөөцийн савны арматурчлалын ажил 100%-тай, ус цуглуулах савны ажил 100%-тай, авто замын ажил 100%-тай, гал командын байр 100%-тай, ажилчдын байр 100%-тай, Захиргааны байр, агуулах, засварын цех, анхны тусламжийн төв, лаборатори, угтах байрны барилгын ажил 100%-тай байна. Үйлдвэрийн цэвэр ус дамжуулах хоолойг татах бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас шаардагдах газрын асуудлыг шийдвэрлэн, цэвэр ус дамжуулах 84.58 км хоолой татах шугамын ажлыг “Оргилон дэлгэрэх ус” ХХК, “Хасу мигавает” ХХК-ууд гүйцэтгэж, 11 цэвэр усны худаг, 1 өргөх насосыг байршуулсан. Барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг шуурхай олгож, Замын-Үүдийн</p>
------------------------------------	-------------------------------------	--	--	--	--

							боомтоор барилгын материалуудыг нэвтрүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. “Газрын тос боловсруулах үйлдвэрийн хашаа барих, талбайн тэгшилгээ, газар шорооны ажил”-ыг ашиглалтад оруулсан. “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтад оролцож буй “Жи Эм Си Прожектс Монгол” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмал буюу 55,3 мянган куб элсийг ашиглуулах гэрээг байгуулж дэмжлэг үзүүлэн ажилласан.
133		133. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэх	2022	Дэмж-лэгийн тоо	2	ОНТ	Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах хоолойн төслийн түр кемпийн зориулалтаар ашиглах 4,2542 га газрыг Алтанширээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж газар олгосон. Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдын нутаг дэвсгэрт нийт 1334.66 га газрыг Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/08 тоот тогтоолоор батлуулж, тогтоолыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн.
134	3.2.3. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжинэ.	134. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа, уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг	2022	Зохион байгуулах арга хэмжээний тоо	3	ОНТ	Айраг, Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан “Асралт хайрхан дэлгэрэх” ХХК, “ЭНТЭ” ХХК, “Хутагт өлзийт говь” ХХК, “Хос орчлон” ХХК, “Террам

		цуцлуулах санал хүргүүлэх				<p>Ресурсез Майнинг” ХХК, “Кингдаймонд” ХХК-ийн 7 тусгай зөвшөөрөл цуцлагдсан.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/128 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус аймгийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн талбайд ажиллаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, Даланжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Айраг-Индмин” ХХК (МУ-016936), “Аривжих энерги” ХХК (МУ-020962), “Баялаг жонш” ХХК (МУ-005294), “Блюскай хорс” ХХК (МУ-018496), “Гүн-Орд” ХХК (МУ-015222), “Дасайн-Уул” ХХК (МУ-011915), “Стар флюорит” ХХК (МУ-020726), “Шашир трейд” ХХК (МУ-010258), Айраг сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Таванбаатар” ХХК (МУ-003315), “Экилешия” ХХК (МУ-014111)–иудын тусгай зөвшөөрлийг цуцлуулах үндэслэлтэй гэсэн санал, дүгнэлт гарч, орон нутгийн мэргэжлийн байгууллага, холбогдох сумдаас тодруулга, мэдээллийг авч Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.</p>
135		135. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах		Арга хэмжээн ний тоо	3	<p>Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Айраг, Даланжаргалан, Хатанбулаг, Мандах сумдад үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгжийн 482,3 км орон нутгийн чанартай авто замын трассыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан, хатуу хучилттай, сайжруулсан авто зам барьж тээвэрлэлт хийх үүрэг чиглэлийг өгсөн. Мандах суманд үйл ажиллагаа явуулж буй “Их говь энерги” ХХК нь аймгийн Засаг</p>

							даргын 2012 оны А/534 дугаар захирамжаар батлагдсан орон нутгийн чанартай авто замын трассын дагуу сайжруулсан болон хатуу хучилттай авто зам бариагүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн тул дээрх замын трассыг аймгийн Засаг даргын 2022 оны А/537 дугаар захирамжаар хүчингүй болгосон.
136	3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын	136. Газар тариалан эрхлэгчдийг сургаж дадлагажуулах мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	2022	Арга хэмжээ Оролцогч- дын тоо	4 150	ОНТ	Аймгийн тариалан эрхлэгчдийг чадавхжуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд "Дэлхийн зөн Монгол" Олон улсын байгууллагын "Гамшигт тэсвэртэй орон нутаг" төсөл, "Монгол ногоо" төсөл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран 3 удаагийн танхимын сургалт, 3 удаагийн цахим сургалт, 1 удаагийн туршлага солилцох аялал зохион байгуулан давхардсан тоогоор нийт 297 тариаланчийг хамруулсан. Аймгийн Политехник коллежийн хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ангийг 25 суралцагч амжилттай төгсөж, шинээр 35 суралцагч элссэн.
137	төмс, хүнсний ногооны хангамжийг тогтвортой өсгөнө.	137. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шинэ сортын үрийг үржүүлэн хангамжийг нэмэгдүүлэх	2022	Сортын тоо тарвас), Үрийн хангамжийн өсөлтийн хувь	2	ОНТ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр давхардсан тоогоор 11 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 14 суманд, 2 тн төмсний үрийг "Мөнх-Ашиг" хоршоо, "Оюун шанд" ХХК-д олгон нийлүүлж, үрийн хангамжийг 2,57 хувиар, тариалалтыг 3,1 хувиар нэмэгдүүлсэн. Шинээр солонгосын бууцай, байцаа, салат навчны 3 төрлийн сортын үрийг сумдад тариалан туршин, тарвас, амтат гуаны 2,

					1	<p>эртний байцааны 1, сонгино 1, тарвасны 1, сармис 1, бууцай 1, гүзээлзэгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 9 төрлийн сортыг шинээр туршиж, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар холбогдох газарт хүргүүлсэн. Хүнсний ногоо, модны үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд сухай 100 кг төл, тарвас 13 кг амтат гуаны 13 кг үрийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх “Монгол ногоо” төсөлд нийлүүлсэн ба 2023 онд Сэлэнгэ аймаг, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад тус тус үр нийлүүлэх гэрээ байгуулсан.</p>
138		<p>138. Өрхийн тариалангийн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх замаар хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх</p>	2022	Нэмэг-дэх талбайн хэмжээ	150 (м2)	ОНТ <p>Газар тариалангийн чиглэлээр 217 өрх, 23 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр иргэн, аж ахуйн нэгжүүд нь төмс 25,8 га, хүнсний ногоо 63,2 га, малын тэжээл 33,9 га, жимс, жимсгэнэ 15,2 га, нийт 136 га талбай, бага оврын трактор 72, үрлэгч 5, ухагч 3, 37 га-ын дуслын усалгааны систем, 900 м2 өвлийн хүлэмж 2 ш, 10520 м2 зуны хүлэмж 65 ширхэг, 950 тоннын багтаамж бүхий 22 зоорийг үйл ажиллагаандаа ашиглаж, урьд оноос тариалангийн талбайн хэмжээ 29%, зоорийн хангамж 5,5%, хамгаалагдсан хөрсний тариалалт 579 м2-аар нэмэгдсэн. Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн сумд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас газар тариалан эрхлэх 5 иргэнд 105.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Өргөн, Сайншанд, Иххэт сумд 14 иргэнд 93,46 га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэн дэмжлэг үзүүлсэн.</p>

139		139. Газар тариалан эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан дэмжих замаар үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2022	Хөнгө-лөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо	5	ОНТ	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80% хөнгөлөлттэй үнээр олгосон давхардсан тоогоор 11 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 14 суманд, 2 тн төмсний үрийг “Мөнх-Ашиг” хоршоо, “Оюун шанд” ХХК-д нийлүүлж, үрийн хангамжийг 2,57 хувиар тариалалтыг 3,1 хувиар нэмэгдүүлсэн. Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Өргөн, Сайншанд, Иххэт сумд 22 иргэнд 99,59 га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Засгийн газраас хэрэгжүүлсэн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд 4 иргэн, 1 хоршоо хамрагдаж 69,6 сая төгрөг, Сайхандулаан, Мандах, Хатанбулаг сумд "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 3 иргэнд 55.0 сая төгрөг, нийт 124,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Хүнсний ногоо тарих, боловсруулах хөнгөлөлттэй зээл авах хүсэлт ирүүлсэн 14 сумын 338 иргэн, 32 аж ахуйн нэгжийн хүсэлт, мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжилж, зээлийн шаардлага хангасан 4 иргэн, 1 хоршоо 69.6 сая төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан авсан.</p> <p>“Хөгжлийн шийдэл” ТББ, арилжааны 5 банкттай хамтран хөнгөлөлттэй зээл, хамрагдах боломж, анхаарах асуудлын талаар 1 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 22 тариалан эрхлэгч танхимаар, цахимаар 10 сумын 17 иргэн хамрагдаж мэдээлэл авсан. Гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг 16 төрийн байгууллага, хэвлэл</p>
-----	--	---	------	--	---	-----	---



						мэдээллийн хэрэгслээр (DTV) давхардсан тоогоор 14864 иргэдэд хүргэсэн.
140	3.3.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	140. Гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх	2022	Мах, сүү, гурилан бүтээгдэхүүний хангал-тын өсөлтийн хувь	0.3	ОНТ
						<p>Гурилан бүтээгдэхүүний цех 42, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, цех 6, сүү, сүүн бүтээгдэхүүний цех 3, савласан усны 12 цех, өндөгний 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Алтанширээ сумын "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх чиглэлээр 1 хоршоонд 80,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгон дэмжлэг үзүүлсэн.</p> <p>"Солид Партнерс групп" ХХК нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Дорноговь аймагтай хамтран "Монгол тэмээ Дорноговь" төслийг хэрэгжүүлэн ингэний сүүг боловсруулан хуурай сүү, молоко зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох үйлдвэрийг Замын-Үүд суманд, үйлдвэрт шаардагдах ингэний сүүг цуглуулах эрчимжсэн фермерийг Мандах, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Сайншанд сумдад байгуулахаар малчид, иргэдэд танилцуулга мэдээллийг хүргэсэн. Хүн амын махны хэрэгцээг 100 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн 76,3 хувь, өндөгний 60 хувь, гурилан бүтээгдэхүүний 5,4 хувь, төмс, хүнсний ногооны 10,7 хувийг орон нутгаасаа хангадаг. Урьд оноос мах 2.2%, сүү, сүүн бүтээгдэхүүн 0.2%-иар, гурилан бүтээгдэхүүн 0.2%-р тус тус өссөн.</p> <p>Төв суурин газрын хүн амын 2023 оны хаврын улирлын махны хэрэгцээнд нийлүүлэх 275.2 тн нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн</p>

						төсөвт тусгуулахаар төлөвлөсөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарын бодлогыг шинэ шатанд гаргах, үйлдвэрлэлийн гинжин хэлхээ, борлуулалтын нэгдсэн сүлжээ, санхүү, хөрөнгө оруулалтын урсгалыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж малчид, үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг экспортод чиглүүлэх 4 чиглэл, 19 зорилт, 40 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, эхэлсэн.	
141		141. Үндэсний үйлдвэрүүдэд чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд нийлүүлсэн малчдыг урамшуулалд хамруулах ажлыг зохион байгуулах	2022	Үндэсний үйлдвэрт тушаах түүхий эд нийлүүлэлтийн хувь	14	ОНТ	Монголын арьс, ширний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхтэй 45 төлөөлөгч, мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэгч 19 хоршоо 14 суманд ажиллан, 2020-2021 онд үндэсний томоохон үйлдвэрүүдэд хонь, тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн 14 сумын давхардсан тоогоор нийт 6085 малчин, мал бүхий өрхөд 2084,71 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг татварын төлбөрийн баримтаар /и-баримтаар/ татварын нэгдсэн системд бүртгүүлсэн байхаар хуульчилсан тул төрийн байгууллагуудаар дамжуулан урамшуулал олгох боломжгүй болсон.

142		142. “Дэлгэрэхийн улаан” омгийн ямааны тархалтыг нэмэгдүүлэх	2022	Шинээр тархаан сайжруулах хээлтүүлэгч-ийн тоо	150	ОНТ	Сумдад “Дэлгэрэхийн улаан” омгийн ямааг тархаах талаар чиглэлийг хүргүүлж, 1891 малчинд танилцуулга, мэдээллийг хүргэж ажилласан. “Дэлгэрэхийн улаан омог”-ийн ямааны тархалтыг нэмэгдүүлэх, нутгийн малын чанар сайжруулахаар 31,9 сая төгрөгийг зарцуулж 213 өсвөр хээлтүүлэгч бэлтгэсэн ба Улаанбадрах, Мандах, Алтанширээ, Замын-Үүд, Өргөн, Даланжаргалан сумдад нийлүүлсэн.
143	3.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ.	143. Мал сүрэгт эзлэх өндөр ашиг шимт малын тоог өсгөх замаар малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх	2022	Шинээр өндөр ашиг шимт малын нэмэгдүүлэх тоо	200 толгой	ОНТ	Өндөр ашиг шимт малын тоо 78376 толгойд хүрч, 5 төрөл дээрээ 0,5%-аар өссөн нь нийт мал сүргийн 2,9 хувийг эзэлдэг бөгөөд малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэхээр “Дэлгэрэхийн улаан омог”-ийн ишгэн ухна 213, гал шарын ишгэн ухна 60, барга, үзэмчин үүлдрийн 30 хурган хуц, нийт 303 толгой өсвөр хээлтүүлэгч бэлтгэн бойжуулсан. Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн 4 суманд 141 үхэрт Алатау, Хар тарлан үүлдрийн үрээр, 996 толгой хонь, ямаанд нутгийн монгол хонь, дэлгэрэхийн улаан ямааны үрээр, нийт 1137 гардан хээлтүүлэгч хийсэн нь урьд оноос 51,3 хувиар нэмэгдсэн. Алтанширээ, Сайншанд сумд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 2 иргэн, аж ахуйн нэгжид 113,0 сая, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК-д 360,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.
144		144. Малчид, иргэдийн	2022	Зохио-мол	2	ОНТ	Биотехнологийн дэвшилтэт технологийг

		захиалгын дагуу бод, бог малын зохиомол хээлтүүлэг хийх		хээлтүү-лэгт хамраг-дах малын тоо-350 Өсөл-тийн хувь			нэвтрүүлэн 4 суманд 141 үхэрт Алатау, Хар тарлан үүлдрийн үрээр, 996 толгой хонь, ямаанд нутгийн монгол хонь, дэлгэрэхийн улаан ямааны үрээр гардан хээлтүүлэг хийж, урьд оноос 51,3 хувиар нэмэгдүүлсэн.
145	3.3.4. Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээлтийг хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.	145. Бэлчээр ашиглалтын нөлөөллийг фотомониторингийн аргаар тодорхойлж, сум бүр орон нутгийн онцлогт тохирсон бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх	2022	Судалгаанд хамруулах сумын тоо  Бэлчээр ашиглах журам, менежмент-ийн төлөв- лөгөө шинээр батлуу-лах сумын тоо-	14  2	ОНТ	Жил бүрийн 8 дугаар сард бэлчээрийн төлөв байдлын, ургац тодорхойлох ажлыг 14 сумын 54 багийн 72 бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын цэгүүдэд гүйцэтгэж, судалгааны үр дүнг харгалзан тухайн жилийн өвөлжилт, хаваржилтын бэлчээр ашиглалт, отор нүүдлийн зохион байгуулалтыг хийсэн. Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Сайншанд сумдын бэлчээр даац хэтэрсэн, бусад сумдад мал нэмж бэлчээх боломжтой гэж тогтоогдсон ба одоогоор хонин толгойд шилжүүлснээр 4,5 сая толгой мал бэлчээрлэсэн. 2022-2023 онд хонин толгойд шилжүүлснээр 434,6 мянган толгой малыг хүнсэнд болон зах зээлд борлуулах тооцоо гарсан. Айраг, Өргөн, Мандах, Улаанбадрах, Сайхандулаан, Хөвсгөл, Сайншанд сумд “Бэлчээр ашиглах, отор нүүдэл зохицуулах журам”-ыг батлуулан мөрдөж эхэлсэн.
146		146. Төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	2022	Шинээр гарах, сэргээн засвар-лах худгийн тоо	10	ОНТ	Бэлчээрт 3202 худаг ашиглагдаж байгаа нь нийт бэлчээрийн 40,3 хувийг усжуулдаг. Улсын төсвийн 157.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Эхний эхэн” ХХК сумдын бэлчээрт шинээр инженерийн хийцтэй 5 худаг гаргах ажлыг 60 хувьтай гүйцэтгэж байна. Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Мандах, Улаанбадрах, Замын-Үүд сумдын СОНХС-ийн 204.2 сая төгрөгийн санхүүжилтээр инженерийн хийцтэй 21 худаг

							шинээр гаргасан. Айраг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 18 сая төгрөгийн хөрөнгөөр 3 гар худаг сэргээн засварласан. Айраг, Даланжаргалан, Эрдэнэ сумдын 3 малчин хувийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 3 худаг шинээр гаргаж, 3 гар худгийг сэргээн засварласан. Дээрх 26 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 39,0 мянган га бэлчээрийг усжуулж, 54,6 мянган толгой мал услах нөхцөл бүрдсэн.
147	3.3.5. Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	147. Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,	2022	Илгээх мессеж тоо	100000	ОНТ	Мал аж ахуйн салбарын цаг үеийн болон цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/241 дүгээр захирамжаар 2.9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн "Мобиком", "Скайтел" ХХК-тай гэрээ байгуулан “Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэж, давхардсан тоогоор нийт 151,359 мессежийг илгээж, урьд оноос 30,3 хувиар өссөн.
148		148. Хадлан тэжээл бэлтгэх менежментийг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалах ажилд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	2022	Малын тэжээл тариалах хэмжээ (га)  Өвс (тн)  Тэжээл (тн)	34  100	ОНТ	Замын-Үүд суманд 2, Даланжаргалан суманд 1, Иххэт суманд 1, нийт 3 суманд 4 хадлангийн салаа үйл ажиллагаа явуулдаг. Аймгийн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл бэлтгэхээр тогтоосны дагуу хэрэгжилтийг 91.7 хувьтай хангаж, аймгийн нөөцөд 270 тн өвс, 61,5 тн тэжээл, сумдын нөөцөд 580.6 тн өвс 171.4 тн тэжээл бэлтгэсэн. “Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд сумдын газар тариалан эрхлэгч, малчдын 45 төлөөллийг Төв аймгийн Баян-Чандмань суманд малын тэжээл тариалах чиглэлээр

					50	<p>талбай бэлтгэх, тариалалтын хийх явцтай газар дээр нь танилцуулж туршлага судлуулсан. Дэлгэрэх, Эрдэнэ суманд 3 га талбайд малын тэжээлийн ургамлыг 20,0 гаруй сая төгрөгийн бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч олгож, 5 удаагийн танхимын сургалт, 1 удаагийн туршлага судлах аялалд давхардсан тоогоор 150 гаруй малчдыг хамруулсан.</p> <p>Төслийн үр дүнг Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ сумдад туршиж 33.90 га талбайд малын тэжээлийн тариалалт хийсэн нь өмнө оноос тариалалтыг 1 га-аар нэмэгдүүлсэн. Иххэт сумын иргэн 20-25 га талбайд ногоон тэжээл тариалан 18 тн ургац хураан авсан. Улсын төсвийн 100,0 сая төгрөгийн санхүүжилтээр Мандах, Сайхандулаан сумдад малын тэжээлийн ургамал тариалах, хадлан тэжээл бэлтгэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлагдсан.</p>
149	149. Малын тооноос хамааруулан өвс, тэжээлийн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, стандартын дагуу хадгалах	2022	Аймаг, сумдын өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хувь	80	ОНТ	<p>Аймгийн 14 сум мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахад сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэн хадгалах агуулахтай. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор аймгийн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл бэлтгэхээр тогтоосон. Тогтоолын хэрэгжилтийг 91.7 хувьтай хангаж, аймгийн нөөцөд 270 тн өвс, 61,5 тн тэжээл, сумдын нөөцөд 580.6 тн өвс 171.4 тн тэжээл бэлтгэсэн.</p>

							Сумдын бэлчээрийн даац, газар зүйн байршил, отор нүүдлийн төлөв байдлыг харгалзан Хөвсгөл, Өргөн сумдад сум дундын өвсний аюулгүй нөөцийг бүрдүүлж, 222 тонн өвсийг татан төвлөрүүлсэн.
150		150. Мал сүргээ тогтвортой өсгөн үржүүлж, нүүдлийн соёлыг уламжлалыг хадгалан малчдын залуу халааг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж байгаа тэргүүний малчдыг урамшуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	2022	Малчдын тоо  Арга хэмжээний тоо	40  2	ОНТ	Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан мал сүргээ 5 төрөл дээр нь тогтвортой өсгөн үржүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн, малч ухаан, ажиллах арга туршлагаараа манлайлан ажилласан "Улсын гавьяат малчин"-1, "Улсын аварга малчин өрх"-4, "Алтан төлийн эзэн"-5, "Аймгийн хошой аварга малчин өрх"-5, "Аймгийн аварга малчин өрх"-26, "Аймгийн аварга тэмээчин"-2, "Аймгийн алдарт уяач" -4 тус тус тодруулж, тэргүүний малчдыг урамшуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх 3 удаагийн арга хэмжээг 2022 оны 3-4 дүгээр сард зохион байгуулсан.
151	3.3.6. Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлж, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.	151. Орон нутгийн хүнс, газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах	2022	Зохион байгуулах багц ажлын тоо	5	ОНТ	Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Намрын ногоон өдрүүд", "Шилмэл мал" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 14 сумын 17 төрийн байгууллага, 5 төрийн бус байгууллага, 127 иргэн, аж ахуйн нэгж, 50 гаруй малчин оролцож үйл ажиллагаагаа сурталчлан, 73.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл" нэгдсэн арга хэмжээнд орон нутгаас шалгарсан 3 аж ахуйн нэгжийг бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан оролцуулж 6.8 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн. "Язгуур алтан өв" соёлын биет бус өвийн

						<p>анхдугаар үзлэг, наадам, Соёл, урлагийн газрын Нээлттэй хаалганы өдөрлөгөөр 27 өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилсан. “ITM” Олон улсын аялал зуулчлалын үзэсгэлэн худалдаа 2022 оны 10 дугаар сарын 28, 29, 30-ний өдрүүдэд Мишээл экспод зохион багуулагдаж “Далт мөнгөн шанд” ХХК Загсгал цай, “Дорнын үжин говь” ХХК Эко саван, эсгий урлалаар оролцсон. Нийтийн хоолны газар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн түвшин тогтоох ур чадварын дадлага сургуулалтад 33 тогоочийг хамруулсан. “Хүнсний аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтад Сайншанд, Мандах, Эрдэнэ, Өргөн сумдын хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 107 төлөөлөл хамрагдсан.</p> <p>Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүнсний үйлдвэрийн 1, хүнсний худалдааны 5, нийтийн хоолны 69 нийт 75 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдалд улсын байцаагчийн 11-03-013/17 дугаартай 37 заалт бүхий “Үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” зөвлөмж хүргүүлсэн. Мөн үйл ажиллагааг зогсоох 2 акт, ажлын байрны 1 дүгнэлт, 4 албан шаардлага тус тус хүргүүлсэн.</p>
--	--	--	--	--	--	---



152		<p>152. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартыг мөрдүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулан мэргэжилтэй ажилтан бэлтгэх</p>	2022	<p>Тохир-лын үнэлгээнд хамруулах, бүтээгдэхүүний тоо</p> <p>Олгох тохир-лын гэрчилгээ тоо</p> <p>Стан-дарт хувь</p> <p>Хүний нөөцийн хангал-тын хувь</p>	<p>450</p> <p>232</p> <p>60</p> <p>40</p>	ОНТ	<p>Худалдаа, үйлчилгээний 700 газрыг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, стандартуудыг тухай бүрд тайлбарлан таниулж, 35 бүтээгдэхүүн, 300 үйлчилгээнд гэрчилгээ олгосон. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад 1910 цахилгааны, 637 массын, 743 эзлэхүүний хэмжих хэрэгслийг хамруулсан.</p> <p>Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартын талаар 9, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр 4, хэмжил зүйн чиглэлээр 2 нийт 15 удаагийн сургалт зохион байгуулж сургалтад 24 аж ахуйн нэгж, 314 иргэнийг хамруулж мэдээлэл өгсөн. 2022 оны 04 дүгээр сарын 07-ний өдөр "Best" хөтөлбөрийн Дорноговь салбартай хамтран Сайншанд суманд, 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Замын-Үүд суманд "Дотоодын бүтээгдэхүүн" үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд "Боловсруулсан гурилын бэлдэц" техникийн шаардлага MNS5760-2020, "Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн" техникийн шаардлага MNS2488-2021, "Чанамал гурилан бүтээгдэхүүн" техникийн шаардлага MNS4578-2021 шинэчлэгдсэн стандартуудыг танилцуулах сургалтыг хийж сургалтад нийт 33 аж ахуйн нэгж хамрагдаж, шинэчлэгдсэн стандартын талаар мэдээлэлтэй болсон.</p> <p>Аймгийн Эрүүл мэндийн газар, Улаанбаатар Төмөр замын барилга ашиглалт, үйлчилгээний 3 дугаар ангийн албан хаагчдад, Замын-Үүд сумын Засаг</p>
-----	--	--	------	--	---	-----	--

						даргын Тамгын газарт тус тус “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартын тухай ойлголт сэдэвт сургалтыг зохион байгуулж 3 аж ахуйн нэгж 163 иргэн оролцсон. Говьсүмбэр аймаг, Замын-Үүд, Өргөн, Эрдэнэ суманд үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэнд Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ итгэмжлэлийн тухай хууль, хэмжил зүйн тухай хууль болон ажил үйлчилгээний талаар сургалт хийж сургалтад 60 иргэн хамруулсан.	
153		153. Орон нутагт хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж, стандартыг сурталчлан цар хүрээг өргөжүүлэх	2022	Батал-гаажуулалтад хамрагдалтын хувь	98	ОНТ	Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжил зүй, стандарт, сорьцын хяналтын баталгаажуулалт зэрэг үндсэн 4 чиглэлээр орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлэн, орон нутагт 303 худалдааны, 231 үйлдвэр, 142 үйлчилгээний цэг, цахилгааны 22303, массын 300 гаруй, эзлэхүүний 4611 хэмжих хэрэгсэл тус тус ашиглаж худалдаа, үйлчилгээний 700 газрыг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, стандартуудыг тухай бүрд тайлбарлан таниулж, 35 бүтээгдэхүүн, 300 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад 1910 цахилгааны, 637 массын, 743 эзлэхүүний хэмжих хэрэгслийг хамруулж худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартыг мөрдүүлэх, стандартыг сурталчлах чиглэлээр 11 удаагийн танхимын болон цахим сургалтад нийт 386 иргэн, 9 аж ахуйн нэгж, төрийн байгууллагын 70 төлөөллийг хамруулж, 74 стандартыг үнэ

							<p>төлбөргүй олгосон. Баталгаажуулалтын салбар зөвлөл 9 удаа хуралдаж 14 сумын 115 аж, ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулж, 15 бүтээгдэхүүн, 112 худалдаа, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгож, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах мерник, туухай зэрэг эталон тоног төхөөрөмжийг худалдан авахад орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>
154	<p>3.3.7. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулж, экспортыг нэмэгүүлнэ.</p>	<p>154. Малын эмч, мэргэжилтний хүний нөөцийг бүрдүүлэн, чадавхжуулах</p>	2022	<p>Мэргэ-жил дээш-лүүлэх болон давтан суралцах эмч, мэргэжилт-нүүдийн тоо</p>	300	ОНТ	<p>Малын эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 25 удаагийн цахим, 19 удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 355 эмч, мэргэжилтэн, төрийн албан хаагч, малчдын төлөөлөл 845 иргэнийг хамруулан, 66 төрлийн гарын авлага материал 9400 ширхэгийг олгосон. Цахим орчинд давхардсан тоогоор 59 постер, 10 төрлийн богино хэмжээний видео мэдээллийг байршуулж, орон нутгийн телевизэд 4 удаа мэдээлэл хийж, үйл ажиллагааг сурталчилсан.</p> <p>Мал эмнэлгийн үйлчилгээний 33 нэгжид 42 малын их эмч, 3 бага эмч, Мал эмнэлгийн газар, сумдын Мал эмнэлгийн тасагт 22 эмч, мэргэжилтэн ажиллаж байгаа нь хүний нөөцийн 48.8 хувийг бүрдүүлж байна. Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Мэргэжил сурталчлах өдөрлөг"-ийг Сайншанд, Иххэт сумдын ерөнхий боловсролын сургуульд зохион байгуулж 9-12 дугаар ангийн нийт 126 сурагчийг хамруулан гарын авлага, мэдээллээр хангасан. Мал</p>

						эмнэлгийн газрын 1 мэргэжилтэн ХААИС-ийн "Магистр, докторын сургууль"-ийг төгссөн. "Нутгийн зөвлөл"-ийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөрт 4 оюутныг хамруулан сургалтын дэмжлэг үзүүлсэн.	
155		155. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах	2022	Хяналт шалгалтад хамруу-лах иргэн	120, ААН-60	ОНТ	Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийлгэх 9754 хүсэлтийн дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан мах 15,6 мянган тонн, арьс, шир 35991 ширхэг, ноос, ноолуур 17,8 мянган тонн, 168375 толгой амьд мал, амьтанд эрүүл болохыг баталгаажуулан, 9618 ширхэг мал эмнэлгийн цахим гэрчилгээ олгож, шаардлага хангаагүй 136 хүсэлтийг зөвлөгөө, мэдээлэл өгч буцаасан. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны 33 аж ахуйн нэгжид 2, мал эрүүлжүүлэн тусгаарлах бүсэд 3, тахианы аж ахуй эрхлэгч 2, малын эмийн сангийн үйл ажиллагаанд 1, нийт 8 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулсан. Малын эрүүл мэндтэй холбоотой мэдлэг, мэдээлэл олгох 6 удаагийн шалган туслах, сургалтад 250 малчинг хамруулж, гарын авлага материалаар хангасан.
156		156. Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг зохион байгуулахад мал эмнэлгийн нэгж, малчдын хамтын ажиллагаа, үр нөлөөг дээшлүүлэн	2022	Өвчний төрөл Арга хэмжээний тоо Хамраг- далтын хувь	12  12	ОНТ	Малын гоц халдварт, халдварт 15 нэр төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх 15 удаагийн арга хэмжээг улсын төсвийн 150.9 сая төг, орон нутгийн 494,7 сая төг, малчдын 33,9 сая төгрөг, нийт 679,5 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 897,2 мянган толгой хамруулж, төлөвлөгөөг 100 хувь гүйцэтгэж хэрэгжүүлсэн.

		малын өвчлөлийг бууруулах			90	<p>Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх идэвхтэй үзлэг тандалтад 4467 өрхийн 1834728 толгой мал, 31 толгой зээр, идэвхигүй үзлэг тандалтад 1123 өрхийн 668332 толгой мал, 1000 толгой зээрийг хамруулсан. Аймаг, сум дамнасан отор нүүдэл, мал амьтны шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор давхардсан тоогоор 12 суманд 3 төрлийн гоц халдварт өвчин бүртгэгдэж, 1551 толгой мал өвчилсөн.</p> <p>Орон нутгаас малын гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох 10 удаагийн шуурхай арга хэмжээ хэрэгжүүлж, давхардсан тоогоор 190,3 мянган толгой малыг дархлаажуулалтад хамруулан 55,3 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. Мал эмнэлгийн төлөвлөгөөт дархлаажуулалтад 1,869,8 мянган толгой малыг технологит хугацаанд нь хамруулж, хэрэгжилт 100 хувьтай хангагдсан. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, түүхий эдийн чанар, гарал үүслийн гэрчилгээ олголтын талаар 39 удаагийн сургалт, арга хэмжээг хэрэгжүүлж, давхардсан тоогоор 7850 малчинд зөвлөгөө, мэдээлэл, 17500 гарын авлага материал олгосон. Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг 33 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, 4665 малчин өрхтэй хамтран ажиллах гэрээ байгуулан малчдын оролцоог нэмэгдүүлснээр, хамрагдалт 12 хувиар өсч, малын өвчлөлийг 0.5 хувиар бууруулсан.</p>	
157		157. Мал, амьтны	2022	Эмчлэн сэргий-		ОНТ	Мал, амьтны шимэгчтэх өвчний гаралт,

		шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэн, халдварт бус өвчний шалтгаан нөхцөлийг тодорхойлж эрүүлжүүлэх		лэх арга хэмжээ хамраг-далтын хувь  Үзлэг, тандалтад хамруу-лах малын тоо толгой, Шинжлэх дээжийн тоо	60  40000  1000		тархалтыг тодорхойлох, эрт илрүүлгийн үзлэг, тандалт, судалгаанд 3 сумын 83 өрхийг санамсаргүй түүврээр хамруулж, 19 өрхийн 2350 толгой буюу хамрагдсан малын 3,5 хувьд өвчин илрүүлсэн. Судалгааны дүнгээс үзэхэд малчид мал сүргээ шимэгчтэх мал эмнэлгийн арга хэмжээнд тогтмол хамруулаагүй, гарал үүсэл, хэрэглэх заавар тодорхойгүй эм бэлдмэл хэрэглэдэг зэргээс үүдэлтэй гэж үзэж, 528 малчин өрхөд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Байгаль цаг уурын нөхцөл, малын өвчлөлөөс шалтгаалан 1500 толгой мал зүй бусаар хорогдож, урьд оноос 4,5 дахин буурсан. Мал, амьтныг шимэгчлэх 3 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн арга хэмжээнд 1.2 сая толгой мал хамруулж, хамрагдалт 79 хувьтай явагдсан.
158		158. Мал амьтны зооноз, шинээр болон дахин сэргэж байгаа өвчний тандалт, шинжилгээг тогтмолжуулж, зарим төрлийн өвчингүй тайван бүсийг баталгаажуулах	2022	Тандалтад хамрагдах малын тоо  Шинжлэх дээжийн тоо-	20,0 мянга,  25 (мянга)	ОНТ	Мал амьтны зооноз халдварт Бруцеллёз өвчний тандалт, шинжилгээнд 14137 толгой мал хамруулж, 11,2 сая төгрөг зарцуулсан. Шинжилгээгээр 4 сумын 7 толгой хээлтүүлэгч буюу нийт хээлтүүлэгчийн 0,04 хувь эерэг гарсан. Шинээр болон дахин сэргэж байгаа ям, үхрийн сүрьеэ өвчний тандалтад 3200 толгой малыг хамруулсан. Мал эмнэлгийн лабораторийн төлөвлөгөөт шинжилгээнд адууны ям өвчний шинжилгээнд 1600, бруцеллёзын шинжилгээнд 14137, сүүний цагирган урвалын шинжилгээнд 110, үхрийн сүрьеэд 1600, асколын урвалын шинжилгээнд 120 толгой мал хамруулан, 30,0 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан. Аймгийн нутагт сүүлийн 3 жил ямааны годрон, үхрийн сүрьеэ өвчний тохиолдол бүртгэгдээгүй тул

							тус 2 төрлийн өвчнөөр тайван бүс нутгаар баталгаажуулсан.
159	3.4.1. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлнэ.	159. Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, жуулчдын тоог 3 хувиар нэмэгдүүлэх	2022	Жуулч-дын тоо	21630	ОНТ	<p>“Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-г 93 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, мэргэжлийн холбоодтой хамтран танхимын 4 удаагийн сургалт, 2 удаагийн хэлэлцүүлэг, цахим 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1800 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилт, үйлчилгээний стандарт, зочлох үйлчилгээ, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдлэг, мэдээллийг дээшлүүлсэн.</p> <p>Аялал жуулчлалын бүс нутгуудаар гадаад, дотоодын жуулчид аюулгүй, тав тухтай аялах, орчин үеийн стандартад нийцсэн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авто зам, аяллын маршрут, үзвэрүүдийн тайлбар бүхий тэмдэг, тэмдэглэгээ 15 ширхэг, 6 боловсон ариун цэврийн байгууламж, 11 сандал, сүүдрэвчийг шинээр болон засаж сайжруулсан. “Аялал жуулчлалын бүс нутагт дагаж мөрдөх журам”-ын төслийг боловсруулан 14 сум, холбогдох байгууллага, иргэдээр хэлэлцүүлэн санал авсан. “Шамбалын орон”, “Хамарын хийд”, “Ханбаян зүрх хайрхан уул”-ын чиглэлд гадаадын 718, дотоодын 90630, нийт 91348 жуулчин аялаж, аялагчдын тоо урьд оноос 4 дахин нэмэгдсэн.</p>
160		160. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын	2022	Цахи-маар хүргэх мэдээллийн тоо	5	ОНТ	<p>“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд <a href="http://www.touristinfocenter.mn">http://www.touristinfocenter.mn</a>, <a href="https://joinme.mn/">https://joinme.mn/</a> цахим сайтуудад орон</p>

		бүтээгдэхүүн үйлчилгээг шинэлэг байдлаар сурталчлах					нутгийн аялал, жуулчлалын гол бүс нутгуудын танилцуулга, шашин мөргөлийн зан үйл, онцлог, давуу тал, үйлчилгээний газруудын байршил, бүтээгдэхүүн үйлчилгээ, тээврийн хэрэгслийн цагийн хуваарь, зардлын тарифыг дэлгэрэнгүй байршуулж, жуулчид нэг дороос мэдээ, мэдээлэл, аяллын дараа төлбөрт үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж 82000 гаруй хандалт авсан. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Ай Ти Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд "Хамарын хийдийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ, "Далт мөнгөн шанд" ХХК, Хамарын хийдийн гэр буудал, жуулчны бааз, гар урлалын 15 төлөөлөл оролцож орон нутаг, онцлог бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчилсан ба үзэсгэлэнг зорин ирсэн зочид төлөөлөгчдөд 2700 ширхэг танилцуулга, гарын авлага хүргэж, Улаанбаатар хотын аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 10 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан.
161	3.5.1. Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ.	161. Сайншанд сумын дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгааны ажлыг хийх	2022	Судал-гааны ажил	50%	ОНТ	Сайншанд сумын дулааны станц уур үйлдвэрлэх зориулалттай KE-25-14C маркийн 3 зуухтайгаас 2 болон 3 дугаар зуухыг эдийн засгийн үр ашигтай, эрчимжүүлсэн буцлах давхаргын шаталтат KB-P23,26-150/70 маркийн зуухаар шинэчлэх судалгааны ажил хийгдэж, урьдчилсан байдлаар 4,9 тэрбум төгрөг шаардлагатай тооцоо гарсан.
162		162. Сайншанд сумын цэвэр усны нөөцийн	2022	Гүйцэт-гэлийн хувь	50	ОНТ	Улсын төсвийн 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд хоногт 3000 м3 ус



		савыг өргөтгөж усан хангамжийг сайжруулах					нөөцлөх хүчин чадалтай цэвэр усны нөөцийн сан байгуулах ажлыг "Энержи парагон" ХХК гүйцэтгэн, нөөцийн савны угсралтын ажил-100%, хлоржуулалтын төхөөрөмж суурилуулах ажил-100%, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил 100%-тай гүйцэтгэсэн. Нийт ажлын гүйцэтгэл 95 хувьтай бөгөөд ашиглалтад хүлээлгэж өгөхөөр бэлтгэл ажлыг хангасан.
163		163. Сайншанд, Замын-Үүд сумдад ЦДАШ солих, дэд станц байгуулах, шинэчлэх ажлыг хийх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	"Дэлхийн банкны эрчим хүчний төсөл 2"-ын хүрээнд Сайншанд суманд 10кВ-ын 9,2 км, 0.4 кВ-ын 45 км ЦДАШ, 10 кВ-ын 1,1 км, 0.4 кВ-ын 2,3 км кабель шугам шинэчлэх, 10/0.4 кВ-ын 400 кВа хүчин чадалтай иж бүрдмэл дэд станц угсрах ажлыг "Биндэг норов" ХХК, Замын-Үүд суманд 0,4 кВ-ын тоолуурын хайрцаг 532 ширхэг, 250 кВ-ын дэд өртөө 2 ширхэг, 0,4 кВ-ын ЦДАШ-ын сип дамжуулагч 20 км, кабел шугам 500 метрийг "Саруул өргөө" ХХК тус тус гүйцэтгэн, 95%-ийн гүцэтгэлтэй. Төсөл хэрэгжсэнээр цахилгаан түгээх компаниудын цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулж, эдийн засгийн чадавхыг сайжруулах, техникийн найдвартай ажиллагааг хангах боломжийг нэмэгдүүлсэн.
164	3.6.1. Зам, тээврийн сүлжээг байгуулж, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	164. Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас шаардагдах дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах	2022	Хамтран ажиллах арга хэмжээ-ний тоо	5	ОНТ	Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Боомтын сэргэлтийн хүрээнд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг барих ажилд орон нутгаас шаардлагатай дэмжлэгийг үзүүлж хамтран ажилласан. Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км шинэ төмөр замын төсөлд төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажилд

						шаардагдах түгээмэл тархацтай ашиг малтмал ашиглах зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2022 оны А/204, А/369, А/624 тоот захирамжаар нийт 232 байршилд тус тус олгосон. Төмөр замын угсралтын ажил бүрэн дуусч улсад хүлээлгэн өгөх нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад хамтарч ажиллав. Төмөр зам ашиглалтад орсоноор манай улсын импорт, экспортын бараа бүтээгдэхүүний нэвтрэх хүчин чадал 20 сая тонноор, төмөр замаар тээвэрлэж байгаа нийт тээврийн хэмжээ 65 хувиар нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүнээ илүү дөт, бага зардлаар дэлхийн зах зээлд хүргэх боломжийг бүрдүүлсэн.
165		165. Сайншанд сумын авто замыг өргөтгөх судалгааны ажлыг хийж, авто зам, замын байгууламжид засвар шинэчлэлт хийж, шинээр барих	2022	Барил-гын ажлын гүйцэтгэлийн хувь	100	ОНТ Замын сангийн 578.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд сумын 2 дугаар сургуулийн хойд талын автозамыг Офицерийн төв замтай холбох 0.577 км автозам барих ажил, 267.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр 2 дугаар сургуулийн хойд талын автозамын асфальтан хучилт хийх ажил, 106.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр Шинэ зууны 33-р байрны гадна авто зогсоол байгуулах ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 391.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр Шинэ халдвартын эмнэлэг болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна авто зогсоол байгуулах ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 1989.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 7 дугаар багт "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш

						<p>үргэлжилэх 1.59 км авто зам барих ажил, ОНТ-ийн 322.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр 7 дугаар багийн "Мандах наран" хороолол хүртэл 0,141 км авто замыг "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 62.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр 233, 245-р байрны баруун талаар автозам барих ажлыг "Айсуй хөгжил" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсөв, Замын сангийн 3717.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7 байршилд шинээр автозам, авто зогсоол барих ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	
166		<p>166. Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто замаас Өргөн сум хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл 18.25 км автом замыг барих</p>	2022	<p>Барил-гын ажлын гүйцэтгэлийн хувь</p>	75	ОНТ	<p>Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто замаас Өргөн сум хүртэлх хатуу хучилттай автозам үргэлжлүүлэн барих ажлыг улсын төсвийн 3664.9 сая төгрөгийн төсөвт өртөгөөр 9.3 км хатуу хучилттай авто замыг шинээр барих ажлыг "Дорноговь-АЗЗА" ТӨХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан. Уг гэрээт ажлын хүрээнд 2022 онд улсын төсөвт батлагдсан 355.4 сая төгрөгийн санхүүжилтээр 3.2 км авто замын далан шороо, ухмал, хөвөө өргөсгөх, түвшингийн зөрүү гаргах зэрэг ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн.</p>
167		<p>167. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	2022	<p>GPS суурилуулсан автобусны тоо</p>	2	ОНТ	<p>Сайншанд сум доторх нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй 3 автобусанд GPS, түлш хэмжигч суурилуулах ажлыг "Гайхам" ХХК-аар гүйцэтгэж 3.2 сая төгрөгийг зарцуулан хүлээн авсан. Сайншанд сум дотор нийтийн тээврийн үйлчилгээг Дэнжийн малчны байр-3-р сургууль, Өндөр дов-</p>

							Жанчивын хороолол гэсэн маршрутаар явуулж 3801 том хүн, 6773 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн.
168	3.7.1. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно.	168. Газар зүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах	2022	Мэдээл-лийн санд мэдээ-лэл оруулах сумын тоо	3	ОНТ	Аймгийн 14 сумын 65 багийн оноосон нэрийг сумдын ИТХ-ын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн 09/05 дугаар тогтоолоор батлуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн. Газар зүйн нэрийн тодруулалт хийх мэдээллийн сан байгуулах ажлыг эхлүүлж, 14 сумын газар зүйн нэрийн зургийн 9131 мэдээллийг геопортал цахим системийн <a href="http://192.168.10.17">http:192.168.10.17</a> серверт байрлуулсан. Ортофото зурагт оруулах ажлыг гүйцэтгэж дууссан.
169		169. Устсан геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж, геодезийн хэмжилт, зураглал хийх ажлыг эхлүүлэх	2022	Сэргээх цэг тэмдэгтийн тоо	5	ОНТ	Сайншанд суманд байрлах DOG1, Замын-Үүд суманд байрлах DOG2 нэртэй станцуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. Төрийн өмчийн үзлэг тооллогын ажилтай хамтатган нийт сумдын төвийн геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг хийж Айраг суманд 53, Алтанширээ суманд 5, Даланжаргалан суманд 9, Дэлгэрэх суманд 8, Замын-Үүд суманд 9, Иххэт суманд 13, Мандах суманд 30, Өргөн суманд 15, Сайхандулаан суманд 20, Сайншанд суманд 25, Улаанбадрах суманд 18, Хатанбулаг суманд 30, Эрдэнэ суманд 11, Хөвсгөл суманд 15 ширхэг нийт 261 цэг тэмдэгт бүр мөсөн устсан, нөхөн сэргээх шаардлагатайг судлан гаргасан. Замын-Үүд суманд 1, Сайншанд суманд 1 геодезийн цэг тэмдэгтийг

							орон нутгийн төсвийн 3.0 сая төсөвт өртгөөр сэргээсэн
170	3.7.2. Иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн болон газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг орон нутагт нэвтрүүлнэ.	170. Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг газрын үнэлгээний системд оруулан, дүн шинжилгээ хийх	2022	Үнийн мэдээний тоо	1645	ОНТ	<p>Газрын үнэлгээний цахим системд инженерийн болон хүрээлэн буй орчны, нийгмийн дэд бүтцийн 462 мэдээллийг оруулж, 36163 нэгж талбарт үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн утга бодуулан дүн шинжилгээ хийсэн.</p> <p>Үнийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 1 м2 газрын зах зээлийн дундаж үнэлгээг гаргахад гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар 11076 төгрөг, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газар 62298 төгрөг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газар 3000 төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнэ 54 хувиар өссөн, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйгаас бусад зориулалттай газар 6.6 хувиар буурсан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газрын зах зээлийн үнэ өмнөх хэвээрээ байгаа судалгааны үр дүн гарсан. Газрын биржийн цахим системд 148 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг бүртгэсэн.</p>
171		171. Газрын бүртгэлийн нэгдсэн системд эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгогдсон газруудыг бүрэн хамруулж, нөхөн бүрдүүлэлт хийх	2022	Нөхөн бүрдүүлэл-тийн ажлын гүйцэтгэлийн хувь	95	ОНТ	Газар олгох захирамж шийдвэр гарсан хэдий ч газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдээгүй иргэн хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг системд бүртгэж, нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хүрээнд "Цахим газрын харилцаа-2022" 2 сарын аяныг зохион байгуулж, иргэд олон нийтэд мэдээлэл

						хүргэснээр нөхөн бүрдүүлэлтээр оруулах шаардлагатай нийт 601 нэгж талбараас 597 нэгж талбар буюу 99,3 хувийг бүртгэсэн.	
172		172. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг нэвтрүүлэх, боловсронгуй болгоход хамтран ажиллах	2022	Системд оруулах мэдээллийн хувь	100	ОНТ	Тухайн шатны Засаг даргын шийдвэрээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон нийт 12197 нэгж талбарт 4251.36 сая төгрөгийн газрын төлбөр, 11488 нэгж талбарт 28.1 сая төгрөгний албан татварыг бүрэн ногдуулж нэхэмжлэх үүсгэж татварын удирдлагын системд илгээн төлөгдсөн нэхэмжлэхийн судалгааг газрын төлбөр, татварын системтэй тулган нийт 310 төлөгдсөн нэхэмжлэхийн төлөв өөрчлөгдөөгүй байсныг өөрчлөн шинэчилсэн. Сумдын удирдлага холбогдох мэргэжилтнүүд 59 албан хаагчдыг оролцуулан цахим хурал зохион байгуулж, газрын төлбөр татварыг нэгдсэн системээр дамжуулан ногдуулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан.
173		173. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг нэвтрүүлж эхлэх	2022	Систем нэвтрүүлэх хувь	60	ОНТ	Газар зохион байгуулалтын болон газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн иргэд, олон нийтэд зориулсан цахим систем /www.egazar.gov.mn/-ээр дамжуулан 72 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлж иргэн, хуулийн этгээдээс нийт 161 хүсэлт цахимаар ирүүлснийг хянаж, 146 өргөдлийг шийдвэрлэсэн. Бүрдэл дутуу 12 өргөдлийг зөвлөмж өгч буцаан, 3 өргөдөл судлагдаж байна. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн системээр дамжуулан 148 иргэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгсөн. Цахим системээр газрын эрх шилжүүлэх,

						газрын эрхийн хугацаа сунгах, газрын зориулалт өөрчлөх, газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах, төлөвлөгөөнд санал өгөх, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн мэдээлэл болон газрын төлбөр, татвар цахимаар төлөх, цахим дуудлага худалдаанд оролцох зэрэг зөвлөмж өгч "Цахим газрын харилцаа-2022" 2 сарын аян, 235 удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн нийт 18349 иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.
174	3.7.3. Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлого хэрэгжүүлнэ.	174. "Мандах наран-5" орон сууцны хорооллын төслийг үргэлжлүүлэн, ашиглалтад хүлээн авах	2022	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	ОНТ <p>"150 мянган айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд "Мандах наран-5" хорооллын 1152 айлын орон сууцны төслийг "Гантулга трейд" ХХК хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж Сайншанд сумын 7 дугаар багт эхний ээлжийн 384 айлын орон сууцны барилгыг гүйцэтгэж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 75%-тай байна. Уг орон сууцны хороололд 11.2 МВт-ын халаалтын зуухны эх үүсвэр, гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ шинээр барих ажлыг орон нутгийн төсвийн 10.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Чандмань-Илч" ХХК гүйцэтгэж байгаа ба гадна шугам сүлжээ, цэвэр, бохир усны нөөцийн сангийн барилга угсралтын ажлууд бүрэн дууссан. Зуухны барилга угсралтын ажлын явц 50%-тай байна.</p> <p>Мөн гадна цахилгаан хангамж 10/0.4кВ-ын 2х630кВА чадалтай иж бүрэн дэд өртөө, 10кВ-ын 3180м ЦДАШ, 1300м урт 10кВ-ын кабель шугам угсрах ажлыг ОНТ-ийн 519.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Гега тера" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж,</p>

						ЦДАШ, дэд станцын ажлуудыг гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 90%-тай.
175	175. Сайншанд суманд "Тохилог хотхон" орон сууц барих хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжих	2022	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөл-төд тусгаж батлуулсан байна.		ОНТ	<p>Сайншанд сумын гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж дахин төлөвлөх, төсөл хэрэгжүүлэх газрын байршлыг баталсныг үндэслэн Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсрууллаа. Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэр Нисэхийн хэсэгт 317 өрхийн 30.37 га газарт дахин зохион байгуулалт хийж, Орон нутгийн төсвийн 12.22 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны шугам, 1.59 км автозам, Өлзийт хорооллын айл өрхийг цахилгаанд холбох ажлыг хийж гүйцэтгэн шинээр суурьшлын бүс байгуулах ажлыг эхлүүлсэн.</p> <p>Дээрх суурьшлын бүсэд "Мандах наран-5" орон сууцны хороолол, "Саран хөхөө" театрын барилга, төвлөрсөн хангамж бүхий амины орон сууцны хороолол, төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор, Ерөнхий боловсролын сургууль зэрэг барилга бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Сайншанд суманд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийн зөвшөөрлийг 114 иргэнд олгож 63 иргэн өөрийн хөрөнгөөр төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон.</p>
176	176. Түрээсийн орон сууц	2022	Барилга	100	ОНТ	"Мандах наран 5" орон сууцны төслийн



		төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах		угсралтын гүйцэтгэ-лийн хувь  Хамрагдах өрхийн тоо-	144		<p>хүрээнд баригдаж буй барилга байгууламжуудын дэд бүтцээр хангах ажлын хүрээнд 11.2 МВт-ын халаалтын зуухны эх үүсвэр, гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ шинээр барих ажлыг орон нутгийн төсвийн 10.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Чандмань-Илч” ХХК гүйцэтгэж гадна шугам сүлжээ, бохир усны насос станц, бэвэр усны насос станцын барилгын угсралтын ажлуудыг бүрэн дуусгасан ба зуухны барилгын угсралтын ажлын явц 50%-тай гүйцэтгэсэн.</p> <p>Орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамж 10/0.4кВ-ын 2х630кВА чадалтай иж бүрэн дэд өртөө, 10кВ-ын 3180м ЦДАШ, 1300м урт 10кВ-ын кабель шугам угсрах ажлыг ОНТ-ийн 519.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Гега тера" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж, ЦДАШ, дэд станцын ажлуудыг гүйцэтгэсэн ба ажлын гүйцэтгэл 90%-тай байна. Дээрх орон сууцнаас 144 айлын орон сууцыг түрээсийн орон сууц болгон зорилтот бүлгийн иргэдийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 75 хувьтай.</p>
177	3.7.4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын	177. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах	2022	Цэвэр-лэх байгууламжийн барил-гын ажлын гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	<p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 6350.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж,</p>

	дэвшилтэт технологи нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.						2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэт цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой, цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулан бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламж болсон. Цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор Сайншанд хотын дэд бүтцийг хөгжүүлэх, оршин суугчдын тав тухтай амьдрах орчныг нэмэгдүүлэх, орон нутгийн байгаль орчныг сайжруулж, хөрсний бохирдлыг бууруулах, цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах боломж бүрдсэн.
<b>Дөрөв. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
178	4.1.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим хэрэгслийг нэвтрүүлнэ.	178. Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулах	2022	Шинээр цахим систем нэвтрүүлэх байгууллагын тоо	28	ОНТ	Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг нэмэгдүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулахаар “Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”-ийг төрийн болон төрийн өмчит 125 байгууллагад нэвтрүүлэн албан бичиг солилцох, өргөдөл гомдол бүртгэх, цаг бүртгэл хөтлөх байдлаар ашиглаж байна. Цахим хэрэглээг нэмэгдүүлж чадавхжуулахаар “Цахим шилжилт” сургалтыг 14 удаа зохион байгуулж 340 албан хаагчдыг хамруулж ажилласан.
179		179. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, интернетийн зохистой	2022	Цахим гарын үсэгтэй албан хаагч-дын тоо	35	ОНТ	“Хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй

		хэрэглээг бий болгох чиглэлээрх төрийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх, хяналт тавих		МАБ журмын хэрэгжилтийн хувь	80		<p>холбогдуулж 48 байгууллагын 1886 албан хаагчдын цаг бүртгэх, үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл шалгах зорилгоор цуглуулсан биометрик мэдээллийг бүртгэсэн 102 төхөөрөмжийн мэдээллийг устгаж холбогдох дээд шатны байгууллагад тайлан мэдээг хүргүүлсэн.</p> <p>Төрийн 13 байгууллагын 151 албан хаагч тоон гарын үсгийг лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргүүлэх байдлаар албан ажилдаа ашиглаж байна. Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж нийт иргэдийн 19,1 хувь буюу 1915 иргэнийг тоон гарын үсэгтэй болгосон. "Кибер аюулгүй байдлын тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж "Цахим Дорноговь" хөтөлбөрт мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, байгууллагын мэдээлэл алдагдах, гадны халдлагаас хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах заалтыг тусган ажилласан.</p> <p>Төрийн байгууллагын мэдээлэл технологи хариуцсан албан хаагчдад мэдээллийн аюулгүй байдлыг хангах, upgrade тест болон "Кибер аюулгүй байдлын тухай хууль", "Хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль"-ийн талаарх 10 удаагийн сургалтаар дамжуулан нийт 180 албан хаагчдыг хамруулж заавар, зөвлөмж өгч чадавхжуулсан.</p>
180	180. Төрийн байгууллага хоорондын болон төр,	2022	Цахим үйлчилгээ-ний	95 ТҮНМТ-1	ОНТ	Аймгаас үзүүлж буй төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэхээр аймгийн Засаг даргын	

		<p>хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн солилцоог сайжруулж, төрийн үйлчилгээний цахим хэрэглээг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн төв байгуулах</p>		<p>тоо</p>		<p>2022 оны А/168 дугаар захирамжаар цахим шилжилт, цахим засаглалыг орон нутагт нэвтрүүлэхээр 5 салбарын чиглэлээр 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ерөнхий ажлын хэсэг, 39 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсгүүдийг байгуулсан.</p> <p>Ажлын хэсгүүд 2 удаа хуралдаж төрийн 15 байгууллагуудын 73 үйлчилгээг “төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем”-д оруулж, цахимаар шийдвэрлэж хариу илгээх сургалт, “Төрийн үйлчилгээг цахимаас” сэдэвт төрийн цахим үйлчилгээг сурталчлах өдөрлөг зохион байгуулан ажилласан.</p> <p>Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор 14 сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоонд өөрчлөлт оруулж олон нийттэй харилцах, төрийн цахим үйлчилгээний ажилтаны орон тоог бий болгож тухайн суманд төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг цахим аар үзүүлэх операторын үйлчилгээ, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааний хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллуулж байна. Төрийн үйлчилгээний лавлах суурин утсыг ажиллуулан “call center” үйлчилгээгээр дамжуулан нэг дороос төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 642 дуудлагад хариу өгч ажилласан. Төрийн цахим үйлчилгээг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдээр 21 постер, 6 видео шторк</p>
--	--	---	--	------------	--	---

						бэлтгэн байршуулсан. 14 сумдын ЗДТГ-аар дамжуулан нийт 1650 гарын авлага, 640 зурагт хуудсыг аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийн самбаруудад байршуулсан. Мөн “Өнөөгийн Дорноговь сонин” Засаг даргын хийсэн ажлын сэтгүүлд нийт 12 постер, мэдээлэл байршуулан 5500 ширхэг хэвлүүлж иргэдэд хүргэсэн.	
181		181. Төр засаг, орон нутгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах, хүргэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх	2022	Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэг-дүүлэх арга хэмжээ-ний тоо, цахим хаягтай болох сум, агентлагийн тоо	20	ОНТ	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг олон нийтэд сурталчилж, ашиглалтыг нэмэгдүүлж, иргэдэд танилцуулах зорилгоор “Цахим Дорноговь” өдөрлөгийг “Төрийн үйлчилгээг цахимаас - цаг хэмнэх цахим үйлчилгээ” уриатайгаар Сайншанд, Замын-үүд суманд төрийн 24 байгууллагатай хамтран зохион байгуулж, 278 үйлчилгээг 3100 иргэнд төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан үзүүлж, заавар, зөвлөмжийг өгсөн. Мөн ашиглалтын талаарх мэдээлэл хүргэх сургалтыг 16 удаа зохион байгуулж нийт 2,145 иргэнд мэдээлэл хүргэсэн. Цахим орчинд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан 83 постер, видео шторк мэдээллийг байршуулж нийт 84160 хандалт авсан. Төрийн байгууллагын мэдээ мэдээллийг цахимаар дамжуулан авах нөхцөлийг бүрдүүлэн 12 сум, 18 агентлаг байгууллага албаны цахим хуудасай болсон.
182	4.1.2. Төрийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулна.	182. Замын-Үүд суманд багийн иргэдийн хөгжлийн төв барих, Айраг, Сайхандулаан сумдын ЗДТГ-ын	2022	Шинээр Барих  Засвар үйлчилгээ хийх	1  2	ОНТ	Замын-Үүд суманд Иргэдийн хөгжлийн төв барих ажлыг ОНТ-ийн 796,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр "Мандах наран сүлжээ" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан, барилгын үндсэн хийц бүтээц, гадна, дотор

		барилгыг засварлах		барилгын тоо		шавардлагын ажил, цонх суулгах ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 70%-тай байна. Айраг сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлыг ОНТ-ийн 289.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр "Энержи парагон" ХХК гүйцэтгэж 7 дугаар сард ашиглалтад оруулсан. Сайхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын барилгын цахилгаан сантехникийн засварын ажлыг ОНТ-ийн 98.9 сая төгрөгийн төсөвт өртгөөр "Эргэл хийц" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Барилгын дотор цахилгаан, сантехникийн засварын ажил бүрэн дуусч, халаалтын зуух шинэчлэх ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 90%-тай байна.
183	4.1.3. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой тодорхойлж, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллах тогтолцоог төлөвшүүлнэ.	183. Аймаг, сумын төсвийн эрх мэдлийн шинэчлэлийн хүрээнд орон нутгийн чиг үүргийн шинжилгээг хийж хуулийн хэрэгжилтийг хангуулах	2022	МУЗЗНДНТУТХ хэрэгжиж эхэлсэн байна.	ОНТ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар төрийн захиргааны албан тушаалын ажлын байранд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулан 39 төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны шинжилгээг асуулгын аргаар авч 3 албан тушаалын чиг үүргийг салгаж, 2 албан тушаалын чиг үүргийг өөрчилж, 3 албан тушаалыг шинээр бий болгон, үйл ажиллагааны давхардал, хийдэлгүй байхаар шинэчлэн, сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд чиг үүргийг шинжилгээ хийсний үндсэн дээр аймгийн Засаг даргын 2022 оны А/230 дугаар захирамжаар дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын ангилал зэрэглэлийг өөрчлөн төрийн цахимаар хүргэх операторын үйлчилгээ, сумын ЗДТГ-ын архив, албан хэрэг

						хөтлөлтийн ажлыг хариуцуулахаар жишиг албан тушаалын тодорхойлолт боловсруулан баталсан. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог жишиг байдлаар баталсантай холбогдуулан аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2022 оны А/340 дүгээр захирамжаар баталж давхардал, хийдлийг арилгасан. Сайншанд, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг хүргүүлж тус сумдын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг чиг үүргийн шинжилгээг асуулга, ажлын байрны зураг авалтын аргаар хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан ирүүлснийг сумын Захирагчийн ажлын алба, хот тохижилтын байгууллагыг нэгтгэх замаар чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.
184	184. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, төр, иргэний хамтын ажиллагааны оновчтой арга хэрэгслийг нэвтрүүлэх	2022	-Иргэ-дийн өргөдөл, гомдлын тоо, бараг-дуулалтын хувь  Төрийн байгууллагуу-дын	95%	ОНТ	Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж, 2022 оны байдлаар нийт 6145 өргөдөл, гомдол ирүүлснээс 5910 өргөдлийг нь хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч 193 өргөдөл хугацаа болоогүй судлагдах шатанд байна. Хуулийн хугацаа хэтрүүлсэн өргөдөл, гомдол байхгүй бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлт 94.3 болсон. Өргөдөл гомдлыг агуулгаар нь эрэмбэлвэл газар өмчлөл, эзэмшилтэй холбоотой

				талаарх иргэдээс авах судал-гааны үр дүнг тооцсон байна. -ТББ-аар гүйцэтгүүлэх ажлын тоо			<p>асуудлаар 28,8%, ажилд орох, томилуулах, чөлөөлөгдөх, чөлөө хүсэх асуудлаар 2,3%, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамжийн асуудлаар 1,6%, орон гэр, мөнгө санхүүгийн дэмжлэг хүссэн асуудлаар 1,1%, талархал илэрхийлэх асуудлаар 0,8%, төрийн албан хаагчийн ёс зүй, хүнд суртлын асуудлаар 0,8%, саналын шинжтэй 2,6%, бусад 98,2%байсан.</p> <p>Өргөдлийг хэлбэрээр нь авч үзвэл 6145 нь бичгээр, 58 нь утсаар, 164 нь Засгийн газрын мэдээллийн 1111 төвөөр дамжин ирүүлсэн байсан. Цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг хүргэхээр аймгийн 15 төрийн байгууллагын 73 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлж нийт 353 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж нийт 310017 удаа гаргаж үйлчилсэн. Аймгийн ахмадын холбоо, эмэгтэйчүүдийн холбоо, залуучуудын холбоо зэрэг төрийн бус байгууллагууд, сургалт мэдээллийг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 төрийн бус байгууллагатай хамтран иргэд, төрийн албан хаагчдыг мэргэшүүлж ажиллалаа.</p>
185	185. Орон нутгийн бодлого шийдвэр боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн саналыг цахимаар авах, төрийн	2022	Иргэ-дийн оролцооны хувь	15%	ОНТ	<p>“Ханбаянзүрх хайрхан уул, Хамарын хийд орчмын тусгай хамгаалалттай газрын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч, аялагчдын нийтээр дагаж мөрдөх журам”-ын төслийг боловсруулан аялал жуулчлалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар тус бүсэд үйл ажиллагаа явуулдаг</p>	



		<p>үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулах</p>				<p>иргэд, аж ахуй нэгжийн төлөөллийг оролцуулсан 2 удаагийн хэлэлцүүлэг болон аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, агентлаг, сумдаас санал авах ажлыг тус тус зохион байгуулснаас гадна нийт 355 иргэдээс цахим болон цаасан хэлбэрээр аялагчдын сэтгэл ханамжийн судалгаа авч журмын төсөлд нийцүүлэн боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулах бэлтгэл ажлыг хангасан. "Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" захирамжийн төслийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, сумдад хүргүүлэн, нийт 1174 иргэдээс аймаг, сумдуудын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг иргэдэд танилцуулан цаасаар болон цахимаар авч эрэмбэлэн хэлэлцүүлэг зохион байгуулж нэн шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллалаа.</p> <p>Төрийн үйлчилгээний лавлах суурин утсыг ажиллуулан “call center” үйлчилгээгээр дамжуулан нэг дороос төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 942 дуудлагад хариу өгч ажилласан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/681 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргаар ахлуулсан 44 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 14 суманд ажиллаж төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрийн талаар мэдээлийг 3681 иргэнд өгч, нэгдсэн өдөрлөгөөр дамжуулан төрийн</p>
--	--	---	--	--	--	--

							үйлчилгээг 3498 иргэнд үзүүлж ажилласан. Энэ үеэр бичгээр ирүүлсэн 502, амаар ирүүлсэн 25 иргэний асуулт, саналд хариу өгсөн.
186	4.1.4. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.	186. Төрийн байгууллагын хүний нөөцийн аудитыг хийж, чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх	2022	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	ОНТ	Төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах болон бусад хүний нөөцтэй холбоотой асуудлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/248 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтаар хууль бус томилгоо нийт албан хаагчийн 5-8 хувийг эзэлж байгаа нь илэрсэн. Төрийн албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлөхдөө нотлох баримт бүрдүүлдэггүй, сул орон тоо гарсан тухай тушаал шийдвэрийн бүрдэл хууль эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн, ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ бодит үр дүнг харгалздаггүй, ялгавартай үнэлж, дүгнэсэн, нөөцийн мэдээллийг тухай бүр нь мөн сул орон тоо гарсан тухай мэдээлэл, сул ажлын байрны захиалгыг Төрийн албаны тухай хуульд заасан хугацаанд Төрийн албаны салбар зөвлөлд мэдээлдэггүй, нуун дарагдуулдаг зэрэг зөрчлүүд гарсан. Шалгалтын үр дүнгээр гарсан зөрчлийг хууль тогтоомжийн дагуу арилгах арга зүй, чиглэл өгч

						<p>ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулж 93 иргэн тэнцэн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн. Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх, туслах албан тушаалыг нөхөхөөр 12 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж 98 сул орон тоог нөөцөөс болон шатлан дэвшүүлэх замаар нөхсөн. Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг нөхөхөөр 2 удаа төрийн үйлчилгэний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 7 сул орон тоог нөхсөн.</p>
187		<p>187. Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, шинэ соёлыг төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлэх</p>	2022	Зохион байгуулах ажлын тоо	4	ОНТ <p>Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын дэргэд 51 ёс зүйн зөвлөл ажиллаж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар 7 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн.</p> <p>Төрийн албанд шинээр томилогдсон 72 албан хаагч, Алтанширээ сумын 84 албан хаагч, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын харъяа төсөвт байгууллагын 400 албан хаагч, Сайншанд сумын 13 цэцэрлэгийн 104 албан хаагч, 50 хүний нөөцийн мэргэжилтэн, 9 агентлаг дарга, 8 хэлтэс, тасгийн дарга, 26 мэргэжилтэн, 13 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, хууль эрх зүйн асуудал хариуцсан 26 албан хаагч буюу давхардсан тоогоор нийт 779 төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйтэй, цогц чадамжтай, шинийг санаачлагч байх, манлайлагч төрийн</p>

						<p>албан хаагчийг бэлтгэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх сургалтыг хийж ажиллалаа. Иргэн, хуулийн этгээдтэй харилцах, тэдэнд үйлчилгээ үзүүлэхдээ төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний үндсэн шаардлагыг тогтоож хэвшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/686 дугаар захирамжаар "Дорноговь аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний стандарт"-ыг шинэчлэн баталж мөрдүүлж эхэлсэн. Стандартаар төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, харилцаа, ёс зүй, хувцаслалт зэргийн стандартын тодорхой тусгасан. Аймгийн Засаг даргын 2021 оны "Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа, хандлагыг дээшлүүлэх" 01 тоот албан даалгавар гаргаж хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>14 сум, Засаг даргын эрхлэх хүрээний 28 агентлаг албан даалгаврын хүрээнд ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж үр дүнг нь тооцон хэрэгжүүлсэн.</p>
188	188. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэшүүлж, чадавхжуулах тогтолцоог хөгжүүлэн хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх	2022	Нийг-мийн батал-гаа, сургал-тын орчныг сайжруулах хувь	70%	ОНТ	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газарт ухаалаг самбар, лед дэлгэц зэргийг байршуулж 120,0 сая төгрөг, 10 сум, 15 байгууллага сургалтын танхим байгуулж, засвар хийж, техник тоног төхөөрөмжөөр ханган 30,0 сая гаруй төгрөгийг тус тус зарцуулж цахим хурал, сургалт зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж албан хаагчдын суралцах орчныг сайжруулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/233 дугаар</p>

				Сургал-тад хамрагдах албан хаагчийн хувь	90	<p>захирамжаар 2022 онд зохион байгуулах сургалт, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөг 42 арга хэмжээтэй байхаар төлөвлөн баталж 40 сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж 100,0 сая гаруй төгрөгийг зарцуулж 200 гаруй төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь сурган чиглэл бүрээр мэргэшүүлж ажилласан.</p> <p>Удирдлагын академийн эрхэлсэн болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 12, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 22, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 32, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 40 албан хаагчийн мэдлэг ур чадварыг дээшлүүллээ. Төрийн анхан шатны нэгж дэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор "Төрийн бүтээмжийн сэргэлтийг хэрэгжүүлэх нь" сэдэвт Багийн Засаг дарга нарын нэгдсэн сургалтыг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулж 14 сумын 65 багийн Засаг даргыг хамруулж "Төрийн бодлого, нутгийн удирдлага", "бүртгэл, статистик", "төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх аргазүй", "хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь" бүлэг сэдвүүдээр цогц мэдлэг олгосон.</p> <p>Төрийн бодлого, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй боловсруулж, хэрэгжүүлэх болон төрийн алба, өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйл, мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэх зорилгоор "Дорноговь аймгийн төрийн захиргааны албан хаагчдын</p>
--	--	--	--	--	----	--

						ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах" аймгийн зорилтот хөтөлбөрийг боловсруулан төрийн албан хаагчдыг сургах, орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэтгэмж олгох зэрэг бодлогын зорилтыг тусган аймгийн ИТХ-н 2022 оны 09/01 тогтоолоор батлуулсан.	
189	4.2.1. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	189. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2022	Хил хамгаа-лах туслах хүчний зөвлө-лийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт  Дэмжлэгийн тоо	100%	ОНТ	<p>Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний нийт 7 зорилт, 45 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд хилийн цэргийн 0108 дугаар ангийн алба хаагчдын 28 айлын орон сууцны барилгын засвар, Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн алба хаагчдын орон сууцны гадна, дотор сантехникийн засвар, Хилийн цэргийн 0168 дугаар ангийн 0137 дугаар салбарын хариуцсан хэсгийг бүхэлд нь өндөр хүчин чадал бүхий камерын хамгаалалтад шилжүүлж "Цахим салбар" болгоход зориулж аймгийн Засаг даргын захирамжаар анги тус бүрт 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хилчдийн ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн байгууллагуудтай хамтран орон нутгийн төсвөөс нийт 160,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хилийн ангиудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг хийж</p>

						гүйцэтгэсэн. Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг сурталчлах, дотоодын цэргийн алба хаагчдын хуул, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гарч болох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хуульчид-Хилд” арга хэмжээг Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Тагнуулын ерөнхий газрын Дорноговь аймаг дахь хэлтэс, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар, Хатанбулаг сумын Сум дундын цагдаагийн тасаг, Хууль зүйн туслалцааны төвийн хуульчдын холбооны салбартай хамтран зохион байгуулж хилийн ангийн төв, болон цэргийн салбарын бие бүрэлдэхүүнээс гадна хил хамгаалах туслах хүчний гишүүд, хилийн суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын алба хаагчдад сургалт мэдээлэл, хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан
190	190. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах	2022	Паспортжуулалт хийх барил-гын тоо	2	ОНТ	Шинээр ашиглалтад оруулсан 1 аж ахуйн нэгж, 2 иргэний хүсэлтээр барилга байгууламжид чанар, аюулгүй байдлын түвшингээр хяналт хийж ногоон гэрчилгээг олголоо. Системийн холбогдох мэдээллийн санд үнэлгээг тухай бүр оруулж баяжилтийг хийж судалгаа бүртгэлийг хийж хэвшсэн. Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёл үйлчилгээний барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулах ажлын зардлын тооцоо судалгааг хийж байна.

191	4.2.2. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	191. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал болон судалгаанд суурилсан ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2022	Төлөвлөсөн ажлын Хэрэгжил-тийн хувь	100	ОНТ	<p>ГХУСАЗСЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 10 дэд бүлэг 50 арга хэмжээ бүхий заалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс нийт 530,0 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулан ажилласан. Орон нутгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт, хэрэг, зөрчилд сар, улирал тутамд дүн шинжилгээ хийж өсөлттэй гэмт хэргийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүллээ. “Иргэдээ сонсьё”, “Хүүхэд хөгжил-2022”, “Нээлттэй хаалганы өдөрлөг” зэрэг 28 өдөрлөг, улс болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэн.</p> <p>“Хүүхэд бүр хайрлагдах эрхтэй”, “Соёлтой жолооч, соёлтой зорчигч”, “Намайг алгас”, “Сэрэмжлүүлье” зэрэг 20 гаруй төрлийн нөлөөллийн аян, “Авлигаас урьдчилан сэргийлэх дэвжээ”, “Өсвөрийн сэргийлэгч-2022”, “Ногоон гэрэл цагаан шугам” зэрэг 10 төрлийн тэмцээн уралдаан, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллээр дамжуулан төрийн болон хувийн 9450, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3200, малчин 8300, оюутан 2300, сурагч 3680, ажилгүй 125,0, (цахим орчинд давхардсан тоогоор 430,0 мянга иргэдэд түгээсэн) нийт 345,0 мянга гаруй иргэдэд хууль, эрх зүйн мэдлэг олгосон.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах хүрээнд нийт 200 гаруй албан мэдэгдэл хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан. Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт</p>
-----	--	---	------	-------------------------------------	-----	-----	--



						аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг камерын нэгдсэн хяналтад бүрэн оруулснаас гадна бусад сумдаас 120,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар камержуулалт, 350,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэрэлтүүлэг шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж иргэд, оршин суугчдын амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд 12 сарын байдлаар нийт 621 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үе /490/-с 131 буюу 26,7 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 66,1 хувь байгаа нь өмнөх оны мөн үе /54,7/-с 11,4 хувиар өссөн.
192		192. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг төрийн бус байгууллага, үүрэн холбооны аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	2022	Төлөвлөх ажлын хэрэгжилтийн хувь	100	ОНТ <p>“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийн 3 зорилт 12 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Нийт 25 эрх зүйн хөтчийг гарын авлага, материалаар хангаж 14 сумын Засаг дарга болон холбогдох 3 агентлагийн дарга нартай хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.</p> <p>Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран нийт 15 эрх зүйн хөтчийг шинээр эрх зүйн хөтөч бэлтгэх давтан сургах сургалтад хамруулж гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж үзүүлэх чиглэлээр мэдээлэл олгосныг үйл ажиллагаандаа</p>

						<p>хэрэгжүүлэн ажиллалаа. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, МҮЭХ, Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн зөвлөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран шинээр батлагдсан эрх зүйн актын талаарх сургалт мэдээллийг аймаг, сумдын дарга нар болон давхардсан тоогоор нийт 8200 гаруй төрийн албан хаагчдад хүргэж, тэдгээрийг чадавхжууллаа. Орон нутгийн телевиз, сонины газруудтай хамтран ажиллах гэрээ байгуулан 12 нэвтрүүлэг, 25 видео шторк, 80 гаруй төрлийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг иргэдэд хүргэснээс гадна төв зам дагуу автобусны зогсоол, аж ахуй нэгжүүдэд хууль, эрх зүйн мэдээлэл бүхий зурагт хуудсыг байршуулсан. Үүрэн холбооны аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран 3,5 сая төгрөгөөр гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрүүл мэнд, замын хөдөлгөөний аюулгүй байдал, цахим залилах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээллийг масс мессеж үйлчилгээгээр дамжуулан 68,0 мянган иргэнд хүргэсэн. Мөн нээлттэй хаалганы 2 удаагийн өдөрлөгийг зохион байгуулж 1200 гаруй иргэдэд тэмцээн, уралдаан, үзүүлэх тоглолт, хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Сурагчдад эрх зүйн боловсрол олгох ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс 7,5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж ерөнхий боловсролын 3 сургуулийн нийгмийн ухааны багш, нийгмийн ажилтантай хамтран</p>
--	--	--	--	--	--	--

						сурагчдад эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй, шинэлэг байдлаар хүргэн 100% хэрэгжүүлсэн.
193		193. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулах	2022	Төлөв-лөх ажлын хэрэгжилтийн хувь	100	ОНТ <p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4 зорилт 26 арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, 36,4 сая төгрөгийг зарцуулсан. Замын сангийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын холбогдох 4 газарт авто зам шинээр барих, 3 цэгт авто зогсоол шинээр барих, шинээр баригдсан автозамуудад 7 ширхэг хурд сааруулагч, 64 ширхэг замын тэмдэг тэмдэглэлээ байршуулах, Говьсүмбэр-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замын Өлзийт, 64, 30, 31, 35-р зөрлөг, Өргөн сумын уулзварын орчим зэрэг 10 цэгт 30 сая төгрөгийн санхүүжилтээр нойр сэргээгч дэржигнүүр байршуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд хүүхдүүд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 9,5 сая төгрөгийн санхүүжилтээр “Ногоон гэрэл, цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Өсвөрийн сэргийлэгч” зэрэг тэмцээн уралдааныг зохион байгуулж шилдгүүдийг шалгаруулан 21 сургууль, 13 цэцэрлэгийн 510 гаруй сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн мэдлэг олгосон. Улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Уусан бол бүү жолоод”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Соёлтой жолооч, соёлтой</p>

						зорчигч” зэрэг нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 10-15 удаагийн яриа таниулга, 120 гаруй төрлийн зурагт хуудас, 45 шторк, контент, подкаст ярилцлага, 93 төрлийн сургалт мэдээлэл болон жолоочид хүргэх 6000 ширхэг зурвас, 8000 ширхэг гарын авлага, тараах материалаар дамжуулан иргэдийг эрх зүйн боловсрол олгосноос гадна Олон нийтийн 6 цагдааг замын хяналт, шалгалт, хөдөлгөөн зохицуулалтад хүч нэмэгдүүлэн, нийт 40 алба хаагч 24 цэгийн байршилд тогтмол хяналт тавин 21180 зөрчил, согтуу тээврийн хэрэгсэл жолоодсон 1017, эрхийн үнэмлэхгүй явсан 579 зөрчил илрүүлэх, түүнчлэн босоо тэнхлэгийн авто зам дагуух 800 бод малд цацруулагчтай хүзүүвч зүүлгэх зэргээр зам тээврийн осол, хэрэг үйлдэгдэхээс сэргийлж ажилласнаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах" төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.	
194	4.2.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн	194. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, бэлэн байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулах	2022	Бэлэн байдлын үзлэг, гамш-гаас хамгаа-лах каманд штаб иж бүрэн сургууль дадлага зохион байгуулах сумын тоо	3	ОНТ	Монгол улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/58 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг Сайхандулаан, Хатанбулаг сумдад, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Мандах Хөвсгөл сумдад зохион байгууллаа. Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг үзлэгийн хүрээнд сумдын Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар, аж ахуй нэгж, байгууллага,

	оролцоог нэмэгдүүлнэ.					иргэдийн төлөөллийг оролцуулан олон нийтийн оролцоонд суурилсан гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, тухайн орон нутгийн эрсдэл, эмзэг байдалд суурилан орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, нийт 1432 ажилтан алба хаагч, иргэнийг хамруулсан. Мөн Сайншанд сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг чадавхжуулах сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулж “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Мэргэжлийн ангийн дүрэм”, “Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал”, “Эмнэлгийн анхны тусламж” сэдвүүдээр 130 гаруй ажилтан, алба хаагчийн гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагаас орон нутгийн гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, иргэдийн амьжиргааг хамгаалах, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, уур амьсгалаас үүдэлтэй гамшгийн эрсдэлийг даван туулах чадавх бүхий орон нутаг болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийг 2022-2025 он хүртэл 3 жилийн хугацаатай Иххэт, Хатанбулаг, Сайншанд сумдад хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан.
195	195. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн гамшгаас хамгаалах арга хэмжээний чанар	2022	Зохион байгуулах сургалт, нөлөөллийн ажлын тоо		ОНТ	“Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг 03 дугаар сарын 23-ны өдөр, “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-ийг



						хамгаалах мэдлэгээ дээшлүүлсэн. Сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан, багийн Засаг дарга нарт “Үер, уснаас үрсээ хамгаалья” аяны удирдамж, төлөвлөгөөний талаар танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллах, гамшиг, осол цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар малчид, иргэдэд өгөх зөвлөмж бүхий 9 төрлийн 700 гаруй сэрэмжлүүлэг мэдээг тараасан.
196		196. Цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн үеийн мэдээллийг амжиж анхааруулах системийг бий болгон, малчид, иргэдэд шуурхай хүргэх ажиллагааг сайжруулах	2022	Сэрэмж- лүүлэг мэдээ хүргэх тоо	40000	ОНТ Аймгийн Засаг даргын 2021 оны А/33 захирамжаар 2,1 сая, 2022 оны А/241 дүгээр захирамжаар 2,9 сая төгрөгийг тус тус зарцуулан Мобиком, Скайтел компануудтай гэрээ байгуулж, “Масс мессеж” үйлчилгээгээр дамжуулан байгаль, цаг уурын аюулт үзэгдэл болох цасан болон шороон шуурга, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэрэмжлүүлэх болон цаг үеийн мэдээллийг нийт давхардсан тоогоор 107359 иргэд, малчдад шуурхай хүргэн ажилласан. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Онцгой байдлын газрын цахим хуудсаар дамжуулан иргэд, малчдыг болзошгүй цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлж, өрхийн бэлэн байдлыг хангахыг анхааруулсан зөвлөмж, мэдээлэл байршуулж нийт 13000 гаруй хүний хандалт авсан. Ус цаг уур орчны шинжилгээний газраас цаг агаарын сэрэмжлүүлэг, анхааруулга мэдээллийг хүлээн авч, Гал түймэр унтраах, аврах 17, 23, 33 дугаар ангиуд болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад хүргүүлэн, 8 удаагийн мэдээ мэдээллийг 10

						удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн.	
197		197. Дэлгэрэх сумын Цаг уурын станцын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах	2022	Барил-гын гүйцэтгэ-лийн хувь	100	ОНТ	Дэлгэрэх сумын Цаг уурын станцын барилга шинээр барих ажлыг орон нутгийн төсвийн 240.5 сая төгрөгийн төсөвт өртөгөөр "Альянс трейд" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажлын газар шороо, суурь, хана, хамар ханын ажил дуусч, хучилт цутгах ажил хийгдэн ажлыг 70%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.
198		198. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын хараат бус, шударга, ил тод байдлыг ханган үр нөлөөг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах	2022	Хяналт шалгалт хийх объек-тын тоо	100	ОНТ	Аймгийн Засаг даргын 2022 оны А/248 тоот захирамжаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмчилгээний чанарын хяналт, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар, А/560 дугаар захирамжаар Сайншанд сумын 1, 2 дугаар багуудын 23 аж ахуй нэгж, 14 иргэний хүнс, худалдаа үйлчилгээний газруудад эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгөгдсөн үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын баталсан төлөвлөгөөний дагуу Хатанбулаг сумын Ханги хилийн боомтод ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж буй 27 аж ахуйн нэгжид эрүүл ахуй халдвар хамгаалал, хүнсний чанар стандартын хяналтаар тус тус төлөвлөгөөт бус шалгалт хийж гүйцэтгэсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны "Танхимын сургалтад шилжих тухай" А/38 дугаар тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/623 дугаар захирамжаар боловсролын сургалтын байгууллагуудын хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг 3 удаа хийж давхардсан тоогоор боловсролын салбарын 111 объектыг



							хамруулан гарсан зөрчил, дутагдалд улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмж хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.
199	4.3.1. Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа гаа өргөжүүлэн, гадаад харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	199. Хөрш зэргэлдээ БНХАУ, ОХУ-ын аймаг, хотуудтай хамтын ажиллагааны баримт бичгийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх	2022	Хамтран ажиллах баримт бичгийн тоо	10	ОНТ	<p>Оросын Холбооны Улсын Эрхүү мужтай эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, боловсрол, аялал жуулчлал, соёл урлаг болон бусад салбарт найрсаг түншлэлийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах "Санамж бичиг", Сайншанд сум, БНХАУ-ын Сычуань мужийн Пенжоу хоттой Найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны "Санамж бичиг" байгуулахаар харилцан тохиролцсоны дагуу зөвшөөрөл авахаар ГХЯ-ны Олон улсын гэрээ, эрх зүйн газарт хүсэлт гаргасан.</p> <p>Хятад-Монгол Улсын Дипломат харилцааны 73 жилийн ойн хүрээнд БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас Замын-Үүд сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 20,0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийн дэмжлэг үзүүлж БНХАУ-ын ӨМӨЗО-ны 6 аймгаас хандивласан 20,0 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн хамгаалалтын хувцас, хэрэгсэл, 25,0 сая төгрөгийн үнэ бүхий "HUAWEI" брендийн ухаалаг самбарыг эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн. БНХАУ-н Сычуань мужийн Жанжякоу хоттой цаг үеийн нөхцөл байдал болон 2 талын цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд харилцан санал солилцох, ӨМӨЗО-ны Хөх Хотын Гадаад харилцааны албатай гадаад хамтын ажиллагааг сэргээх, БНХАУ-аас Замын-Үүдэд</p>

						суугаа Ерөнхий консулын газартай “Хятад Монголын найрсаг хамтын ажиллагааны форум”-д муж, хот, хошуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх асуудлаар тус тус цахим хурал зохион байгуулж ажилласан. ОХУ-ын Хойд Дорнодын холбооны их сургууль, Арктикийн соёл урлагийн их сургууль, Сахагийн БНУ-ын хөгжмийн их сургуулиудтай урт хугацааны түншлэлийн харилцаа тогтоох, уул уурхай, барилга, дэд бүтэц, мэдээллийн технологийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, биеийн тамир спорт, урлаг, соёл, орос хэлний багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, хөтөлбөрүүдийг эхлүүлэх, салбар бүрийн багш, оюутан, сурагч солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг олон чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлсэн.	
200		200. Гуравдагч хөршийн орнуудтай түншлэлийн харилцааг өргөжүүлэн, харилцан ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжих	2022	Шинээр баталгаа-жуулах хамтын ажилла-гааны тоо	15	ОНТ	Бүгд Найрамдах Турк Улсын Сакарья хотын захирагч Экрем Ючетэй боловсрол, эрүүл мэнд, спорт, аялал жуулчлал, түүх, соёл урлагийн салбарт хамтран ажиллах, мэргэжилтэн солилцоо, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ах дүү хотын харилцаа тогтоох, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийг байгууллаа. Дорноговь аймаг болон Шизуока мужтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа тогтоосны 10-н жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлж, цар тахлын улмаас зогсонги байдалд орсон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн Шизуока

						<p>мужид 13 албан хаагчийг сургаж, Шизуока мужаас 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй холбогдох салбарын удирдлага, мэргэжилтнүүдийн 3 удаагийн албан ёсны айлчлал зохион байгууллаа. Мөн найрамдалт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ахлах ангийн сурагч солилцоо хөтөлбөрийг хэрэгжүүлж 12 дугаар сард 25 хүүхэд, 2 багш, аймгийн ЗДТГ-ын 1 мэргэжилтнийг Шизуока мужид туршалага судлуулахаар шийдвэрлэсэн. АНУ, Австрали улсын элчин сайдын яамны төлөөллүүд боловсрол, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр хийсэн айлчлал зэрэг 8 удаагийн 60 гаруй гадаад, дотоодын зочид төлөөлөгчидтэй хийх уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж ажилласан.</p>
201	201. Орон нутагт хэрэгжүүлж буй гадаадын болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөл хөтөлбөрийг шинээр олж хэрэгжүүлэх бодлого баримтлах	2022	Гадаа-дын хөрөнгө оруулал-ттай төсөл хөтөлбөр	4	ОНТ	<p>НҮБ-ын Цөлжилттэй Тэмцэх Конвенцийн санхүүжилтээр “Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, бууруулах” төслийн хүрээнд модлог ургамал, эмийн ургамал зэрэг 11 төрлийн 35000 гаруй ургамал тариалалт хийгдэн 90%-тай ургаж байна. Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS), Монгол-Оросын ХНН-ийн Улаанбаатар төмөр зам, Дорноговь аймгийн ЗДТГ-ын хооронд говийн бүсийн зэрлэг ан амьтдын холбоос нутгийг сайжруулах зорилгоор 3 талт “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулан, 2022 оны 1 сард 2 газрын, 2022 оны 7 сард 1 газрын төмөр замын торыг тус тус нээсэн.</p>

							Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, мал байгаа эсэхийг хянах, утсаар дамжуулан сануулах, шаардлагатай үед малыг холдуулах зорилгоор тус 3 газарт 1 жилийн хугацаатай гэрээт сахиул томилон, цахим хуудас үүсгэн тор авсан ойр орчмын малчид, сахиулууд, сумын Засаг дарга нар, замын мастерүүд болон WCS-ийн ажилчдыг нэгтгэсэн 209 гишүүнтэй хуудсыг идэвхтэй ажиллуулсан. Дээрет Олон Улсын Энэрлийн байгууллага 2022 оны 11-р сард Сайншанд сумын 4,8-р багийн Мааньзавын гудамжинд смарт тохиргоотой 24 цагийн турш иргэдэд нээлттэй байх ундны усны автомат худгийг шинээр ашиглалтад оруулж, аймгийн Ахмадын асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцаж, эд хэрэгслийн дэмжлэг үзүүлсэн. БНХАУ-ын 201,0 сая юань (75 тэрбум төгрөг)-ийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд зорчигч тээврийн байгууламжийн ажлыг 52%-ийн гүйцэтгэлтэй, ачаа тээврийн байгууламжийн ажил 31%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.
202	202. Гадаад улсруу айлчлах болон гадаадын улсын төлөөлөгчдийн орон нутагт хийх албан айлчлалыг зохион байгуулах	2022	Зохион байгуулах ажлын тоо	5	ОНТ	Дорноговь аймгаас Япон улсын Шизуока мужид Төрийн захиргааны болон цэвэрлэх байгууламжийн чиглэлээр чадавхжуулах сургалтад хамрагдах 13 албан хаагчийн холбогдох материалыг бэлтгэн мужийн ЗДТГ-т хүргүүлэн, паспорт, визний материалын бэлэн байдлыг хангаж ажилласан. Бүгд Найрамдах Турк Улсын Сакарья хотын дарга	

						Экрем Юче болон Япон улсын Шизуока мужийн 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй холбогдох салбарын удирдлага, мэргэжилтнүүдийн 3 удаагийн албан ёсны айлчлал, НҮБ-ын Хүүхдийн сангийн Шадар суурин төлөөлөгч Аяако Кайногоор ахлуулсан тус сангийн мэргэжилтнүүдийн хүүхдийн эрхийг хангах чиглэлээр хийсэн айлчлал, АНУ, Австрали улсын элчин сайдын яамны төлөөллүүд боловсрол, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр хийсэн айлчлал зэрэг 8 удаагийн 60 гаруй гадаад, дотоодын зочид төлөөлөгчидтэй хийх уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж ажилласан.
203	4.4.1. Батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед хэрэгжүүлнэ.	203. Батлан хамгаалах салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх	2022	Бодло-гын хэрэгжилтийн хувь	95,0	ОНТ Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах зорилгоор БХЯ-ны нээлттэй өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сард Сайншанд сум болон Зүүнбаян багт зохион байгуулж цэргийн төв архивын лавлагаа олгох, цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоо, цэргийн дуу бүжгийн чуулгын тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, уулзалт хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн батлан хамгаалах салбарын бодлогыг 300 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг давхардсан тоогоор 3100 иргэнд хүргэсэн. Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан “Соёмбо” сонин, орон нутгийн DSB телевиз, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, “Өнөөгийн Дорноговь нутгийн мэдээ”

						сонинд нийт 8 удаа мэдээлэл нийтлүүлсэн. Цэргийн албаны тухай хуулийн дагуу “Хугацаат цэргийн албаны тухай”, “Цэргийн гэрээт алба”, Цэргийн дүйцүүлэх алба”, “Оюутан-цэрэг” сургалт, “Цэргийн бүртгэл” зэрэг 5 төрлийн гарын авлага, материал бэлтгэн ерөнхий боловсролын сургууль төгсөгчид, сум, багийн Засаг дарга нарт албан бичиг болон албан даалгавраар 1500 ширхгийг хүргүүлэн ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн120 сурагчид БХИС, ХСИС-ийн үйл ажиллагаа, сургалтын онцлог, элсэлтийн шалгалтын журмын талаар 1 удаа мэдээлэл хүргэсэн.
204		204. Орон нутаг дахь Зэвсэгт хүчний ангиудын тайван цагт дотоод үйл ажиллагааг хэвийн явуулах, бэлэн байдлыг хангах зорилгоор дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	2022	Дэмж-лэгийн тоо	4	ОНТ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аяны хүрээнд Зэвсэгт хүчний 336 дугаар ангид байгуулахад “Мод үржүүлгийн газар” байгуулах 30 га газрыг эзэмшүүлэх шийдвэрийг гаргасан. Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 090, 253, 281 дүгээр салбаруудын барилга байгууламжид хийх шаардлагатай засварын зардалд зориулан тус бүр 20,0 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлж олгосон. Зэвсэгт хүчний 336 дугаар анги үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан аймгйн Засаг даргын захирамжаар 10,0 сая төгрөгийг олгосон ба нийт Зэвсэгт хүчний 336 дугаар ангид нийт 144,3 сая төгрөгийн, зэвсэгт хүчний 090, 253, 281-р тусгай салбаруудад нийт 60,0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүллээ. Мөн дайчилгааны бэлтгэл нөөцийн

							бүрэлдэхүүний сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд 24,4 сая төгрөг, нууцын горимыг бүрдүүлэн ажиллахад 3.3 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.
205		205. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх	2022	Баримт бичиг боловс-руулалтын хувь 100 Төлөв-лөлтийг хийж дуусга-сан байна.		ОНТ	“Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах” аймгийн төлөвлөгөөг шинэчлэн, хавсралт тооцоо, сумдуудтай дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах байдлаар тооцоо судалгааг гарган тодотгол хийж сумдын дайчилгааны төлөвлөгөөг болон Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын стратегийн 600/02 удирдамжийн дагуу 2022 оны 1 дүгээр улиралд “Зэвсэгт хүчний ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах” төлөвлөгөөг шинэчлэн, хавсралт тооцоог тус тус боловсруулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулсан.
206		206. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлж, “Оюутан-цэрэг” сургалт, хугацаат цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх	2022	Арга хэмжээний тоо  Хяналтын тоог биелүүлсэн байна	18  100 хувь	ОНТ	Цэрэг-эх оронч үзлийг сурталчлах, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 100 жилийг сурталчлах, цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг эх оронч хүмүүжил олгох чиглэлээр орон нутгийн DSB телевиз, FM-101.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, “Өнөөгийн Дорноговь-нутгийн мэдээ” сонинд нийт 15 удаагийн мэдээлэл нийтлүүлсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/357 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын нэрэмжит “Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний I,II шатны шалгаруулалтыг орон нутагт зохион байгуулж “Тэргүүн байр”-нд шалгарсан Сайншанд сумын 5 дугаар сургуулийн тасаг Улсын аварга шалгаруулах

							тэмцээнд амжилттай оролцож, 21 аймаг, 9 дүүргээс 13 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн. Тайлант оны I, II ээлжийн цэрэг халах, татах ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулан Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги салбараас тогтоосон хяналтын тоог 100 хувь биелүүлсэн. Цэргийн жинхэнэ алба хаах 18-25 насны иргэдийн тоо 18,8 хувиар нэмэгдсэн.
207	4.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цар хүрээг нэмэгдүүлж, төрийн байгууллагын ажлын үр дүнг сайжруулна.	207. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн баяжуулалт, шинэчлэлийг хийх	2022	Баяжуу-лалт хийх тоо	4	ОНТ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан 4 зорилтот хөтөлбөрийг бүрэн байршуулж, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын 25 агентлаг, 14 сумын Засаг даргын Тамгын газарт хамаарал бүхий үеэс арга хэмжээг хуваарилсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилийн эцэст нэгтгэн цахимаар авах боломжийг бий болгосон
208	4.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цар хүрээг нэмэгдүүлж, төрийн байгууллагын ажлын үр дүнг сайжруулна.	208. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг нэмэгдүүлж, дээд шатны байгууллагын үнэлгээний хувийг ахиулах	2022	Үнэлгээний хувь	88.0	ОНТ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах болон үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийх арга зүйд сургах “Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг” аймгийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 06 сард зохион байгуулсан. Сургалт зөвлөгөөнд 9 агентлагийн дарга, 8 хэлтэс, тасгийн дарга, 26 мэргэжилтэн, 13 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, ХШҮ хариуцсан мэргэжилтэн 69 хүнийг хамруулсан. “Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ерөнхий ойлголт”, “Төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичгийг



							<p>хяналтад авах нь”, “Бодлогын баримт бичгийг төлөвлөх, тайлагнах арга зүй” “Цаг төлөвлөлт”, “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын өөрчлөлт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хувцаслалт, сахилга хариуцлага”, “2021 оны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт-шалгалтын дүн” зэрэг мэдээлэл арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.</p> <p>Эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн, хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай 74 заалт арга хэмжээг нэгтгэн, холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Аймгийн ИТХ болон ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг бодитой дүгнэх, үнэлгээний хувийг ахиулах зэрэг бэлтгэл ажлыг бүрэн хангасан.</p>
Тав. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
209	5.1.1. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	209. Агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох, цахилгаан халаалтыг дэмжих арга хэмжээг судалж хэрэгжүүлэх	2022	Зохион байгуулах арга хэмжээний тоо	5	ОНТ	<p>“Хүүхэд хөгжил 2022” зорилтот жилийн хүрээнд “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал”-аас 1,4 сая төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлэн Сайншанд сумын гэр хорооллын олон хүүхэдтэй 6 өрхөд эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур олгосон. Сайншанд, Замын-Үүд сумдын тарифын хөнгөлөлттэй тоолуур бүхий 570 өрх шөнийн цагаар хэрэглэсэн цахилгааны төлбөрийн хөнгөлөлтөд хамрагддаг бөгөөд тайлант хугацаанд Дэлгэрэх, Сайншанд,</p>

						<p>Сайхандулаан, Замын-Үүд сумдын 11 өрх шинээр нэмэгдсэн. “Намрын ногоон өдрүүд”, төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг” зэрэг олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдэд салбарын үйл ажиллагааг сурталчлан оролцож, агаарын бохирдлыг бууруулах, ухаалаг хэрэглээг нэмэгдүүлэх, гэр, амины орон сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, зуухны талаар 100 гаруй гарын авлага, материалыг олон нийтэд түгээсэн.</p> <p>Сайншанд суманд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийн зөвшөөрлийг 114 иргэнд олгож 63 иргэн өөрийн хөрөнгөөр төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд, Замын-Үүд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 249.6 сая төгрөгийн санхүүжилтээр Сүлд багийн 11 болон 12 дугаар хэсэгт 730м бохир усны төвийн шугам сүлжээ татах ажлыг “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ гүйцэтгэж, 65 айл өрх төвлөрсөн шугам сүлжээнд, Айраг суманд 3 айл, 4 аж ахуйн нэгж, Дэлгэрэх суманд 3 айл, Өргөн суманд 5 айл, Хатанбулаг суманд 20 айл 3 аж ахуйн нэгж, Хөвсгөл суманд 5 аж ахуйн нэгж тус тус төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож, нийт 10 сумын гэр хорооллын 531 өрх агаарын бохирдлыг бууруулах, ухаалаг хэрэглээг нэвтрүүлсэн.</p>
210	210. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн	2022	Эрүүл ахуйн бүсийн дэглэмийн	100	ОНТ	Орон нутгийн усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүстэй давхцуулан

		дэглэмийг нарийвчлан тогтоож мөрдүүлж хэвшүүлэх		биелэлтийн хувь  Худгийн тоо	2	олгосон 139 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүлсэн. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09, 11 дүгээр албан даалгавар тус тус гарсантай холбогдуулан усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, ойр орчмын 88,5 га талбайг цэвэрлэж, 178,7 тн хог хаягдлыг 29 тээврийн хэрэгсээр төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн. Даланжаргалан сумын 3 аж ахуйн нэгжийн 4, Сайншанд 1 худаг, Дэлгэрэх 1, Мандах 2, Улаанбадрах 2, Алтанширээ 1 худагт эрүүл ахуйн бүсийг шинээр тогтоон хашаажуулж, тэмдэгжүүлсэн. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй 18 нүхэн жорлонг буулган хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөө бууруулсан.
211		211. Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлэх	2022	Хам-гаалж, тохижуу-лах булгийн тоо	3	ОНТ Гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 12.0 сая төгрөгийн хөрөнгөөр Хөвсгөл сумын “Бөөрийн хурал”, Эрдэнэ сумын “Уртын булаг”, Иххэт сумын “Хөгцөт” булаг, Хатанбулаг суманд ОНХС-ийн 5,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хатны булаг” нийт 4 суманд 4 булгийн эхийг хашиж хамгаалж тохижуулан усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан. Сумдад Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх,

						түүний орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдсэн. Нийт 52 ААНБ, 404 иргэн, ажилтан, албан хаагчид оролцон булаг шанд, рашааны эхийг хамгаалж тохижуулах, сэргээн засварлах, ойр орчмын 88,5 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр, 178,7 тн хог хаягдлыг цэвэрлэн сумдын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн
212		212. Сумдын ундны усыг чанарын шинжилгээнд хамруулж, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ундны усаар хангах	2022	Шинжил-гээнд хамраг-дах худгийн тоо  Цэвэр-шүүлэх төхөө-рөмж суури-луулах худгийн тоо-	40  1	ОНТ  Сумдын төвийн хүн амын ундны усанд ашиглаж буй 55 худгийг шинжилгээнд хамруулж цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарч, үе шаттайгаар 35 худгийг стандартад нийцүүлсэн. Усны чанар, стандартыг сайжруулах ажлын хүрээнд “Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал”-ын 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр Улаанбадрах суманд 1 худаг, Улсын төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Алтанширээ суманд 1 худаг, Сайхандулаан сумын 2 худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж шинээр суурилуулж, Хөвсгөл сумын 1 худгийн цэвэршүүлэх төхөөрөмжийг сэргээн засварласан.
213	5.1.2. Гэр хороолол, аялал жуулчлал ын газруудын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж	213. Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2022	Сайж-руулах ариун цэврийн байгуу-ламжийн тоо	100	ОНТ  Хөрсний бохирдлыг бууруулах, усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах зорилгоор хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй "Нүхэн жорлонгийн хэрэглээг бууруулах, цаашлаад зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 11 дүгээр албан даалгаврын хүрээнд Замын-Үүд,

	<p>сайн туршлагыг дэлгэрүүлнэ.</p>					<p>Сайншанд сумын 8 өрх, 13 аж ахуйн нэгж, байгууллагын стандартын шаардлага хангасан /сорулдаг/ ариун цэврийн байгууламж суурилуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Мандах сумын гэр хорооллын 80 өрхийн нүхэн жорлонг булшилж, орчин үеийн стандартын шаардлага хангасан боловсон ариун цэврийн байгууламж суурилуулсан. “Өнгө Нэм” ТББ-тай хамтран “Хог хаягдлын менежмент”-ийг сайжруулах сургалтыг 2 удаа зохион байгуулж хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, шингэн хаягдлын менежмент, стандартын бие засах газрын чиглэлээр мэдээлэл сургалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл 130 хүнийг танхимаар, 14 сумын ЗДТГазар, төрийн байгууллагуудын дарга эрхлэгч 70 хүнийг цахимаар тус тус сургалтад хамруулсан.</p> <p>Хөрсний бохирдол үүсгэгч хүчин зүйлийн томоохон шалтгаан болж буй нүхэн жорлонгийн хэрэглээг бууруулах, цаашлаад зогсоох чиглэлээр Мандах сумын гэр хорооллын 80 өрхийн нүхэн жорлонг булшилж, орчин үеийн стандартын шаардлага хангасан боловсон ариун цэврийн байгууламж суурилуулсан. Гэр хорооллын 60 айл өрх, 13 аж ахуйн нэгж, байгууллагын стандартын шаардлага хангасан /сорулдаг/ ариун цэврийн байгууламж, 15 өрх био 00-той болж, 61 өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож, 112 айл өрх ариун цэврийн байгууламжаа шинэчилж, хөрсний бохирдлыг</p>
--	------------------------------------	--	--	--	--	--

							бууруулсан.
214	5.1.3. Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлнэ.	214. Зарим сумдад сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг гаргах, бороо цасны ус харимтлуулах хөв цөөрөм байгуулж зэрлэг амьтдын ус хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлэх	2022	Сэргээгдэх эрчим хүчээр ажиллах хугацаа  Хөв цөөрөм	1  2	ОНТ	Бэлчээрт нийт 3202 худаг ашиглагдаж, нийт бэлчээрийн 40,3 хувийг усжуулдаг бөгөөд үүнээс 6 худаг сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг. Хатанбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 5,3 сая төгрөгийн санхүүжилтээр "Хатны булаг"-ийн эхийг хашиж хамгаалах ажлын хүрээнд шинээр 1 хөв цөөрөм байгуулж, 2 хөв цөөрмийг сэргээн засварласан. Сайхандулаан, Хатанбулаг сумдын 2 иргэн энгийн уурхайн 2 худагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилуулж бэлчээрийн усан хангамж, зэрлэг амьтдыг ундаалах боломжийг бүрдүүлсэн. Эрдэнэ сумын "Хангинуур", Өргөн сумын "Аргалийн уул"-ын агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөнд 2023 онд тус бүр 2 ширхэг хөв байгуулах ажлын төсвийг оруулж батлуулсан.
215		215. Дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлэн, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах	2022	Төсөл хөтөлбөр хэрэгжсэн байна.		ОНТ	Орон нутагт бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажил гүйцэтгэж байгаа "Улаанбаатар төмөр зам" ХНН, "Газрын тос боловсруулах үйлдвэр", "Бишрэлт түшлэг" ХХК, "Алтраг Ахас" ХХК зэрэг компаниудад зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авах, амьдрах орчныг тэтгэж хөв, цөөрөм байгуулах, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх талаар санал зөвлөмж хүргүүлсэн. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Ханги чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж буй 21 компанийн төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, мал, амьтан чөлөөтэй нүүдэллэх гарц, гармын хоорондын

						зайг ойртуулах, олшруулах, тор, хашлага хийхгүй байх шаардлагыг тавьснаар 600 гаруй хулан адуу, 1200 гаруй цагаан зээр чөлөөтэй нэвтэрсэн. “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг”-ийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран зэрлэг амьтдыг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөлөх зорилгоор төмөр замын 825, 914, 958 дугаар тэмдэгтийн 1.5 км газарт хоёр талын торыг чөлөөлсөн. Мөн Газрын тос боловсруулах үйлдвэрийн төмөр замын дагуу 100м газрын торыг авах ажлыг 12 дугаар сард хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон.
216	5.1.4. Хог хаягдлын менежментийг сайжруулж дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ.	216. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих	2022	Дахин боловсруулах хог	1000тн,	ОНТ Аймгийн Засаг даргын 2022 оны А/431 дүгээр захирамжаар "Эко говь" хог дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжин цахилгаан эрчим хүчний найдвартай байдлыг хангах зорилгоор эрчим хүчний дэд станц суурилуулахаар цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийг гаргуулж дэд станцын барилга угсралтын ажлын зургийг гаргуулсан. Дахивар хог хаягдал боловсруулах "Эко говь" үйлдвэрийг бодлогоор дэмжих зорилгоор Сайншанд суманд 110 худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, дахивар хог хаягдлыг цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгөх талаар албан бичиг хүргүүлж, 73 аж ахуйн нэгж, байгууллагатай хариуцлагын гэрээ байгуулан 43 аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулсан. “Эко говь” хог хаягдлыг дахин боловсруулах

						<p>үйлдвэрт 400 тн хогийг дахин боловсруулж, 450 гаруй сандал, хашааны шон, таг, авто зогсоолын хөдөлгөөн хязгаарлагч зэргийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн. Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай түүхий эд, нөөцийг бүрдүүлэх зорилгоор худалдаа, үйлчилгээний 6 газар, 2 зах, 7 нийтийн орон сууц, 4 сургууль, 14 цэцэрлэгийн орчимд 33 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулж, 80 тн хогийг төвлөрүүлсэн. "Тохижилт-Сайншанд" хот тохижилтын газар 20 тонн хаягдал шил цуглуулж Улаанбаатар хотын шил боловсруулах үйлдвэрт хүргэж ажилласан. Дахивар хог хаягдал нийлүүлдэг худалдаа, үйлчилгээний төвийн тоо 2-оор нэмэгдэж, нийт 15 цэгээс 3 тонн дахивар гялгар уутыг цуглуулсан.</p>
217	217. Хог хаягдлыг цэвэрлэх, эх үүсвэр дээр нь ялган ангилах, иргэдийн дадал хэвшлийг бий болгох сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах	2022	<p>Сургалт нөлөөллийн ажлын тоо</p> <p>Хог ангилан ялгах өрхийн тоо</p> <p>Автопарк шинэчлэл-ийн тоо-</p>	<p>40</p> <p>2000</p> <p>1</p>	ОНТ	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/141 дүгээр захирамжийн хүрээнд "Эко бизнес, Эко ажлын байр" уриан дор "Хог хаягдлын менежментийг сайжруулах" зөвлөгөөнийг зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 150 гаруй төлөөллийг хамруулан орчны бохирдлыг бууруулах, хор уршиг, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг ангилах ялгах, дахин боловсруулах чиглэлээр мэдлэг олгосон. "Монголын Эргийн Волейболын холбоо" ТББ, "Эко говь" төсөлтэй хамтран сургуулийн 120 сурагчийн оролцоотойгоор 70 кг PP, 70 кг PET хуванцар, 5 кг лааз, 50 кг LDPE нийлэг хальсан уутыг цуглуулан ангилан ялгах үзүүлэх сурталт хийж, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлсэн. "Намрын ногоон өдрүүд",</p>



						төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг” зэрэг олон нийтийг хамарсан 3 арга хэмжээнд оролцож салбарын үйл ажиллагаатай холбоотой 1500 гаруй гарын авлага, материал, 10 төрлийн постер, 3 төрлийн видео мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн.
218	218. Аюултай хог хаягдлын бүртгэлжүүлж, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх	2022	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах барьж ашиглалтад оруулна. Үйлдвэрт шилжүүлэх хог хаягдлын хэмжээ	150 тн	ОНТ	<p>Аюултай хог хаягдал үүсгэгч уул уурхайн баяжуулалт, зам барилгын үйл ажиллагаа эрхлэгч 3 аж ахуйн нэгж, авто засварын үйл ажиллагаа эрхлэгч 4 иргэн, 4 аж ахуйн нэгж нийт 8 аюултай хог хаягдал үүсгэгчдийг бүртгэлжүүлж дугаар олгосон. Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт "Аюултай хог хаягдлын агуулах барих ажил"-ыг "Цомбон тоосго" ХХК гүйцэтгэж бүрэн дуусгасан.</p> <p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс 2022 онд 29,6 тн аюултай хог хаягдлыг хог хаягдлын төвлөрсөн цэгт устгалд оруулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/309 дүгээр захирамжаар 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн “Түмэн эгшиг” ХХК-тай хамтран Айраг, Иххэт, Замын-Үүд Өргөн, Сайншанд сумдын 8 сургуульд хадгалагдаж байсан 257 нэр төрлийн 750 кг хуурай, 310 литр шингэн, 216 ширхэг бохирдсон сав, баглаа боодлыг зориулалтын байгууламжид саармагжуулан шатааж устгасан. Сайншанд сумын 6 дугаар багийн нутагт баригдаж буй Газрын тосны үйлдвэрийн ажилчдын хотхоны талбайгаас 2021 онд явган цэрэг, танк эсэргүүцэх мина,</p>

						онгоцны бөмбөг зэрэг нийт 22 ширхэг, 2022 онд 1 ширхэг цэргийн зориулалттай тэсэрч дэлбэрэх зүйл олдсоныг Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн тэсэрч дэлбэрэх зүйлсийн хайгуул устгалын бүлэг устгаж аюулгүй болгосон. Хотхоны хамрах 110,6 м2 талбайд тэсэрч дэлбэрэх зүйлсийн хайгуул устгалын ажлыг зохион байгуулах хүсэлтийг Зэвсэгт хүчний Жанжин штабт аймгийн Засаг даргын 2022 оны 01/1646 дугаар албан бичгээр гаргасан.
219	5.1.5. “Ногоон Дорноговь” арга хэмжээг хэрэгжүүлж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	219. 20 сая мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод тарьж, ургуулсан иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах	2022	Тарих модны тоо  Урамшуулах иргэд  ААНБ	400,000  100  20	ОНТ  “Тэрбум мод” аймгийн зорилтот хөтөлбөрийн 92,0%-тай хэрэгжүүлэн ажиллалаа. 2 сумын 3 байршилд цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган 8,5 га газрыг олгож нийт 7 сум цэцэрлэгт хүрээлэн байгуулсан. Төв суурин газрын хамгаалалтын ойн зурвас байгуулах газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган 8 сумын 52 байршилд 173,3 га газар олгож 5 сумын ойн зурваст 4500 мод тарьсан. 14 сумын тариалангийн зориулалтаар ашиглагдаж буй талбайн хөрсний байдалд дүн шинжилгээ хийж 14 удаагийн заавар зөвлөмж өгсөн. Улсын болон орон нутгийн авто замын хамгаалалтын зурвас байгуулахаар 52,5 га газрыг төлөвлөгөөнд оруулж 42000 мод тарьсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын экологийн боловсролыг дээшлүүлж хүүхэд бүр мод тарих арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан 2142 сурагч 6255 мод суулгасан. “Тэрбум

						<p>мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 14 сум 158990, уул уурхайн компани 21854, сайн дурын холбоод 1000, “Их сумт хайрхан” ХХК 22450, “Оюу гарден” ХХК 3200, “Шамбала инженеринг” ХХК 32000, “Борхойн Баян бүрд” ОНӨААТҮГ 50055, нийт 289540 ширхэг мод тарьж, ургуулсан.</p> <p>Сайншанд, Замын-Үүд, Иххэт сумдад орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн ургуулах боломжтой олон төрлийн мод тарьж ургуулсан 5 иргэн, 2 аж ахуйн нэгжийг шагнаж урамшуулсан. Сайн дураар мод тарьж орон нутгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн иргэд, ажахуйн нэгжүүдийг урамшуулах ажлыг 12 дугаар сард зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосон.</p>
220	220. Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж, заган ой, ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх	2022	<p>Зохион байгуулах арга хэмжээний тоо</p> <p>Мод үржүүлгийн газрын тоо</p>	7	ОНТ	<p>Даланжаргалан сумын “Чойрын богд ХХК-ийн 3,3 га, Сайншанд сумын “Мөрөөдлийн говь” ХХК-ийн 10 га, Хилийн цэргийн 0168-р ангийн 0,4 га, Зэвсэгт хүчний 336 дугаар ангий 30 га талбайд “Мод үржүүлэг-Агро экологийн төв”, Сайншанд сумын 1 иргэн “Зээгийн хөтөл”-д 10 га, нийт 55,7 га талбайд мод үржүүлгийн газар шинээр ашиглалтад оруулсан.</p> <p>Дээрх мод үржүүлгийн газруудад говийн унаган ургамал заг, сухай, алтан харгана, буйлс, хайлаас, улиас зэрэг модны 1,4 сая гаруй үрсэлгээг амжилттай хийж, хаврын тарилтад ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. Ханги хилийн боомтод мод үржүүлгийн газар, бортого үйлдвэрлэх цех байгуулах иргэний санаачилгыг дэмжиж, 2 га газар олгосон ба</p>

						цахилгааны асуудлыг шийдвэрлэсэн. “Арвин РММС” ХХК жимс, жимсгэнийн агро парк 30 га талбайд байгуулахаар зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулан дэд бүтэц шийдвэрлэхэд шаардлагатай техникийн нөхцөл авах хүсэлтийг холбогдох газруудад хүргүүлсэн. Сайншанд сумын 1 иргэн мод үржүүлгийн газар байгуулан, хашаажуулахад орон нутгаас 3,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
221	5.1.6. Уул уурхайн олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болон эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	221. “Нөхөн сэргээлт 2024” арга хэмжээг хэрэгжүүлж, уул уурхайн олборлолт болон төмөр зам, автозам, барилга байгууламж барихтай холбоотой эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх	2022	Нөхөн сэргээлтийн хувь  Нөхөн сэргээх талбайн хэмжээ	100  20 га	ОНТ  “Ханги-Зүүнбаян” чиглэлийн 222.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутагт ашигласан 20 карьерын 350.66 га-г, Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 45км хатуу хучилттай автозамд ашигласан 7 карьерын 34.38 га-г, Нийт 385.04 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг холбогдох сумд тус тус хүлээн авсан. Уул уурхайн компаниуд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд техникийн 18.32 га, биологийн 2 га талбайд 87,4 сая төгрөгийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан. Аймгийн хэмжээнд уул уурхай, дүйцүүлэн хамгаалах, төмөр замын бүтээн байгуулалт хийгдсэнтэй холбоотой техникийн 403.36 га, биологийн 2 га талбайд 821276.1 мян.төгрөгийн зардлаар техникийн нөхөн сэргээлт хийсэн байгааг мэдээллийн санд оруулсан.
222	5.1.7. Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль	222. Иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх	2022	Зохион байгуулах сургалтын тоо	7	ОНТ Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан 10 төрлийн томоохон сургалт, арга хэмжээнд

<p>орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлнэ.</p>			<p>Хамрагдах хүний тоо</p>	<p>17000</p>	<p>давхардсан тоогоор 18248 иргэн, 90 гаруй цэцэрлэгийн багш хамруулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/656 дугаар захирамжаар 5,0 сая төгрөгийг зарцуулан “Торгон хил” сургалт, аяллын арга хэмжээг Сайншанд сумаас Сулинхээрийн 5-р застав хүртэлх маршрутаар зохион байгуулж ЕБ-ын 20 сургуулийн 40 сурагч, 8 багшийг хамруулж Монгол орны байгаль, говь нутгийн ахуй амьдрал, өөрийн аймгийн түүхэн дурсгалт газрууд, хилийн цэргийн амьдралтай танилцуулан, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлсэн.</p> <p>Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялган ангилах нөлөөллийн арга хэмжээг "Эко говь" төсөлтэй хамтран хэрэгжүүлж, 45 удаагийн нөлөөллийн ажлыг цахим орчинд өрнүүлж, 27769 орчим иргэнд мэдээлэл өгч, гарын авлага материалаар хангасан. ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд нутаг орноо танин мэдэх, бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Хүн болох багаасаа”, “Говь нутгийн бахархал”, “Ёс суртахуун”, “Эко цэцэрлэг”, “Гэрээр суралцах” хөтөлбөрт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, 1211 хүүхэд, 30 гаруй багшийг оролцуулсан.</p> <p>Сайншанд сумын цэцэрлэгүүд "Ногоон Дорноговь" хөтөлбөр, Замын-Үүд сумын цэцэрлэгүүд "Эко орчныг бүтээх жил" зорилтот жилийн хүрээнд болон "Говийн хөрс" орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Алтан намар, Ногооны зах өдөрлөгийг цэцэрлэг бүр зохион байгуулж хураан авсан жимс ногоогоор хийсэн төрөл</p>
--	--	--	----------------------------	--------------	--

						бүрийн хоолны үзэсгэлэн гаргаж 2000 эцэг эхчүүд хамрагдсан. "Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас хамгаалах нөлөөллийг бууруулах нь", "Таримал модны хөнөөлт, шавж өвчинтэй тэмцэх арга" зэрэг сургалтад сургууль цэцэрлэгийн алба хаагчид хамрагдаж, иргэд, эцэг эхчүүд, хүүхдүүдэд нөлөөллийн 170 гаруй үйл ажиллагаагаар 15000 гаруй хүн хамрагдлаа. Даланжаргалан сумын ЕБ-ын сургуулийн 47 сурагч, 8 багшийг "Их нартын байгалийн нөөц газар"-тай танилцах аялалд оролцуулж, цахимаар 11645 иргэнд мэдээлэл хүргэсэн.
223		223. Сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажиллуулж, урамшуулах	2022	Шинээр томилог-дох идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо  Зохион байгуулах арга хэмжээний тоо	20  3	ОНТ  Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Мандах, Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн, Хөвсгөл, Замын-үүд сумдын нутагт хамаарах орон нутгийн тусгай хамгаалалттай 31 газрын 584037.51 га талбайг хариуцан ажиллах 55 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар томилж үнэмлэх олгосон. Эдгээр идэвхтэн байгаль хамгаалагч нартай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сард дүгнэж, урамшуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосон. Мэргэжлийн байгууллага, сумдаас идэвхтэн байгаль хамгаалагч нарыг чадавхжуулах, салбарын хууль тогтоомж, дүрэм журмын шинэчлэл, цаг үеийн мэдээ мэдээллээр хангаж, 4 удаагийн цахим, 1 удаагийн танхимын сургалт арга хэмжээнд оролцуулсан.
224	5.1.8. Аймгийн Тусгай	224. Тусгай хамгаалалттай газар	2022	Нутаг дэвсгэрийн эзлэх хувь-	10	ОНТ  Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 32.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай

	хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.	нутгийн сүлжээг нэмэгдүүлж, хамгаалалтыг сайжруулах		32.9, шинээр тэмдэгжүүлэх газрын тоо			хамгаалалттай газар нутаг эзэлдгээс Алтанширээ сумын “Хайлсан шанд”, “Холбоогийн уул”, “Баянбуурал”, Эрдэнэ сумын “Цант хайрхан”, “Хар дэлийн шүү”, Хөвсгөл сумын “Уушны говийн өргөтгөл” зэрэг 52290.3 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Улаанбадрах, Мандах, Иххэт, Сайншанд, Даланжаргалан сумдын улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 24 байршил газрыг 22,8 сая төгрөгийн санхүүжилтээр тэмдэгжүүлсэн.
Зургаа. ОРОН НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ							
225	6.1.1. Орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	225. Сайншанд сумын суурьшлын бүсэд хот хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулж, дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2022	Гүйцэт-гэлийн хувь	100	ОНТ	<p>Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК нь гүйцэтгэсэн.</p> <p>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж, төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон “Тохилог орон сууц” амины орон сууцны хороолол болон “Шинэ Найрамдал” хорооллын газруудын байршлыг нарийвчлан тогтоож үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэрт шинээр суурьшлын бүс үүсгэх ажлын хүрээнд нисэхийн хэсэгт 317 өрхийн 30.37 га газарт дахин зохион байгуулж, ОНТ-ийн нийт 12.22 тэрбумын хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны шугам, 1.59 км автозам, Өлзийт хорооллын айл өрхийг цахилгаанд холбох</p>

						ажлыг хийж гүйцэтгэсэн.
226	226. Сайншанд сумын гэр хороололд газрыг дахин зохион байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2022	Чөлөөлөх нэгж талбарын тоо	79	ОНТ	<p>Сайншанд сумын 7 дугаар багт хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нийгмийн дэд бүтэц, орон сууцны бүтээн байгуулалтын нөөц газар бүрдүүлэхээр төлөвлөсөн бүсэд багтсан 69 иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалттай 4,51 га эзэмшил газрыг сумын Засаг даргын 2021 оны А/193 дугаар захирамжаар газрын байршлыг шилжүүлж, газрыг чөлөөлсөн. Энэхүү шинэ суурьшлын бүсэд сумын 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн 126,7 сая төгрөгийн хөрөнгөөр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг байгуулж, ашиглалтад оруулсан.</p> <p>Мөн 6 дугаар багт аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 0,577 км авто зам шинээр байгуулах ажлыг хэрэгжүүлэхээр гэр хорооллын газрыг дахин зохион байгуулалт хийж авто замын трасст орсон 1 айлын газрын байршлыг шилжүүлж, чөлөөлсөн.</p> <p>Сайншанд сумын 7 дугаар багт хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны бүтээн байгуулалтын нөөц газар бүрдүүлэхээр төлөвлөсөн бүсэд багтсан 154 иргэний гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалттай 10,78 га эзэмшил газрыг байршлыг шилжүүлж, чөлөөлөхөөр сонсох ажиллагааг зохион байгууллаа. Дээрх газрыг сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шилжүүлэх байршлыг тусгахаар төлөвлөсөн.</p>
227	227. Замын-Үүд сумын	2022	Барилга угсрал-	100		"Шинэ сэргэлтийн бодлого"-ын боомтын



		хилийн боомтын Барилгын материалын лабораторийн барилга барих		тын гүйцэтгэлийн хувь			сэргэлтийн хүрээнд Замын-Үүд боомтод улсын төсвийн 2.89 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "Барилгын материалын лабораторийн барилга угсралтын ажил"-ыг хийж гүйцэтгэхээр "Батбүрдэл" ХХК тендерт шалгарч гэрээ байгуулсан. Барилгын үндсэн хийц бүтээцийн угсралт, дотор шавардлага, цонх суулгах, дотор цахилгаан, гадна шугам сүлжээний ажил бүрэн хийгдсэн ба нийт ажлын 70 хувийг гүйцэтгэсэн.
228		228. Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн дэд станцын 0.4 кВ хуваарилах байгууламжийн тоноглолыг өргөтгөх	2022	Барилга угсралтын гүйцэтгэлийн хувь	100		Улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Замын-Үүд чөлөөт бүс"-ийн цахилгаан хангамжийн дэд станцын 0.4 кВ хуваарилах байгууламжийн тоноглол өргөтгөх ажлыг "Улаанбаатар Электро Монтаж" ХХК гүйцэтгэхээр тендерт шалгарч гэрээ байгуулсан. Уг ажлын хүрээнд 0,4 кВ-ын нийт 16 ширхэг КТПН маягийн дэд станц суурилуулж, тоноглохоос 12 дэд станцыг тоноглох ажил хийгдэж дууссан. КТПН-ийн үлдсэн 4 тоноглолын угсралт хийгдэж байгаа ба ажлын 80 хувийг хийж гүйцэтгэсэн.
229		229. Мандах сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалт, тохижилтийг сайжруулах	2022	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	ОНТ	Улсын төсвийн 200,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Мандах сумын төвийн тохижилтын ажлыг "Экоповерлайн инженеринг" ХХК гүйцэтгэхээр шалгарч ажлаа эхлүүлсэн. Сумын төвд цацардаг гэрэл 6 ширхэг камертай гэрэл, гудамжны 30 гэрлийн толгойг шинээр суурилуулж, гудамжны 12 гэрлийг засварласан. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай.
230		230. Сайншанд суманд	2022	Суурьшлын бүс		ОНТ	Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэр

		"Шинэ найрамдал" суурьшлын бүс байгуулах ажлыг эхлүүлэх		байгуулах ажлын дэд бүтцийн ажил, зарим барилгын ажлыг эхлүүлсэн байна.			Нисэхийн хэсэгт 317 өрхийн 30.37 га газарт дахин зохион байгуулалт хийж, Орон нутгийн төсвийн 12.22 тэрбумын хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны шугам, 1.59 км автозам, Өлзийт хорооллын айл өрхийг цахилгаанд холбох ажлыг хийж гүйцэтгэн шинээр суурьшлын бүс байгуулах ажлыг эхлүүлсэн. Дээрх суурьшлын бүсэд "Мандах наран-5" орон сууцны хороолол, "Саран хөхөө" театрын барилга, төвлөрсөн хангамж бүхий амины орон сууцны хороолол, төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор, Ерөнхий боловсролын сургууль зэрэг барилга бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн, ажлууд эхэлсэн.
231	6.1.1. Орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	231. "Хашаандаа сайхан амьдаръя" санаачлагын хүрээнд амины орон сууц, гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр хийх	2022	Төвлөр-сөн шугам сүлжээнд холбогдох амины орон сууц, гэр хорооллын айл өрхийн тоо	30	766,1 ОНТ, ОНХС	Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн 516.5 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 1-р багийн гэр хорооллын гудамжаар Ш90мм голчтой 412м HDPE цэвэр усан хангамжийн шугам, Ш150ммч200мм голчтой 740м бохир усны шугам татах, 6-р багийн Жанчивын гудамжинд ф90 мм-ийн голчтой 350м цэвэр усны шугам татах, 8-р багийн Үзүүрийн 11-р гудамжинд ф90 мм-ийн голчтой 403м цэвэр усны төв шугам татах, 4-р багийн гэр хороололд ф90 мм-ийн голчтой 490м цэвэр усны шугам татах ажлууд тус тус хийгдэж бүрэн дууссан. Сайншанд суманд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийн зөвшөөрлийг 114 иргэнд олгож 63 иргэнд, Замын-Үүд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 249.6 сая төгрөгийн

						санхүүжилтээр Сүлд багийн 11 болон 12 дугаар хэсэгт 730м бохир усны төвийн шугам сүлжээ татах ажлыг “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ гүйцэтгэж, 65 айл өрхөд, Айраг суманд 3 айл, 4 аж ахуйн нэгж, Дэлгэрэх суманд 3 айл, Өргөн суманд 5 айл, Хатанбулаг суманд 20 айл 3 аж ахуйн нэгж , Хөвсгөл суманд 5 аж ахуйн нэгж тус тус төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ -94,5						